



Co-funded by
the European Union

switchasia
PROGRAMME



CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

СУДАЛГААНЫ ТАЙЛАН




“Дулаан шийдэл” төслийн суурь судалгаа



2019





АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	4
ТАЛАРХАЛ	8
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	9
ОРШИЛ	10
Үндэслэл.....	10
Зорилго ба хамрах хүрээ.....	11
Тайлангийн бүтэц.....	12
1. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	13
Баримт бичгийн судалгаа ба хэрэглэгдэхүүн.....	13
1.1. Мэдээлэл цуглуулалт	14
1.2.1 Тоон судалгааны мэдээлэл цуглуулалт.....	14
1.2.2 Чанарын судалгааны мэдээлэл цуглуулалт.....	17
1.2. Шинжилгээ	19
2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ ӨРХҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ.....	21
2.1. Ярилцлага өгөгчийн мэдээлэл.....	21
2.2. Өрхийн мэдээлэл.....	21
2.3. Өрхийн гишүүдийн нийгмийн байдал.....	22
3. АГААРЫН БОХИРДОЛ БА СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА	26
3.1. Агаарын бохирдлын талаарх мэдлэг, хандлага.....	26
3.2. Дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлага	31
4. ӨРХИЙН САНХҮҮГИЙН ЧАДАМЖ	36
4.1. Өрхийн орлого ба зардал	36
4.1.1 Өрхийн орлого	36
4.1.2 Өрхийн зардал.....	42
4.2. Өрхийн хадгаламж ба зээл	50
4.2.1 Өрхийн хадгаламж.....	50
4.2.2 Өрхийн зээл.....	52
4.3. Өрхийн өмч хөрөнгө ба хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөө.....	55
4.3.1 Өрхийн өмч хөрөнгө	55

4.3.2	Өрхийн хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөө	57
5.	ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ	58
5.1.	Сууцны насжилт, зохион байгуулалт, материал	58
5.1.1	Сууцны насжилт	58
5.1.2	Сууцны хэмжээ ба зохион байгуулалт	58
5.1.3	Сууцны бүтэц	60
5.1.4	Сууцыг барьсан этгээд	61
5.2.	Сууцны дулаалга ба дулаан алдагдал	62
5.2.1	Сууцны дулаалга	62
5.2.2	Сууцны дулаан алдагдал	65
5.3.	Халаалт, цэвэр ба бохир ус	68
5.3.1	Халаалт	68
5.3.2	Цэвэр ба бохир ус	70
6.	ӨРХИЙН СУУЦНЫ ЦААШДЫН СОНИРХОЛ	72
6.1.	Сууцны цаашдын төлөвлөгөө	72
6.2.	Дулаан алдагдлыг бууруулахад авах арга хэмжээ	73
6.3.	Санхүүгийн боломж, сонирхол	76
	ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	79
	ХАВСРАЛТ	87
1.	Түүвэр судалгааны асуумж	87
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	99

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эх олонлог ба түүврийн хэмжээ, байршлаар.....	15
Хүснэгт 2. Ярилцлага өгөгчдийн хүн амзүйн зарим үзүүлэлт (n=416).....	21
Хүснэгт 3. Өрхийн хүн амзүйн зарим үзүүлэлт (n=1002)	22
Хүснэгт 4. Гэртээ дулаан өвөлжиж байгаа байдал болон нүүрсний дундаж хэрэглээ, дундаж галлагааны тоо	34
Хүснэгт 5. Өрхийн сарын дундаж орлогын ангилал.....	36
Хүснэгт 6. Өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт ба өрхийн ажил эрхэлдэг гишүүдийн тоо.....	38
Хүснэгт 7. Өрхийн түлээ, нүүрсний дундаж хэрэглээ	45
Хүснэгт 8. Цахилгааны зардал ба өрхийн сууцны хэмжээ.....	49
Хүснэгт 9. Зардлын төрлүүд ба гэр бүлийн төрлүүд	49
Хүснэгт 10. Сууцны дундаж насжилт, сууцны ханын төрөл ба өрхийн орлогын ангиллаар, жилээр.....	58
Хүснэгт 11. Нэг өрөөтэй сууцны шинжүүд (n=226) болон нийтлэг сууцны план зураг	59
Хүснэгт 12. Нэгээс дээш өрөөтэй сууцны шинжүүд (n=190) болон нийтлэг сууцны план зураг.....	60
Хүснэгт 13. Тодорхойлсон техникийн шийдлүүд ба иргэдийн сонголт хийх эрэмбэ...	76
Хүснэгт 14. Тодорхойлсон техникийн шийдлүүд ба иргэдийн сонголт хийх эрэмбэ...	79

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. СОП төслийн зорилго, үйл ажиллагаа, хүрэх үр дүн	11
Зураг 2. Суурь судалгааны ажлын хүрээ.....	12
Зураг 3. Суурь судалгааны үе шатууд ба үе шат бүрд хийгдсэн ажлууд, үр дүн	13
Зураг 4. Түүвэр судалгаанд оролцсон өрхүүдийн байршил (GPS), дүүрэг, хороо бүрээр...	16
Зураг 5. Мэдээллийн чанарын хяналт	17
Зураг 6. Фокус бүлгийн ярилцлагад ашигласан аргууд.....	18
Зураг 7. Сүхбаатар дүүргийн зорилтот өрхүүдийн дунд зохон байгуулсан ФБЯ: 2019 оны 2 сарын 16, Нийт оролцогчид: 13 хүн.....	18
Зураг 8. Сонгинохайрхан дүүргийн зорилтот өрхүүдийн дунд зохон байгуулсан ФБЯ:2019 оны 2 сарын 17, Нийт оролцогчид: 18 хүн.....	18
Зураг 9. Өрхийн ам бүлийн тооны бүлэглэлт (n=416)	21
Зураг 10. Гэр бүлийн төрөл (n=416)	22
Зураг 11. Өрхийн шийдвэр гаргагч (n=651).....	22
Зураг 12. Нийт насанд хүрсэн гишүүдийн боловсролын түвшин (n=1002).....	23
Зураг 13. Өрхийн тэргүүний боловсролын түвшин (n=389)	23
Зураг 14. Өрхийн тэргүүний боловсролын түвшин ба өрхийн орлогын ангилал (n=389)...	23
Зураг 15. Нийт насанд хүрсэн гишүүдийн сүүлийн 12 сарын ажил эрхлэлтийн байдал (n=1002).....	24
Зураг 16. Өрхийн тэргүүний сүүлийн 12 сарын ажил эрхлэлтийн байдал (n=389)	24
Зураг 17. Нийт насанд хүрсэн гишүүдийн ажил эрхэлдэг салбар (n=662)	25
Зураг 18. Өрхийн тэргүүний ажил эрхэлдэг салбар (n=389).....	25

Зураг 19. Нийт насанд хүрсэн гишүүдийн нийгмийн даатгал төлөлт, ажил эрхлэлтийн байдлаар	25
Зураг 20. Агаарын бохирдлын талаарх мэдлэгийг тодорхойлох хүрээ.....	26
Зураг 21. АЧИ-ийн талаар сонссон эсэх, АЧИ-ийн ягаан өнгөний тэмдэглэгээний талаарх ойлголт (n=416)	26
Зураг 22. Агаарын бохирдлын гол эх үүсвэрийн талаарх мэдлэг (n=416)	27
Зураг 23. Агаарын бохирдлын хүний эрхтэн тогтолцоонд үзүүлэх хор нөлөөний талаарх мэдлэг (n=416)	28
Зураг 24. Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалахын тулд хийдэг зүйлс, нийт хариултын тоогоор (n=660).....	28
Зураг 25. Агаарын бохирдлоос үүдэн өрхөд учирч буй хохирол (n=416).....	29
Зураг 26 Гэр хорооллын амины сууцтай өрхүүдийн агаарын бохирдлыг бууруулахад тохирох арга (n=416)	30
Зураг 27 Гэр хорооллын амины сууцтай өрхүүдийн агаарын бохирдлыг бууруулахад тохирох арга ба орлогын ангилал (n=416)	30
Зураг 28. Гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулахад нэн тэргүүнд хийх шаардлагатай зүйлс (n=460 санал)	30
Зураг 29. Дулаан алдагдлын талаарх мэдлэгийг тодорхойлох хүрээ	31
Зураг 30. Гэрээ дулаан байлгахад хийх зүйлс (n=549)	31
Зураг 31. Гэрээ дулаан байлгахад хийх зүйлс ба орлогын ангилал, хийх зүйлсээр (n=549)	32
Зураг 32. Гэрээ дулаан байлгахад хийх зүйлс ба агаарын бохирдлыг бууруулахад тохирох арга.....	32
Зураг 33. Сууцаа огт дулаалаагүй өрхүүдийн гэрээ дулаан байлгахад хийх зүйлс (n=189)	32
Зураг 34. Сууцаа огт дулаалаагүй өрхүүдийн орлогын ангилал (n=189)	33
Зураг 35. Сууцаа дулаалсан байдал (n=300)	33
Зураг 36. Гэртээ тав тухтай, дулаахан байгаа эсэх (n=416)	33
Зураг 37. Сууцаа дулаалсан байдал (n=300)	34
Зураг 38. Өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт, нийт түүвэрээр, дүүргээр	37
Зураг 39. Өрхийн сарын дундаж орлого ба өрхийн дундаж ажил эрхэлдэг гишүүдийн тооны хамаарал	38
Зураг 40. Өрхийн орлогын ангилал ба гэр бүлийн төрөл.....	39
Зураг 41. Өрхийн орлогын хүрэлцээ (n=416)	39
Зураг 42. Өрхийн насанд хүрсэн гишүүдийн орлогын төрөл (n=999)	40
Зураг 43. Өрхийн орлогын төрөл (n=416)	40
Зураг 44. Өрхийн орлогын төрөл, орлогын ангиллаар	41
Зураг 45. Өрхийн гишүүдийн орлогын эх үүсвэр, орлогын төрлөөр.....	42
Зураг 46. Боловсрол, сургалтын зардлын бүлэглэлт, жилээр (n=174)	43
Зураг 47. Боловсрол, сургалтын зардал гаргадаг эсэх, орлогын ангиллаар (n=416).....	43
Зураг 48. Боловсрол, сургалтын зардлын бүлэглэлт, орлогын ангиллаар (n=174).....	43
Зураг 49. Өрхийн эрүүл мэндийн сарын зардал, төгрөгөөр (n=392)	44
Зураг 50. Эрүүл мэндийн зардлын бүлэглэлт, орлогын ангиллаар (n=392).....	44
Зураг 51. Амьсгалын замын өвчний зардлын бүлэглэлт (n=384) ба тодорхойлох статистик	45
Зураг 52. Зүрх судасны өвчний зардлын бүлэглэлт (n=101) ба тодорхойлох статистик	45
Зураг 53. Өрхийн сарын түлээний зардал (n=235) ба тодорхойлох статистик.....	46
Зураг 54. Өрхийн жилийн түлээний зардал (n=159) ба тодорхойлох статистик.....	46
Зураг 55. Өрхийн сарын нүүрсний зардал (n=163) ба тодорхойлох статистик	47
Зураг 56. Өрхийн жилийн нүүрсний зардал (n=237) ба тодорхойлох статистик.....	47

Зураг 57. Өрхийн сарын цахилгааны төлбөрийн бүлэглэлт, халаалтын ба халаалтын бус улирлаар (n=416).....	48
Зураг 58. Халаалтын улирлын цахилгааны зардлын бүлэглэлт, орлогын ангиллаар (n=392)	48
Зураг 59. Өрхийн хадгаламж (n=461).....	51
Зураг 60. Өрхийн хадгаламжийн бусад мэдээлэл (n=84)	51
Зураг 61. Өрхийн зээлийн төрөл (n=461)	52
Зураг 62. Өрхийн зээлийн хэмжээ (n=135).....	53
Зураг 63. Зээлийн хугацаа (n=135)	53
Зураг 64. Зээлийн хугацаа (n=135)	53
Зураг 65. Өрхийн зээлийн эргэн төлөлт (n=135).....	54
Зураг 66. Өрхийн зээлийн зориулалт (n=170)	55
Зураг 67.Автомашинтай өрхийн бүлэглэлт, автомашины тоогоор (n=226)	55
Зураг 68.Автомашинны төрөл (n=252).....	55
Зураг 69.Газрын хэмжээ (n=416).....	56
Зураг 70.Өрхийн сууцны өмчлөл ба ҮХХ-ийн гэрчилгээтэй эсэх (n=416).....	57
Зураг 71.Өрхийн сууцны өмчлөл ба барьцаанд байгаа эсэх (n=416)	57
Зураг 72. Өрхийн ойрын ирээдүйд хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (n=416)	57
Зураг 73. Барилга сууцанд хөрөнгө оруулахаар төлөвлөсөн хугацаа (n=101)	57
Зураг 74. Сууцны насжилт (n=416)	58
Зураг 75. Сууцны хэмжээ (n=416)	59
Зураг 76. Сууцны ханын материал ба ба дээврийн хэлбэр (n=416)	61
Зураг 77. Сууцны ханын материал ба ба шалны үндсэн материал (n=416)	61
Зураг 78. Сууцыг барьсан этгээд ба орлогын ангилал (n=298*)	62
Зураг 79. Сууцыг барьсан этгээд ба сууцны ханын төрөл (n=299*)	62
Зураг 80. Дулаалга хийсэн эсэх, байшингийн ханын төрлөөр (n=416).....	63
Зураг 81. Дулаалгын материалыг худалдан авахад нөлөөлсөн хүчин зүйлс (n=172*) .	63
Зураг 82.Өрхүүдийн хийсэн дулаалгын чанартаа өгсөн үнэлгээ (n=130)	63
Зураг 83. Дулаалга хийхэд тулгардаг бэрхшээлүүд (n=674)	64
Зураг 84. Дулаалгыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх сонирхол(n=416).....	64
Зураг 85. Сууцны дулаан алдаж байгаа газрууд (n=427).....	65
Зураг 86. Сууцны дулаан алдаж байгаа газрууд ба байшингийн ханын төрөл (n=427)	66
Зураг 87. Дулаалга хийсэн газрууд (n=298).....	67
Зураг 88. Дулаалга хийсэн газрууд ба ашигласан материал (n=298)	67
Зураг 89. Дулаалгын материал авсан газар (n=298)	67
Зураг 90. Өрхийн зуухны төрөл (n=416)	68
Зураг 91. Өвлийн улиралд хоногт галладаг тоо (n=416)	68
Зураг 92. Галлагааны тоо ба дулаалга хийсэн эсэх (n=416)	69
Зураг 93. Зуухны төрөл ба халаах хэрэгсэл (n=416)	70
Зураг 94. Ундны эх үүсвэр (n=416)	70
Зураг 95. Өрхийн хоногийн унд болон ахуйн хэрэглээний усны хэмжээ (n=416)	70
Зураг 96. Усанд ордог газар (n=416)	71
Зураг 97. Бохир усны зайлуулалт (n=416).....	71
Зураг 98. Одоогийн амьдарч буй сууцаа цаашид хэрхэх вэ? (n=416)	72
Зураг 99. Төлөвлөж буй он, %	73
Зураг 100 Дулаан алдагдлыг бууруулах авах арга хэмжээ #1	73
Зураг 101 Дулаан алдагдлыг бууруулах авах арга хэмжээ #2	73
Зураг 102 Санхүүжилтийг хэрхэн шийдэх (n=416).....	77
Зураг 103 Дулаалганд мөнгө зарцуулах эсэх (n=416).....	78
Зураг 104 Зарцуулах боломжтой мөнгөн дүн.....	78

ТАЛАРХАЛ

МИРИМ Консалтант ХХК-ийн судалгааны баг Пипл Ин Нийд ОУТББ-ын захиалгаар Улаанбаатар хотын төлөвлөгдөөгүй бүсэд тогтвортой эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барихад зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх төслийн суурь судалгааг 2018 оны 12-р сараас 2019 оны 3-р сарын хооронд амжилттай хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны ажлыг хэрэгжүүлэхэд Пипл Ин Нийд ОУТББ, ЖЭРЭС ОУТББ, ШУТИС-ийн БЭХХТ-ийн хамт олны туслалцаа маш их байсан бөгөөд тэр дундаа судалгааны ажлын явцад үнэтэй зөвлөгөө, удирдамж, мэдээллээр хангасан Пипл Ин Нийд ОУТББ-ын төслийн менежер М. Тамир, төслийн мэргэжилтэн М.Мөнхсаруул, ЖЕРЕС ОУТББ-ын санхүүгийн мэргэжилтэн Т.Уламбаяр, техникийн зохицуулагч Б.Саруул, санхүүгийн зуучлал хариуцсан мэргэжилтэн Н.Аззаяа, ШУТИС-ийн БЭХХТ-ийн барилгын инженер Ж.Ганхуяг, эрчим хүч хэмнэлтийн зөвлөх П.Мандахнаран нарт тусгайлан талархал илэрхийлье.

Тоон болон чанарын судалгаанд идэвхтэй оролцож, өрхийн санхүүгийн байдал, орон сууцны нөхцөл, дулаан алдагдал, цаашдын хүсэл сонирхлын талаар ярилцсан зорилтот өрхийн гишүүдэд, мэдээлэл цуглуулах ажлыг чадварлаг гүйцэтгэсэн талбарын судлаачиддаа талархал илэрхийлье.

Уг судалгааг МИРИМ Консалтант ХХК-ийн судалгааны үндсэн ба туслах баг хийж гүйцэтгэлээ. Үндсэн багт Д. Бямбасүрэн (тоон судалгааны зөвлөх), Л. Цэлмэгсайхан (чанарын судалгааны зөвлөх), Ц.Бадамсүрэн (судалгааны зохицуулагч) нар ажиллаа.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БО	Бага орлоготой
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БЭХХТ	Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв
ГМЯ	Гол мэдээлэгчийн ярилцлага
ГХАОЗТ	Гэр хорооллын амьдрах орчны зураглалын төв
ДДО	Дунджаас дээгүүр орлоготой
ДО	Дундаж орлоготой
МБҮА	Монголын барилгын үндэсний ассоциаци
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ӨНЭЗС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ПИН	Пипл Ин Нийд
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ФБХ	Фокус бүлгийн хэлэлцүүлэг
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль

ОРШИЛ

Үндэслэл

2017 оны эцсийн байдлаар Нийслэлийн 386,218 өрхийн 55.5 хувь нь гэр хороололд амьдарч байна.¹ Хэдийгээр НЗДТГ-аас гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлыг 2013 оноос эхлэн санаачлан хэрэгжүүлж байгаа ч гэр хорооллын өрхийн тоо төдийлөн буурахгүй байна. Гэр хорооллын өрхийн тоо буурахгүй байгаагийн гол шалтгаан нь орон нутгаас шилжин ирэгсдийн тоо шилжин явагсдын тооноос даруй 2-3 дахин их² байгаатай холбоотой бөгөөд шилжин ирэгсдийн олонх нь гэр хороололд шингэж байна.

Улаанбаатар хотын гэр хороололд дэд бүтэц хөгжөөгүйгээс өрхүүд өвлийн улиралд халаалтдаа голдуу сайжруулаагүй нүүрс хэрэглэж байна. 2017 оны ӨНЭЗС³-аас үзэхэд Улаанбаатар хотын нэг өрх жилд дунджаар 66 уут түлээний мод, 3.3 тонн нүүрсийг түлжээ. Цаашлаад үр ашиг муутай халаалтын систем, орлогын хүрэлцээгүй байдал, байшингийн дулаан алдагдал зэрэг нь түлшний хэрэглээг нэмэгдүүлэх гол шалтгаан болж байна. Энэ нь эргээд агаар мандал, газрын хөрс, орчноо бохирдуулахын сацуу Нийслэлийн нийт иргэдийн эрүүл мэндийг ноцтойгоор хохироож байгаа юм.

Гэр хорооллын байшингуудын 90 гаруй хувь нь инженерийн тооцоололгүй, зураг төсөлгүй, стандартын бус ахуйн аргаар баригдсан бөгөөд гал түймэрт өртөмтгий, дулаан алдагдал ихтэй аж (БХБЯ, 2017). Түүнчлэн иргэд байшингаа ихэвчлэн өөрсдөө барьсан байдаг бөгөөд байшингаа стандартын дагуу хэрхэн сайжруулах талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байна.

Европын Холбоо болон “Abbe Pierre” сангийн санхүүжилтээр ЖЭРЭС ОУТББ, ПИН ОУТББ, ГХАОЗТ, МБУА, БЭХХТ нар хамтран Улаанбаатар хотын төлөвлөгдөөгүй бүсэд тогтвортой эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барихад зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх төслийг⁴ 2018 оны 1-р сараас эхлэн дөрвөн жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Энэ төсөл нь амины сууцанд оршин суугчдын эрчим хүчний зүй зохистой хэрэглээг дадал зуршил болгон хэвшүүлэх замаар Монгол улсын хүн амын эрүүл мэндийн нөхцөл байдлыг сайжруулах үндсэн зорилготой.

Ингэхдээ орон нутгийн засаг захиргаа болон бусад байгууллагууд, гэр хорооллын өрхүүд, барилгын салбарын жижиг, дунд бизнесүүдэд дэмжлэг үзүүлэх замаар УБ хотын нийт хүн амын эрүүл мэндэд шууд болон шууд бус ашиг тус үзүүлэхээр зорьж байна. Төслийн зорилтот бүлэг нь халаалтын зардлаа бууруулах, гэр орныхоо тав тухтай байдлыг сайжруулах хүсэл сонирхолтой гэр хорооллын өрхүүд бөгөөд үүнээс амьжиргааны эмзэг төвшинд хамаарах болон өрх толгойлсон эмэгтэйчүүдэд илүүтэй анхаарал хандуулах аж.

¹ Нийслэлийн статистикийн газар


² 2017 онд Улаанбаатараас шилжин явагсдын тоо шилжин ирэгсдийн тооноос анх удаа давсан үзүүлэлттэй гарчээ. Тодруулбал шилжин явагсдын тоо шилжин ирэгсдийн тооноос 1069 хүнээр давсан байна.

³ ӨНЭЗС нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индексэд ашигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг хэрэглээний аргаар тооцоход шаардлагатай мэдээлэл гаргах зорилготой улсын хэмжээний судалгаа юм. 2017 оны ӨНЭЗС-д Улаанбаатар хотоос 3562 өрх хамрагджээ.

⁴ Цаашид төслийн нэрийг СОП гэж товчилно.

Төслийн үндсэн зорилгын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж, үр дүнд хүрэхээр хүлээгдэж байна.

Зураг 1. СОП төслийн зорилго, үйл ажиллагаа, хүрэх үр дүн



Эх сурвалж: СОП төслийн баримт материал


Зорилго ба хамрах хүрээ

Суурь судалгааны үндсэн зорилго нь СОП төслийн суурь мэдээллийг тодорхойлохын сацуу зорилтот хороодын өрхүүдийн санхүүгийн нөхцөл байдал, чадамж, сууцны цаашдын хэрэгцээг тодорхойлох явдал юм. Энэхүү үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Зорилтот хороодын өрхүүдийн агаарын бохирдол ба сууцны дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлох,
- Зорилтот хороодын өрхүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөлийг тодорхойлох,
- Зорилтот хороодын өрхүүдийн сууцны одоогийн нөхцөл байдал ба цаашдын хэрэгцээг тодорхойлох.

Уг судалгааг баримт бичиг, тоон ба чанарын мэдээлэлд үндэслэн боловсрууллаа. Энэ хүрээнд зорилтот хороодын өрхүүдийн дунд түүвэр судалгаа хийж, гарсан үр дүнг зорилтот өрхүүдийг хамруулсан фокус бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнтэй нэгтгэн дүгнэлээ. Судалгааны ажлын хүрээг доорх зурагт тоймлон үзүүлэв.

Зураг 2. Суурь судалгааны ажлын хүрээ



Тайлангийн бүтэц

Энэхүү судалгааны тайлан үндсэн зургаан бүлгээс бүрдэнэ. *Нэгдүгээр бүлэгт* суурь судалгаанд ашигласан аргазүйг авч үзлээ. Уг бүлгийн эхний хэсэгт судалгааны дизайн ба баримт бичгийн судалгааны үр дүнг тоймлосон бол дараагийн хэсэгт түүвэр судалгааны аргазүйг авч үзлээ. Тодруулбал хэрэглэгдэхүүн, түүвэрлэлт, мэдээлэл цуглуулалт, дүн шинжилгээнд анхаарах зүйлс зэргийг хэлэлцлээ. Уг бүлгийн сүүлчийн хэсэгт ФБХ-ийн аргазүй, зохион байгуулалтыг тоймлолоо.

Хоёрдугаар бүлэгт түүвэр судалгаанд оролцсон өрхүүдийн хүн амзүйн мэдээллийг тэдний нийгэм, эдийн засгийн хэв шинжээр нь тусган харууллаа. *Гуравдугаар бүлэгт* судалгаанд оролцогчдын агаарын бохирдол ба сууцны дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлагыг тодорхойллоо. *Дөрөвдүгээр бүлэгт* өрхийн санхүүгийн чадамжийг авч үзэв. Өрхийн санхүүгийн чадамжийг өрхийн орлого ба зардал, хадгаламж ба зээл, өмч хөрөнгийн тусламжтайгаар тодорхойлохын зэрэгцээ өрхийн хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөөг авч үзлээ.

Тавдугаар бүлэгт өрхийн одоогийн сууцны нөхцөл байдлыг авч үзлээ. Сууцны насжилт, бүтэц, зохион байгуулалт, сууцны дулаалга, дулаан алдагдал, халаалт, цэвэр ба бохир усны талаар энэ бүлэгт хэлэлцэнэ. *Зургаадугаар бүлэгт* өрхийн сууцны цаашдын сонирхол, төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй авч үзэв. Эцэст нь судалгааны гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэж гаргалаа.

1. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Суурь судалгаа гурван шатнаас бүрдэнэ. Үүнд: (i) баримт бичгийн тойм судалгааны үр дүнд суурилан судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах; (ii) Зорилтот хороодын өрхүүдээс тоон болон чанарын мэдээлэл цуглуулах; (iii) Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлан боловсруулах гэсэн үе шатуудыг хамарна. Доорх зурагт судалгааны үе шатууд, тэдгээрийн хүрээнд хийгдсэн ажлуудыг нэгтгэн харууллаа.

Зураг 3. Суурь судалгааны үе шатууд ба үе шат бүрд хийгдсэн ажлууд, үр дүн



Баримт бичгийн судалгаа ба хэрэглэгдэхүүн

Судалгааны нэгдүгээр шатанд МИРИМ-ийн судалгааны баг түүвэр судалгаа болон ФБХ-ийн судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах зорилгоор төслийн холбогдох баримт бичгүүдтэй танилцлаа. Үүнд:

- Төслийн багийн зохион байгуулсан ФБХ ба ГМЯ-ын тэмдэглэл ба үйл ажиллагааны тайлан, 2018
- Төслийн багийн боловсруулсан холбоотой судалгаа, төсөл, хөтөлбөрүүдийн тоймууд. Үүнд: Гэр хорооллын нийгмийн судалгаа, гэр хорооллын дахин төлөвлөлт, орлогод нийцсэн орон сууц, сууцны эрчим хүчний хэмнэлт, хотын судалгаа зэрэг сэдвүүдийг хамарлаа.

- Зорилтот хороодын өрхүүдийн статистик мэдээлэл
- “SWITCH Asia II” төслийн хүйсийн хувьд баримтлах зарчмын баримт бичиг

Түүнчлэн уг төслийн хэрэгжүүлэгчид болох ПИН, ЖЕРЕС, БЭХХТ-ийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх уулзалтыг нийт 7 удаа хийсэн. Баримт бичгийн тойм, зөвлөлдөх уулзалтуудын үр дүнд үндэслэн түүвэр судалгааны асуумжийг боловсрууллаа.

Зорилтот хороодын өрхүүдээс авах түүвэр судалгааны асуумж⁵: Энэхүү асуумж нь бүтэцлэгдсэн, нийт 4 хэсэг, 76 асуулттай. Асуумжийн эхний хэсэгт өрхийн ерөнхий мэдээллийг багтаасан бол дараагийн хэсэгт тэдгээрийн агаарын бохирдол ба сууцны дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх асуултуудыг орууллаа. Гурав дахь хэсэг нь өрхийн санхүүгийн чадамжийг тодорхойлохыг зорьсон бөгөөд энэ хэсэгт өрхийн санхүүгийн орлого ба зардал, хадгаламж ба зээл, өмч хөрөнгө, хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөөтэй холбоотой асуултуудыг багтаасан. Асуумжийн сүүлчийн хэсэгт өрхийн сууцны нөхцөл байдлыг сууцны бүтэц, зохион байгуулалт, хийц, дулаалга, дулаан алдагдлаар нь тодорхойлохын зэрэгцээ сууцны цаашдын хүсэл сонирхлыг асуусан. Түүнчлэн судалгаанд оролцсон өрхүүдийн сууцны гадна зураг, цонх ба ханын уулзварын зураг, зуух халаас хэрэгслийн фото зургийг авч баталгаажууллаа.

Асуумж боловсруулах хүрээнд МИРИМ-ийн баг дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Асуумж боловсруулах уулзалтыг захиалагч талтай хийсэн.
- Асуумжийн анхны нооргийг боловсруулж, захиалагчид хүргүүлсэн.
- Асуумжид оруулсан өөрчлөлтүүдтэй холбоотойгоор захиалагч байгууллагатай уулзалт хийж, асуулгыг сайжруулсан.
- Асуумжийг шалгах зорилгоор 12 өрхийг хамруулан туршилт судалгаа хийсэн.
- Туршилтын судалгааны үр дүнд суурилан асуумжийг дахин сайжруулсан.
- Асуумжийг эцэслэсний дараа таблетад зориулсан асуумжийн формыг үүсгэх зэрэг ажлыг хэрэгжүүлэв.

1.1. Мэдээлэл цуглуулалт

1.2.1 Тоон судалгааны мэдээлэл цуглуулалт

Түүвэрлэлт

Түүврийн хамрах хүрээ: Сүхбаатар дүүргийн 15, 16, 17, 18-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 11, 28, 31-р хорооны амины сууцтай өрхүүдийг хамруулав.

Түүврийн хэмжээ, төлөөлөх чадвар: 2018 оны 4-р улирлын байдлаар эдгээр 11 хороонд нийтдээ 15,674 амины сууцтай өрхүүд амьдарч байгаас 384 өрхийг санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамруулахаар түүвэрлэн авлаа. Судалгаанд хамрагдах өрхийн тоог дараах томъёогоор тооцов.

$$n = \frac{Z^2 p(1-p)}{C^2}$$

Энд: n-түүврийн хэмжээ, Z-итгэх түвшин (95% -ийн итгэх түвшний хувьд Z=1.96), p-сонирхож буй хувьсагчийн илрэх магадлал, C-алдааны хязгаар (итгэх завсар). Түүврийн

⁵ Хавсралтаас үзнэ үү.

алдааны хязгаарыг $\pm 4.9\%$, итгэх түвшинг 95% байхаар сонгов. Гэхдээ судалгааны явцад 32 өрхийн мэдээллийг нэмэлтээр цуглуулж, нийт 416 өрх судалгаанд хамрагдлаа.

Судалгаанд хамрагдах нийт өрхийн тоог сонгосны дараа хороо тус бүрээс хэдэн өрхийг судалгаанд оролцуулахыг тодорхойлох шаардлагатай бөгөөд үүнийг тооцохдоо давхраат санамсаргүй түүврийн аргыг ашиглав⁶. Тодорхой шалтгааны⁷ улмаас Сонгинохайрхан дүүргийн 9-р хорооны хувьд төлөвлөсөн түүврээс цөөн өрхөөс мэдээлэл цуглуулсан бол тус дүүргийн 10 ба 28-р хорооны хувьд төлөвлөснөөс илүү олон өрхөөс мэдээлэл цуглууллаа. Нийт түүврийн 71% нь Сонгинохайрхан дүүргийн өрхүүд, 29% нь Сүхбаатар дүүргийн өрхүүд байна.

Хүснэгт 1. Эх олонлог ба түүврийн хэмжээ, байршилаар

№	Байршил	Эх олонлог		Төлөвлөсөн түүвэр		Нэмэлт түүвэр	Нийт түүврийн хэмжээ
		Амины сууцтай өрхийн тоо ^(a)	Эх олонлогт эзлэх хувь	Түүврийн хэмжээ	Түүвэрт эзлэх хувь		
Сүхбаатар дүүрэг							
1	15-р хороо	768	5%	19	5%	-	19
2	16-р хороо	1602	10%	39	10%	1	40
3	17-р хороо	1121	7%	27	7%	-	27
4	18-р хороо	1436	9%	35	9%	-	35
Сонгинохайрхан дүүрэг							
5	7-р хороо	2722	17%	67	17%	1	68
6	8-р хороо	1269	8%	31	8%	-	31
7	9-р хороо	1200	8%	29	8%	-8	21
8	10-р хороо	1647	11%	42	11%	27	69
9	11-р хороо	1350	9%	33	9%	-	33
10	28-р хороо	996	6%	24	6%	11	35
11	31-р хороо	1563	10%	38	10%		38
	Нийт	15674	100%	384	100%	32	416

Тэмдэглэгээ: ^(a)- Нийслэлийн статистикийн хороо

Судалгаанд хамрагдах өрхийг сонгох: Хороо бүрээс тухайн нэг өрхийг сонгохдоо системчилсэн санамсаргүй түүврийн аргыг ашиглалаа. Системчилсэн санамсаргүй түүвэрлэлт дараах алхмын дагуу хийгдэв. Үүнд:

- Хороо тус бүрд алхмын хэмжээ буюу хэдэн өрх алгасаад тухайн өрхийг сонгох тоог $k=N/n$ гэж тодорхойлно. Энд: k -алхмын хэмжээ, N -тухайн хорооны нийт амины сууцтай өрхийн тоо, n -тухайн хорооны түүврийн хэмжээ юм.
- 1-ээс k хүртэлх тооноос санамсаргүйгээр нэг бүхэл тоо сонгож, түүвэрлэлтийг эхлүүлнэ. Үүний дараа k дахь өрх бүрийг сонгон авч түүврийг бүрдүүлнэ. Жишээлбэл, $k=10$ гэж гарсан гэе. Тэгвэл 1-ээс 10 хүртэлх тооноос санамсаргүйгээр нэг тоо буюу 3-г сонгоё. Жагсаалт дахь 3 дахь өрхөөс түүвэрлэлтийг эхэлж 10 дахь өрх бүрийг сонгоно. Иймд 3, 13, 23, 33 гэх мэтчилэн (n -г бүрдтэл) түүвэрт сонгогдоно.

⁶ Давхраат санамсаргүй түүврийн аргаар тухайн хорооны түүврийн хэмжээг тооцохдоо нийт түүврийн хэмжээг тухайн хорооны нийт эх олонлогт эзлэх хувь хэмжээгээр үржүүлж тооцно.

⁷ Мэдээлэл цуглуулах хэсгийн мэдээлэл цуглуулалтад үүссэн бэрхшээлүүдийг харна уу.

Уг түүвэрлэлтийн хувьд хороо бүрийн хувьд алхамын хэмжээ буюу түүвэрт хамрагдах өрх хоорондын зайг дээрх аргачлалын дагуу тооцож, дараах дүрмийн дагуу өрхүүдийг сонголоо.

1. Нэг гудамжнаас 2-3 сууцтай өрхийг санамсаргүйгээр сонгож, мэдээллийг авах,
2. Судалгаанд хамруулах хоёр өрхийн хоорондох зай хамгийн багадаа 10 сууцтай өрх байх,
3. Хэрвээ тухайн айл эзгүй, эсвэл сууцыг түрээслэн суудаг бол дараагийн сууцтай өрхөөс судалгааг авах.

Дараах зурагт судалгаанд оролцсон өрхүүдийн байршлыг⁸ хороо тус бүрээр нэгтгэн харуулав.

Зураг 4. Түүвэр судалгаанд оролцсон өрхүүдийн байршил (GPS), дүүрэг, хороо бүрээр



Ярилцлага өгөгчийг сонгох: Судалгаанд өрхийн тэргүүн, өрхийн тэргүүний эхнэр, байнгын хамт амьдардаг өрхийн шийдвэр гаргалтад оролцдог өрхийн насанд хүрсэн гишүүнийг оролцуулж, ярилцлага хийлээ. Түүнчлэн зарим тохиолдолд ярилцлага өгөгч тухайн асуултыг хариулж мэдэхгүй байвал өрхийн өөр гишүүнээс асуух замаар асуумжийг гүйцээлээ. Нийт ярилцлага өгөгчдийн 58% нь өрхийн тэргүүн, 28% нь эхнэр, 11% нь насанд хүрсэн хүүхэд, үлдсэн 3% нь өрхийн бусад гишүүд байв.

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа

Зорилтот өрхүүдийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2019 оны 1 сарын 5-ны өдрөөс 1-р сарын 15-ны хооронд зохион байгууллаа. Үндсэн судалгааг хэрэгжүүлэхийн өмнө талбарын судлаачдыг сургах, тэдгээрийг талбарт турших зэрэг ажлуудыг гүйцэтгэв. Сургалт болон туршилт судалгаанд нийт 15 талбарын судлаач, ПИН ОУТББ, ЖЭРЭС ОУТББ-ын төлөөлөл, МИРИМ-ийн судалгааны үндсэн багийн гишүүд оролцож, үндсэн судалгааны бэлтгэл ажлыг хангасан.

Талбарт ажиллах баг, асуумж, асуумжийн форм, бусад хэрэглэгдэхүүн бэлэн болмогц зорилтот хороодын өрхүүдээс судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлсэн. Судалгааны маршрут, ажлын төлөвлөгөө, багийн зохион байгуулалт зэргийг урьдчилан бэлдэж, төлөвлөлтийн дагуу зохион байгуулагдлаа. Гэхдээ мэдээлэл цуглуулах явцад тодорхой бэрхшээлүүд гарч байв. Үүнд:


⁸ Өрх бүрийн хувьд GPS-ээр нь харууллаа.

- *Хугацаа алдах*: Өдрийн цагаар айлууд эзгүй байх, эсвэл насанд хүрсэн хүнгүй байх, түүвэрлэлтийн дагуу шалгуурт нийцсэн өрх олдохгүй байх зэргээс шалтгаалан хугацаа алдсан.
- *Мэдээлэл өгөхөөс татгалзах*: Зарим айл судлаачийг гэртээ оруулахаас дургүйцэх, сарын орлого, хадгаламж, зээл зэрэг санхүүгийн мэдээллээ өгөхөөс татгалзах, сууцны фото зургийг авахуулахаас татгалзах зэрэг хүндрэлүүд гарсан.
- *Орчны болон цаг агаарын бэрхшээл*: Цаг агаарын болон гэр хорооллын алслагдсан бүсэд ажиллахтай холбоотой бусад хүндрэл судалгааны багт тулгарч байв.

Мэдээллийн хяналт ба мэдээллийн сан

Түүвэр судалгааны мэдээллийн санг дараах схемийн дагуу чанарын хяналт хийж, баталгаажууллаа.

Зураг 5. Мэдээллийн чанарын хяналт



Цугларсан мэдээлэлд чанарын хяналт хийхдээ дараах арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:

- ✓ Асуумж бүрийг бүрэн гүйцэд бөглөгдсөн эсэх, агуулгын хувьд үнэн зөв, логик уялдаатай бөглөгдсөн эсэхийг хянан баталгаажуулав.
- ✓ Нийт түүврийн 30%-д оролцогчтой утсаар холбогдон асуултын хариултуудыг эргэн нягтлав.
- ✓ Судалгааны мэдээллийн санд аналитик хяналт хийв.

Мэдээлэлд чанарын хяналт хийсний дараа цуглуулсан бүх мэдээллийг нэгтгэн цэвэрлэж судалгааны мэдээллийн санг үүсгэлээ.

1.2.2 Чанарын судалгааны мэдээлэл цуглуулалт

Асуулга судалгаагаар цугларсан мэдээлэлд нэмэлт тайлбарлал өгөх, түүн дотроо цаашдаа сууцаа засварлаж, өөрчлөлт хийхээр төлөвлөж буй өрхүүдийн санаа бодлыг гүнзгийрүүлэн судлах зорилгоор зорилтот бүлгийн хүн амын дунд фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан.

Фокус бүлгийн ярилцлагаар дараах асуудлуудыг тодруулсан. Үүнд:

- Тодорхойлсон техникийн шийдлүүдийн хувилбаруудаас иргэдийн чухалчилж буй хувилбаруудыг тодорхойллоо.
- Чухалчлах шийдвэр гаргалтад тухайн техникийн шийдлийн гадаад үзэмж, ая тухтай байдал, эрчим хүчний хэмнэлт, санал болгож буй үнэ зэрэг хүчин зүйлсийн үзүүлэх нөлөөг тодорхойллоо.
- Айл өрхүүд цахилгаан халаагуур бага ашиглаж байгаа шалтгаан, гол хүндрэл бэрхшээлийг тодруулсан.
- Айл өрхүүдийн утаагүй зуух (төслийн зуух) ашиглалт яагаад багасч байгааг тодруулсан.

Зураг 6. Фокус бүлгийн ярилцлагад ашигласан аргууд

Картын арга

Н-хүснэгтийн арга

Хамрах хүрээ: Фокус бүлгийн ярилцлагад зорилтот хоёр дүүргийн айл өрхийн төлөөлөл 30 хүнийг хамруулсан. Өрхийн шийдвэр гаргалтад голлох үүрэгтэй гишүүд болох эхнэр, нөхрийн аль аль төлөөллийг урин, хүйсийн харьцааг тэнцвэртэй холимог байдлаар зохион байгуулсан. Оролцоог өндөр байлгах үүднээс бүлгийн ярилцлагыг амралтын өдрүүдэд, зорилтот хорооны төв хэсгийн байршилд зохион байгуулсан.

Зураг 7. Сүхбаатар дүүргийн зорилтот өрхүүдийн дунд зохон байгуулсан ФБЯ: 2019 оны 2 сарын 16, Нийт оролцогчид: 13 хүн



Зураг 8. Сонгинохайрхан дүүргийн зорилтот өрхүүдийн дунд зохон байгуулсан ФБЯ: 2019 оны 2 сарын 17, Нийт оролцогчид: 18 хүн



Зохион байгуулалт: Фокус бүлгийн зохион байгуулалтад СОП төслийн консерциумын гишүүн байгууллагууд дараах байдлаар оролцлоо.

1. ПИН: СОП төслийн талаар танилцуулга бүлгийн ярилцлагын эхэнд өгч, ярилцлагын явцад оролцогчдоос ирсэн зарим тодруулгад хариу өгч, мөн нэмэлт гүнзгийрүүлэх асуултыг асууж байв.
2. БЭХХТ: Тодорхойлсон техникийн шийдлийн танилцуулгыг илтгэл хэлбэрээр, макетын хамт танилцуулсан. Оролцогчдоос ирсэн барилгын материал болон дулаалгын арга ажиллагааны талаар асуултад тодруулга өгч байв.
3. МИРИМ Консалтант: Фокус бүлгийн ярилцлагыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, чиглүүлэн ажиллав.

Эхний өдрийн Сүхбаатар дүүргийн зорилтот хүн амын дунд хийсэн бүлгийн ярилцлагын дараа гишүүн байгууллагууд өдрийн үйл явцыг дүгнэн уулзаж, дараагийн өдрийн ярилцлагыг сайжруулах тодорхой саналуудыг ярилцав.

Энэ удаа хийгдсэн хоёр фокус бүлгийн ярилцлагын мэдээлэлд нэмэлтээр төслийн консерциумаас 2018 оны 10-11 дүгээр сард хийсэн фокус бүлгийн ярилцлага болон гол мэдээлэгчийн ярилцлагын тэмдэглэл, тайлантай танилцаж, нэгтгэн дүгнэн, энэхүү тайлангийн холбогдох хэсгүүдэд орууллаа.

Консерциумын зохион байгуулсан гол мэдээлэгчийн ярилцлагын хүрээнд: Зорилтот хороодын ажилтнууд, гол нөлөө бүхий оршин суугчид, олон нийтийн бүлгийн гишүүдээс нийгэм эдийн засгийн нөхцөл байдал болон барилгын дулаалгын чиглэлээр одоо хэрэгжиж буй болон өнгөрсөн хугацаанд хэрэгжиж байсан төслүүдийн сургамж, туршлагын талаар мэдээлэл олж авах зорилготойгоор уг ярилцлагыг зохион байгуулжээ. Уг ярилцлагыг 2018 оны 10 сарын 11-нээс 17-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 9, 10, 16, 28-р хороо болон Сүхбаатар дүүргийн 12, 16, 17, 18-р хорооны олон нийтийн төлөөлөл, хорооны засаг дарга, нийгмийн ажилтан болон хэсгийн ахлагч нарын нийт 15 төлөөлөлтэй уулзаж ярилцсан байна.

Консерциумын зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын хүрээнд: Төслийн консерциумын зүгээс өрхүүдэд байшингаа дулаалах техникийн шийдэлүүдийн талаар тулгарч буй бэрхшээл, тэдний мэдлэг хандлага, туршлагыг тодруулах зорилготойгоор зорилтот хороодын иргэдийн төлөөллийн дунд ФБЯ-г зохион байгуулжээ. Зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт Сонгинохайран болон Сүхбаатар дүүргийн сонгосон хороодод нийт 16 удаагийн бүлгийн хэлэлцүүлэгт 67 эмэгтэй 60 эрэгтэй төлөөллийг хамрагдсан байна.

1.2.Шинжилгээ


Тоон мэдээллийг дискрефтив болон хамаарлын шинжилгээний аргаар боловсрууллаа. Ингэхдээ судалгаанд оролцсон өрхүүдийг *орлого болон сууцны хэв шинжээр*, ярилцлага өгөгчийг *хүйсээр* ангилан дүн шинжилгээг хийж, бүлэг бүрийн ялгаатай хэв шинжийг илрүүлэхийг зорилоо. Фокус бүлгийн ярилцлагаас гарсан чанарын мэдээллийг нийтлэг шинж тэмдгээр бүлэглэж, хоёр дүүргийн бүлэгт ялгаатай хариултууд байсан эсэхийг харьцуулсан.

2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ ӨРХҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

2.1.Ярилцлага өгөгчийн мэдээлэл

Судалгаанд ярилцлага өгсөн нийт 416 хүний 58% нь өрхийн тэргүүн, 28% нь эхнэр, 11% нь насанд хүрсэн хүүхэд, үлдсэн нь өрхийн бусад гишүүд байв. Ярилцлага өгөгчдийн 53% нь эрэгтэй, 47% нь эмэгтэйчүүд бөгөөд оролцогчдын дундаж нас 44, хамгийн бага настай нь 18, хамгийн өндөр настай нь 87 настай оролцогч байлаа. Насны бүлгээр нь авч үзвэл ярилцлага өгөгчдийн 43% нь 17-39 насныхан, 45% нь 40-59 насныхан, 13% нь 60-аас дээш насныхан байна.

Хүснэгт 2. Ярилцлага өгөгчдийн хүн амзүйн зарим үзүүлэлт (n=416)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

2.2.Өрхийн мэдээлэл

Судалгаанд оролцсон 416 өрх нийтдээ 1618 гишүүнтэй бөгөөд өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна. Нийт өрхийн 42% нь 3 хүртэл ам бүлтэй, 23% нь 4 ам бүлтэй, 19% нь 5 ам бүлтэй, үлдсэн 15% нь 6-9 ам бүлтэй өрхүүд байна.

Нийт өрхүүдэд насанд хүрээгүй хүүхдийн тоо 604, өндөр настны тоо 159, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 26 байна. Тодруулбал, нэг өрх дунджаар 1.5 хүүхэдтэй, нийт өрхүүдийн 39% нь өндөрт настантай, 7% нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй ажээ. Нөгөөтэйгүүр нэг өрхөд дунджаар хөдөлмөр эрхлэх боломжтой 2 хүн⁹ байна.

Зураг 9. Өрхийн ам бүлийн тооны бүлэглэлт (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Гэр бүлийн төрлөөр нь авч үзвэл нийт өрхүүдийн 63% нь дан гэр бүл¹⁰, 17% нь нийлмэл гэр бүл¹¹, 6% нь ганц бие бол 11% нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл, 3% нь ганц бие


⁹ Нийт 829 хөдөлмөрийн насны хүн байна.

¹⁰ Эхнэр, нөхөр, хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл

¹¹ Эхнэр, нөхөр, хүүхдүүд, эмээ, өвөө, хамаатнаас бүрдсэн гэр бүл

эрэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл байна. Тодруулбал, нийт өрхүүдийн 14% нь ганц бие өрх толгойлсон эмэгтэй болон эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүд бөгөөд гэр бүлийн төрлийн хувьд бусад гэр бүлийн төрөлтэй харьцуулахад анхаарахуйц бүлэг юм.

Судалгаанд оролцсон өрхүүдээс нийтдээ 651 хүн өрхийн томоохон худалдан авалт, хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэрийг гаргадаг аж. Эдгээрийн 57% нь өрхийн тэргүүн, 38% нь эхнэр, 3% нь насанд хүрсэн хүүхэд, үлдсэн 2% нь өрхийн бусад гишүүд байна. Олонх өрхийн хувьд аливаа томоохон шийдвэрийг гаргахдаа эхнэр, нөхөр ярилцаж, хамтын шийдвэр гаргадаг болох нь судалгааны явцад ажиглагдсан.




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

2.3.Өрхийн гишүүдийн нийгмийн байдал

Түүвэр судалгаагаар 416 өрхийн насанд хүрсэн нийт 1002 гишүүний нийгмийн болон орлогын мэдээлэл цугларчээ. Эдгээрийн 39% нь өрхийн тэргүүн, 33% нь эхнэр, 19% нь хүүхэд, үлдсэн 9% нь өрхийн бусад гишүүд байна. Хүйсийн хувьд 53% нь эмэгтэй, 47% нь эрэгтэй ажээ. Насанд хүрсэн гишүүдийн дундаж нас 42 байгаа бол хамгийн бага нас 18, хамгийн өндөр нас 87 байна. Нийт насанд хүрсэн гишүүдийн 49% нь 18-39 насныхан, 38% нь 40-59 насныхан, 13% нь 60-аас дээш насныхан ажээ.

Өрхийн тэргүүний 89% нь эрэгтэй, 11% нь эмэгтэй байна. Өрхийн тэргүүний дундаж нас 46, хамгийн өндөр нас 85, хамгийн бага нас 18 байна. Өрхийн тэргүүний 34% нь 18-39 настай, 50% нь 40-59 настай, 16% нь 60-аас дээш настай.



	 11%	 89%
	Өрхийн тэргүүний нас (n=389)	
	Дундаж нас: 42 Хамгийн их нас: 87 Хамгийн бага нас: 18	Залуучууд (18-39): 49% Идэр нас (40-59): 38% Өтөл нас (60+): 13%

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Нийт насанд хүрсэн гишүүдийн 30% нь дээд боловсролтой, 5% нь техник ба мэргэжлийн боловсролтой, 48% нь бүрэн дунд боловсролтой, 6% нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 9% нь суурь ба бага боловсролтой бол 3% нь боловсролгүй байна.

Өрхийн тэргүүний 20% нь дээд боловсролтой, 7% нь техник ба мэргэжлийн боловсролтой бол 66% нь бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой байна. Харин 7% нь огт боловсролгүй бөгөөд дунджаар 50 настай иргэд байна. Өрхийн тэргүүний хувьд боловсролын түвшин Улаанбаатар хотын хүн амын боловсролын түвшнөөс¹²доогуур байгаа бөгөөд ялангуяа бүрэн дунд боловсролтой өрхийн тэргүүний тоо их байна. Өрхийн тэргүүний боловсролын түвшинг өрхийн орлогын ангилалтай харьцуулахад амжиргааны түвшинтэй шууд хамааралтай нь ажиглагдлаа. Тодруулбал, өрхийн тэргүүний боловсролын түвшин доогуур байх тусам өрхүүдийн олонх нь бага орлоготой, харин өрхийн тэргүүний боловсролын түвшин өсөх тусам өрхийн орлого өсөх хандлагатай байна

Зураг 12. Нийт насанд хүрсэн гишүүдийн боловсролын түвшин (n=1002)




Зураг 13. Өрхийн тэргүүний боловсролын түвшин (n=389)



(Зураг 14).

Зураг 14. Өрхийн тэргүүний боловсролын түвшин ба өрхийн орлогын ангилал (n=389)


¹² Улаанбаатар хотын нийт хүн амын 29.6% нь бүрэн дунд боловсролтой, 25.7% нь дээд боловсролтой. (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, 2013)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Нийт насанд хүрсэн гишүүдийн 51% нь хувийн секторт, 15% нь төрийн байгууллагад ажиллаж байгаа бол үлдсэн 34% нь одоогоор ажил эрхлээгүй байна. Эдгээрийн 16% тэтгэвэрт, 7% нь оюутан, 6% нь ажилгүй иргэд байна. Харин өрхийн тэргүүний 33% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 24% нь хувийн байгууллагад, 15% нь төрийн байгууллагад ажилладаг бол 22% нь тэтгэвэр, групптэй, 4% нь ажилгүй ажээ.

Зураг 15. Нийт насанд хүрсэн гишүүдийн сүүлийн 12 сарын ажил эрхлэлтийн байдал (n=1002)



Зураг 16. Өрхийн тэргүүний сүүлийн 12 сарын ажил эрхлэлтийн байдал (n=389)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Одоогоор ажил эрхэлж буй 662 насанд хүрсэн гишүүний 31% нь худалдаа, үйлчилгээний салбарт, 24% нь барилга, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, эрчим хүчний салбарт, 13% нь боловсрол, эрүүл мэндийн салбарт, 9% нь ХАА, батлан хамгаалах, банк санхүү, мэдээлэл холбооны салбарт ажилладаг бол үлдсэн 23% нь бусад салбарт ажилладаг аж. Харин өрхийн тэргүүнүүд үйлчилгээ, барилга, уул уурхай, худалдааны салбарт голдуу ажиллаж байна.

Зураг 17. Нийт насанд хүрсэн гишүүдийн ажил эрхэлдэг салбар (n=662)



Зураг 18. Өрхийн тэргүүний ажил эрхэлдэг салбар (n=389)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Нийт насанд хүрсэн гишүүдийн 46% нь НДШ төлдөг бол 54% нь НДШ төлдөггүй байна. НДШ төлдөг иргэдийн 66% нь төрийн ба хувийн байгууллагад ажилладаг, 20% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч 20% бол үлдсэн 14% нь одоогоор ажил эрхлээгүй бүлэг байна. Харин НДШ төлдөггүй иргэдийн 35% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 14% нь хувийн байгууллагад ажилладаг бол 49% нь одоогоор ажил эрхэлдэггүй бүлэг байна.

Нөгөөтэйгүүр төрийн байгууллагад ажилладаг гишүүд бүгд НДШ төлдөг, хувийн байгууллагад ажилладаг гишүүдийн 67% нь НДШ төлдөг, хувиариа хөдөлмөр эрхлэгчдийн 40% нь НДШ төлж байна.

Зураг 19. Нийт насанд хүрсэн гишүүдийн нийгмийн даатгал төлөлт, ажил эрхлэлтийн байдлаар




3. АГААРЫН БОХИРДОЛ БА СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА

Энэ бүлэгт өрхүүдийн агаарын бохирдол ба сууцны дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлагыг түүвэр судалгааны үр дүн болон СОП төслийн багийн зохин байгуулсан ФБХ-ийн үр дүнтэй нэгтгэн авч үзнэ.

3.1. Агаарын бохирдлын талаарх мэдлэг, хандлага

Судалгаанд оролцогч өрхүүдийн агаарын бохирдлын талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлохдоо дараах хүрээнд авч үзлээ.


Зураг 20. Агаарын бохирдлын талаарх мэдлэгийг тодорхойлох хүрээ



Агаарын чанарын хэмжүүрийн талаарх анхан шатны мэдлэг тааруу байна. Улаанбаатар хотын агаарын чанар хэр байгааг харуулдаг гол үзүүлэлт бол агаарын чанарын индекс (АЧИ) юм. АЧИ нь тухайн газарт агаарын чанар ямар байгааг олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх зорилготой үзүүлэлт бөгөөд цаг агаарын мэдээний нэгэн адилаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг байх зайлшгүй шаардлага Улаанбаатарчуудын хувьд үүсэж байна. Тодруулбал, салхинд гарах, олон цагаар гадаа ажиллахад гадна орчны агаар цэвэр байна уу, эсвэл хортой байна уу гэдгийг шалган үзэх дадал зуршил нийт хүн амд шаардлагатай байгаа билээ.

Судалгаанд оролцогчдын 49% нь АЧИ-ийн талаар огт сонсож байгаагүй аж. Эдгээр иргэдийг нас ба хүйсээр нь ангилж үзвэл нас болон хүйснээс үл хамааран нийтээрээ АЧИ-ийн талаар мэдэхгүй байна. Харин нийт оролцогчдын 51% нь АЧИ-ийн талаар сонсож байсан ч тэдгээрийн олонх АЧИ-ийг тайлж ойлгох анхан шатны мэдлэггүй байна. Тодруулбал, оролцогчдоос АЧИ-ийн өнгөний тэмдэглэгээнээс зөвхөн нэгийг асуухад нийт оролцогчдын 5% нь л зөв хариулсан бөгөөд тэдгээрийн олонх нь эрэгтэйчүүд байв.

Зураг 21. АЧИ-ийн талаар сонссон эсэх, АЧИ-ийн ягаан өнгөний тэмдэглэгээний талаарх ойлголт (n=416)



АЧИ талаар сонсоогүй оролцогчид (n=202)	АЧИ талаар сонссон оролцогчид (n=214)	АЧИ-ийн өнгийг зөв хариулсан оролцогчид (n=22)
 50%	 50%	 28%
 50%	 45%	 73%

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Агаарын бохирдлын гол эх үүсвэрүүдийн талаар мэдлэг сайтай байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80% нь гэр хорооллын өрхүүдийн хатуу түлшний зуухны утаанаас, 10% нь автотээврийн хэрэгслээс ялгарах хорт утаанаас, 6% нь гурван том дулааны цахилгаан станцын жилийн нүүрсний хэрэглээнээс, 4% нь хог шороо хөрсний бохирдлоос тус тус ялгарч байна (Зориг сан, Konrad Adenauer Stiftung, 2018).

Судалгаанд оролцогчдын 86% нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын хамгийн гол эх үүсвэрийг гэр хорооллын өрхүүдийн хатуу түлшний зуухны утаа гэж үзсэн бөгөөд дараагийн бохирдуулагч эх үүсвэрээр авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа хэмээн талаас дээш хувь нь үзжээ. Энэ үр дүн мөн фокус бүлгийн ярилцлагын үеэр бататгагдсан (2018 оны 10-11-р сарын ФБЯ).

Зураг 22. Агаарын бохирдлын гол эх үүсвэрийн талаарх мэдлэг (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөний талаарх анхан шатны мэдлэг сайн байна. Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалахын тулд талаас илүү хувь нь амны хаалт зүүж байна. Агаарын бохирдол хүний гол эрхтэн тогтолцоонууд болох амьсгалын тогтолцоо, мэдрэлийн тогтолцоо, зүрх судасны тогтолцоо, нөхөн үржихүйн тогтолцоонд нөлөөлдөг аж (НЭМҮТ, 2017). Эдгээрээс хамгийн түгээмэл нь амьсгалын тогтолцооны өвчлөл буюу амьсгалын замын хурц болон архаг өвчнүүдийн тохиолдол юм.

Судалгаанд оролцогчдын 87% нь агаарын бохирдол хүний эрхтэн тогтолцооноос амьсгалын тогтолцоонд хамгийн түгээмэл хор нөлөө үзүүлдэг гэж зөв хариулсан бол 10% нь нөхөн үржихүй, зүрх судас, мэдрэлийн тогтолцоо гэж хариулжээ. Эдгээр нь зөв


хариулт боловч хамгийн түгээмэл гэсэн эрэмбийн хувьд хамгийн эхэнд жагсахгүй. Харин 3% нь агаарын бохирдол хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд хор нөлөө үзүүлдэг хэмээн буруу хариулжээ.

Агаарын бохирдлоос өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалахын тулд хамгийн нийтлэг ашиглаж буй аргууд нь гадуур гарахдаа амны хаалт зүүх, дархлаагаа дэмжих, гэртээ агаар цэвэршүүлэгч тавих зэрэг байна (Зураг 24). Нийт оролцогчдын 54% нь амны хаалт зүүдэг, 29% нь дархлаагаа дэмждэг, 26% нь гэртээ агаар цэвэршүүлэгч тавьсан, 20% нь утаа ихтэй үед аль болох гарахгүй байхыг хичээдэг ажээ.


Шигтгээ. ... Айл ихсээд утаа мэдэгдэхүйц нэмэгдээд байна. Утаа нь доогуураа тунадаг. Цэцэрлэг нь зам дагуу яг утаа тунадаг газар байдаг. Орой бүр л хоол хүнстэйгээ цуг аптекаас эмээ аваад л харьдаг. Хүүхдийн эрүүл мэндэд их муу нөлөөтэй. Урагт ч маш муу, эрүүл хүүхэд гараасай л гэж залбирдаг. Байгалийн жимс хандалж уулгадаг. Утааны эсрэг арга хэмжээ гэвэл утаатай үед цонхоо нээхгүй байх л юм даа. Ялангуяа доор байгаа айлын яндан дээд айлын цонхны тушаа байвал бүр аюултай. Тогны мөнгө хямд бол гал түлэхгүй, утаа гаргахгүй байж болно. (СХД-ийн 28 хорооны иргэн, 2018-10-31)

Харин нийт оролцогчдын 7% нь агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалахын тулд юу ч хийгээгүй байна.

Зураг 23. Агаарын бохирдлын хүний эрхтэн тогтолцоонд үзүүлэх хор нөлөөний талаарх мэдлэг (n=416)



Зураг 24. Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалахын тулд хийдэг зүйлс, нийт хариултын тоогоор (n=660)




Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалахын тулд хийдэг зүйлс, нийт оролцогчдоор (n=416)

- ✓ Амны хаалт зүүдэг-54%
- ✓ Дархлаагаа дэмждэг-29%
- ✓ Гэртээ агаар цэвэршүүлэгч тавьсан-26%
- ✓ Утаа ихтэй үед аль болох гадагшаа гарахгүй байх-20%
- ✓ Юу ч хийгээгүй-7%

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Агаарын бохирдлоос үүдэн өрхөд учирч буй гол хохирол нь эрүүл мэнд байна. Судалгаанд оролцогчдын 72% нь агаарын бохирдлоос үүдэн эрүүл мэндээрээ хохирч байгаа гэсэн бол 25% нь эдийн засгийн хувьд хохиролтой байна гэж үзжээ. Тодруулбал, эдгээрийн 17% нь агаарын бохирдлоос үүдэн эрүүл мэндэд гаргах зардал өсөж байна гэсэн бол үлдсэн 8% нь агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэхтэй холбоотой өрхийн хэрэглээний болон удаан эдэлгээтэй барааны зардал өсөж байгаа гэжээ. Харин 2% нь агаарын бохирдлоос үүдэн өрхөд ямар нэгэн хохирол учраагүй гэсэн бол 1% нь энэ талаар хэлж мэдэхгүй байв.

Зураг 25. Агаарын бохирдлоос үүдэн өрхөд учирч буй хохирол (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Цахилгаан халаагуур хэрэглэх, байшингаа дулаалж нүүрсний хэрэглээгээ бууруулах явдал нь гэр хорооллын амины сууцтай өрхүүдийн хувьд агаарын бохирдлыг бууруулахад хамгийн тохиромжтой гэж үзжээ. Судалгаанд оролцсон өрхүүдийн 37% нь цахилгаан халаагуур хэрэглэх замаар, 36% нь байшингаа дулаалж, нүүрсний хэрэглээгээ бууруулах замаар, 14% нь сайжруулсан түлш хэрэглэх замаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой гэжээ (Зураг 26). Хэдийгээр иргэдийн багагүй хувь нь цахилгаан халаагуур хэрэглэхийг чухалчилж буй ч, бүлгийн ярилцлагын үеэр иргэдийн зүгээс цахилгаан халаагуур нь агаар шатаадаг, уушгинд муу нөлөөтэй, тиймээс нялх хүүхэдтэй айлуудад тийм ч тохиромжтой байдаггүйг дурдаж байсан (2018 оны 10-11-р сарын ФБЯ).

Цахилгаан халаагуур хэрэглэх нь тохиромжтой гэж үзсэн өрхүүдийн 45% нь бага орлоготой, 55% нь дунд ба дундаас дээгүүр орлоготой байгаа бол байшингаа дулаалж, нүүрсний хэрэглээгээ бууруулах сонирхолтой өрхүүдийн 54% нь бага орлоготой, 46% нь дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд байна. Өрхийн орлогын бүлгээр авч үзвэл бага

орлоготой өрхүүд байшингаа дулаалах, сайжруулсан түлш хэрэглэх, цахилгаан халаагуур хэрэглэхийг өөрт тохирно гэж үзэж байгаа бол дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд сайжруулсан түлш хэрэглэх, цахилгаан халаагуур хэрэглэх, хашаандаа мод тарих, орон сууцанд орох замаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.

Зураг 26 Гэр хорооллын амины сууцтай өрхүүдийн агаарын бохирдлыг бууруулахад тохирох арга (n=416)



Зураг 27 Гэр хорооллын амины сууцтай өрхүүдийн агаарын бохирдлыг бууруулахад тохирох арга ба орлогын ангилал¹³ (n=416)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулахад төр засаг, ААНБ, иргэдийн зүгээс нийтээрээ нэн тэргүүнд юу хийх шаардлагатай талаар тодруулахад өрхүүдийн зүгээс цахилгаан халаатыг нийтээрээ хэрэглэх, харин төр засгийн зүгээс уг боломжийг дэмжих, гэр хорооллыг дахин төлөвлөх, сайжруулсан түлш хэрэглэх шаардлагатай гэж өрхүүдийн олонх үзжээ. Өрхийн хувьд өөрт тохирох арга болон гэр хороололд нэн тэргүүнд хийх шаардлагатай зүйлсийг нэгтгэн дүгнэвэл цахилгаан халаагуурыг хэрэглэх явдлыг хамгийн тохиромжтой бөгөөд боломжийн шийдэл гэж үзжээ.

Зураг 28. Гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулахад нэн тэргүүнд хийх шаардлагатай зүйлс (n=460 санал)

¹³ Өрхийн орлогын ангиллыг “Хүснэгт 5. Өрхийн сарын дундаж орлогын ангилал”-аас харна уу.




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

3.2. Дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлага


Судалгаанд оролцогч өрхүүдийн дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлохдоо дараах хүрээнд авч үзлээ.

Зураг 29. Дулаан алдагдлын талаарх мэдлэгийг тодорхойлох хүрээ



Гэрээ дулаан байлгах, гэрийн дулаан алдагдлыг бууруулах талаарх мэдлэг тааруу байна. Гэрээ дулаан байлгахын тулд юу хийх хэрэгтэй талаар 2 хариулт хэлж өгөхийг судалгаанд оролцсон өрхүүдээс хүссэн бөгөөд нийт 549 хариулт иржээ. Үүнээс 34% нь сууцаа дулаална, 15% нь цахилгаан халаагуур ашиглана, 3% нь сайжруулсан түлш хэрэглэнэ гэсэн бол 28% нь энэ талаар хариулж мэдэхгүй, 21% нь галаа түлнэ гэжээ. Өөрөөр хэлбэл, нийт саналын тал хувь нь орон гэрээ дулаалах, түлшний хэмнэлтийн талаар мэдлэггүй байгааг харуулж байна.

Зураг 30. Гэрээ дулаан байлгахад хийх зүйлс (n=549)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхийн орлогын түвшинөөс хамаараад сууцаа дулаалах, дулаан алдагдлыг бууруулах мэдлэг бага зэрэг ялгаатай байна. Дээрх асуултад “Мэдэхгүй” гэж хариулсан өрхүүдийн 91% нь, “Галаа түлнэ” гэсэн өрхүүдийн 96%, “Сууцаа дулаална” гэсэн өрхүүдийн 90% нь дунд ба түүнээс доош орлоготой¹⁴ өрхүүд ажээ. Харин “Цахилгаан халаагуур ашиглана” гэсэн

¹⁴ Өрхийн орлогын ангиллыг “Хүснэгт 5. Өрхийн сарын дундаж орлогын ангилал”-аас харна уу.


өрхүүдийн 76% нь, “Сайжруулсан түлш хэрэглэнэ” гэсэн өрхүүдийн 67% нь дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд байна (Зураг 31).

Өрхүүдийн хувьд агаарын бохирдлыг бууруулахад хамгийн тохиромжтой гэж үзсэн цахилгаан халаагуур хэрэглэх, байшингаа дулаалж нүүрсний хэрэглээгээ бууруулах, сайжруулсан түлш хэрэглэх гэсэн аргуудыг гэрээ дулаан байлгахад хийх зүйлстэй харьцуулахад “агаарын бохирдлыг бууруулахад байшингаа дулаална” гэсэн өрхүүдийн 47% гэрээ дулаахан байлгахын тулд галаа түлнэ (16%), мэдэхгүй (31%) гэсэн бол 35% нь л байшингаа дулаална гэжээ. Харин “агаарын бохирдлыг бууруулахад цахилгаан халаагуур хэрэглэх нь тохиромжтой” гэсэн өрхүүдийн 45% гэрээ дулаахан байлгахын тулд галаа түлнэ (27%), мэдэхгүй (18%) гэсэн бол 19% нь цахилгаан халаагуур хэрэглэнэ, 33% байшингаа дулаална гэжээ. Эндээс үзэхэд судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь эхний өгсөн хариултаа дараагийн¹⁵ удаад дэмжихгүй байгаа нь ажиглагдаж байна. Иймд судалгаанд оролцогчдын бараг тал хувьд гэрээ дулаалах, дулааны алдагдлыг бууруулах нь агаарын бохирдлыг бууруулах дам нөлөөтэй гэдгийг анзаарахгүй байна. (Зураг 32).

Зураг 31. Гэрээ дулаан байлгахад хийх зүйлс ба орлогын ангилал, хийх зүйлсээр (n=549)



Зураг 32. Гэрээ дулаан байлгахад хийх зүйлс ба агаарын бохирдлыг бууруулахад тохирох арга




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Гэрээ дулаан байлгах, сууцны дулаан алдагдлаа бууруулах хандлага хангалттай биш байна. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь мэдлэгийн дутмаг байдал болон орлогын хүрэлцээгүй байдал юм. Тодруулбал, судалгаанд оролцогчдын бараг тал хувь (46%) нь сууцандаа огт дулаалга хийж байгаагүй бөгөөд эдгээрийн 62% нь гэрээ дулаан байлгах талаар мэдлэггүй¹⁶ байгаа бол 87% нь дунд ба түүнээс доош орлоготой өрхүүд ажээ.


Зураг 33. Сууцаа огт дулаалаагүй өрхүүдийн гэрээ дулаан байлгахад хийх зүйлс (n=189)

¹⁵ Асуултын зорилго ижил хэдий ч тавил нь өөр байв.

¹⁶ Галаа түлэх, мэдэхгүй гэсэн өрхүүдийг мэдлэггүй гэж үзлээ.



Зураг 34. Сууцаа огт дулаалаагүй өрхүүдийн орлогын ангилал (n=189)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Сууцаа дулаасан өрхүүдийн хувьд хана, цонх, дээврийн дулаалгыг илүүтэй хийдэг аж. Судалгаанд оролцсон өрхүүдийн 54% нь сууцаа ямар нэгэн байдлаар дулаалсан гэж үзсэн бөгөөд нийт 300 дулаалгын тохиолдол бүртгэгджээ. Эдгээрээс 31% нь хана, 26% нь цонх, 15% нь дээрээ дулаалсан байна (Зураг 35).

Өрхүүдийн олонх гэртээ тав тухтай, дулаахан өвөлжиж байна. Судалгаанд оролцсон өрхүүдийн 71% нь гэртээ дулаахан, 21% нь дунд зэрэг, 9% хүйтэн сэрүүн өвөлжиж байгаа гэжээ.

Зураг 35. Сууцаа дулаалсан байдал (n=300)

Зураг 36. Гэртээ тав тухтай, дулаахан байгаа эсэх (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Гэртээ тав тухтай, дулаахан өвөлжиж байгаа байдлын хариулт бүрийн хувьд нүүрсний дундаж хэрэглээ болон галлагааны дундаж тоог тооцлоо. Сараар нүүрснийхээ хэрэглээг хэлсэн өрхүүдийн¹⁷ хувьд “дулаахан” өвөлжиж байгаа өрхүүдийн нүүрсний дундаж хэрэглээ, жилээр нүүрснийхээ хэрэглээг хэлсэн өрхүүдээс¹⁸ “маш дулаахан” өвөлжиж байгаа өрхүүдийн нүүрсний дундаж хэрэглээ их байгаа нь дулаахан өвөлжихөд нүүрсний хэрэглээ нөлөөтэй хэмээн дүгнэж болохоор байна. Гэхдээ хүйтэн, сэрүүн өвөлжиж байгаа өрхүүдийн нүүрсний дундаж хэрэглээ ч мөн өндөр байна.

Нөгөө талаас гэртээ тав тухтай, дулаахан өвөлжиж байгаа байдлыг өвлийн улирлын дундаж галлагааны тоотой харьцуулахад гэрийн дулаан буурах тусам галлагааны тоо өсөж байна. Энэ нь гэртээ хүйтэн, сэрүүн өвөлжиж байгаа айлууд өдөрт олон удаа галлаж, нүүрс их шатаадаг болохыг харуулж байна.

Хүснэгт 4. Гэртээ дулаан өвөлжиж байгаа байдал болон нүүрсний дундаж хэрэглээ, дундаж галлагааны тоо

Гэртээ тав, тухтай дулаахан байгаа эсэх	Нүүрсний дундаж хэрэглээ		Өвлийн улирлын дундаж галлагааны тоо
	Сард (уутаар)	Жилд (тонноор)	
Маш дулаахан	22	4.7	2.6
Дулаахан	26	3.7	3.2
Дунд зэрэг	22	3.8	3.7
Сэрүүн	22	4	4.2
Маш хүйтэн	36	3.3	4.3


Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Гэртээ тав тухтай, дулаахан өвөлжиж байгаа байдлыг гэртээ дулаалга хийсэн эсэхтэй харьцуулахад хариулт бүрийн хувьд олонх нь гэртээ дулаалга хийгээгүй байна. Тодруулбал, гэртээ “маш дулаахан” өвөлжиж байгаа өрхүүдийн 55%, “дулаахан” өвөлжиж байгаа өрхүүдийн 71%, “дунд зэрэг” өвөлжиж байгаа өрхүүдийн 65% нь гэртээ дулаалга хийгээгүй байна. Иймд гэртээ дулаахан өвөлжиж байна гэдэг нь нүүрсний хэрэглээнээс хамаарч байна гэсэн өмнөх дүгнэлтийг дэмжиж байна.

Зураг 37. Сууцаа дулаалсан байдал (n=300)

¹⁷ 163 өрх

¹⁸ 237 өрх



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

4. ӨРХИЙН САНХҮҮГИЙН ЧАДАМЖ

Энэ бүлэгт судалгаанд оролцсон өрхүүдийн орлого орлого ба зардал, хадгаламж ба зээл, өмч хөрөнгө, хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөөг авч үзнэ.

4.1.Өрхийн орлого ба зардал

4.1.1 Өрхийн орлого

Өрхийн сарын дундаж орлого

Судалгаанд оролцсон өрхүүдийн бараг тал хувь нь 700 мянган төгрөгөөс бага сарын орлоготой байгаа төдийгүй төслийн зорилтот хороодын өрхүүдийн сарын дундаж орлого нийтээрээ Нийслэлийн өрхүүдийн дундаж орлогоос доогуур байна. Сүхбаатар дүүргээс судалгаанд оролцсон өрхүүдийн сарын дундаж орлого Сонгинохайрхан дүүргийнхнээс бага зэрэг өндөр байна.

Өрхүүдийг сарын дундаж орлогоор нь бүлэглэн авч үзвэл 500 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 26%, 500-700 мянган төгрөгийн орлоготой өрх 22%, 700-900 мянган төгрөгийн орлоготой өрх 17% байна. Харин 900 мянган төгрөгөөс дээш орлоготой өрх 35% байна. Өрхийн сарын дундаж орлогыг ойролцоолон тооцвол 840,000 төгрөг байна (Зураг 38).

Дүүргээр нь харьцуулахад Сүхбаатар дүүргээс судалгаанд оролцсон өрхүүдийн орлого Сонгинохайрхан дүүргийнхнээс бага зэрэг өндөр байна. Тодруулбал, Сүхбаатар дүүрэгт бага орлоготой өрхийн эзлэх хувь Сонгинохайрхан дүүргийнхнээс бага, дунд орлоготой өрхийн эзлэх хувь их, дундаас дээш орлоготой өрхийн эзлэх хувь ижил байна (Зураг 38).

Судалгааны үр дүнг 2018 оны IV улирлын нийслэлийн өрхийн мөнгөн орлогын бүлэглэлтэй¹⁹ харьцуулахад 500 мянган төгрөгөөс доош орлоготой өрхийн эзлэх хувь 14%-иар их, 500-700 мянган төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 11%-иар их, 700-900 мянган төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 3%-иар их байгаа бол 900 мянгаас дээш орлоготой өрхийн эзлэх хувь 31%-иар бага байна. Түүнчлэн нийслэлийн өрхийн сарын дундаж мөнгөн орлого 1.3 сая төгрөг бөгөөд энэ нь судалгаанд оролцсон өрхүүдийн сарын дундаж орлогоос даруй 460 мянган төгрөгөөр их байна (Зураг 38).

Цаашид судалгаанд оролцсон өрхүүдийг дараах орлогын гурван бүлэгт хувааж, бүлгийн хэв шинжийг тодорхойлохыг зорино.


Хүснэгт 5. Өрхийн сарын дундаж орлогын ангилал

Ангиллын нэр	Сарын орлогын хэмжээ	Өрхийн дүнд эзлэх хувь ²⁰
Бага орлоготой	700,000 төгрөг хүртэл	48%
Дундаж орлоготой	700,001-1,300,000 төгрөг	42%
Дунджаас дээгүүр орлоготой	1,300,001 төгрөгөөс дээш орлоготой	11%

¹⁹ ҮСХ, www.1212.mn

²⁰ Сарын дундаж орлогоос хариулахаас татгалзсан 5 өрхийг хасч тооцов.

Зураг 38. Өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт, нийт түүвэрээр, дүүргээр




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, ҮСХ (www.1212.mn)

Гадаадаас мөнгөн шилжүүлэг хүлээн авдаг 14 өрх байгаасаас 11 нь хүлээн авдаг мөнгөн шилжүүлэгийн хэмжээгээ хэлэхээс татгалзав. Үлдсэн гурван өрхийн хувьд 1.2 сая төгрөг, 6 сая төгрөг, 500 мянган төгрөг жилдээ тус тус авдаг байна.

Өрхийн сарын дундаж орлогыг өрхийн ажил эрхэлдэг гишүүдийн тоотой харьцуулан доорх хүснэгтэд үзүүлээ. Нэг өрхөд дунджаар 1.7 хүн ажил эрхэлж байна. Өрхийн сарын дундаж орлого өрхийн дундаж ажил эрхэлдэг гишүүдийн тооноос эерэг хамаарч байна. Тодруулбал, өрхийн дундаж ажил эрхэлдэг гишүүдийн тоо өсөх тусам өрхийн орлого өсөж байна.

Зураг 39. Өрхийн сарын дундаж орлого ба өрхийн дундаж ажил эрхэлдэг гишүүдийн тооны хамаарал



Хүснэгт 6. Өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт ба өрхийн ажил эрхэлдэг гишүүдийн тоо


Өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт	Өрхийн ажил эрхэлдэг гишүүдийн тоо						Нийт	Дундаж ажил эрхэлдэг гишүүдийн тоо
	0	1	2	3	4	5		
500,000 төгрөг хүртэл	17	38	43	7	1	1	107	1.43
500,001-700,000	9	32	36	12	1	-	90	1.6
700,001-900,000	8	13	38	8	1	1	69	1.76
900,001-1,100,000	9	14	28	8	5	-	64	1.78
1,100,001-1,300,000	4	7	21	6	0	1	39	1.84
1,300,001-1,500,000	2	3	10	4	3	-	22	2.13
1,500,001-2,000,000	2	1	4	2	1	-	10	1.9
2,000,001-2,500,000	-	3	2	2	-	-	7	1.85
2,500,001 төгрөгөөс дээш	-	1	1	1	-	-	3	2
Хариулахаас татгалзсан	-	1	2	1	1	-	5	2.4
Нийт	51	113	185	51	13	3	416	1.68

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Ганц бие, эмэгтэй өрхийн тэргүүнтэй болон ганц бие эрэгтэй өрхийн тэргүүтэй гэр бүлүүдийн олонх нь бага орлоготой байна. Ганц бие хүмүүсийн 84% нь, эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн 71%, ганц бие эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн 58% нь бага орлоготой ажээ. Харин дан болон нийлмэл гэр бүлүүдийн олонх нь дунд ба түүнээс дээш орлоготой байна (Зураг 40).

Өрхүүдийн талаас дээш хувьд өрхийн орлого хүрэлцэхгүй байна. Судалгаанд оролцсон өрхүүдийн 53% нь өрхийн орлого хүрэлцдэггүй, 40% нь орлогын хүрэлцээ дунд зэрэг, зөвхөн 6% нь орлого хүрэлцээтэй гэж үнэлсэн байна (Зураг 41).

Зураг 40. Өрхийн орлогын ангилал ба гэр бүлийн төрөл



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Орлогын хүрэлцээг өрхийн орлогын ангиллаар авч үзвэл бага орлоготой өрхүүдийн 80%, дундаж орлоготой өрхүүдийн 30%, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 24%-д өрхийн орлого хүрэлцэхгүй байна. Харин бага орлоготой өрхүүдийн 18%, дундаж орлоготой өрхүүдийн 64%, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 48% нь орлогын хүрэлцээгээ дунд зэрэг буюу өдөр тутмын хэрэгцээ болон хувцас хэрэглэл авч хүрэлцдэг гэжээ. Бага орлоготой өрхүүдийн 2%, дундаж орлоготой өрхүүдийн 6%, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 29% орлогоо хүрэлцээтэй хэмээн үнэлжээ.

Зураг 41. Өрхийн орлогын хүрэлцээ (n=416)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхийн насанд хүрсэн гишүүдийн орлого

Өрхийн насанд хүрсэн гишүүдийн талаас илүү хувь цалингийн орлоготой байгаа бол судалгаанд оролцсон өрхүүдийн гуравны нэгийг нь хувьд өрхийн бүх гишүүн цалингийн орлоготой байна. Түүнчлэн цалин+тэтгэвэр тэтгэмжийн орлоготой өрхүүд, цалин+бизнесийн орлоготой өрхүүд дараагийн томоохон хэсэг нь байна.

Өрхийн насанд хүрсэн гишүүдийн 9% нь огт орлогогүй бол үлдсэн 91% нь ямар нэгэн төрлийн орлоготой ажээ. Тэдгээрийн 54% нь цалин хөлсний орлоготой, 19% нь тэтгэвэр тэтгэмжтэй, 19% нь бизнесийн орлоготой байна.

Зураг 42. Өрхийн насанд хүрсэн гишүүдийн орлогын төрөл (n=999)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Орлогын төрлийг судалгаанд оролцсон өрхөөр авч үзвэл өрхүүдийн 51% нь нэг орлогын төрөлтэй, 38% нь хоёр орлогын төрөлтэй, 11% нь хоёроос дээш орлогын төрөлтэй аж. Бүх гишүүн зөвхөн цалингийн орлоготой өрх (35%), цалин+тэтгэвэр тэтгэмжийн орлоготой өрхүүд (13%), цалин+бизнесийн орлоготой өрхүүд (13%), бүх гишүүн нь бизнесийн орлоготой өрхүүд (9%), цалин+орлогогүй гишүүдтэй өрхүүд (9%) нийтлэг байна.

Зураг 43. Өрхийн орлогын төрөл (n=416)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхийн орлогын ангиллаар авч үзвэл бага орлоготой өрхүүдийн хувьд нэг орлогын төрөлтэй өрхүүд 51% байгаа бөгөөд тэдгээрийн 26% нь бүх гишүүн цалингийн орлоготой өрхүүд ажээ. Бага орлоготой өрхүүдийн 40% нь хоёр орлогын төрөлтэй өрхүүд бөгөөд энэ ангилалд цалин+тэтгэвэр тэтгэмжийн орлоготой, цалин+бизнесийн орлоготой, цалин+орлогогүй гишүүдтэй өрхүүд зонхилж байна. Бага орлоготой өрхүүдийн 9% нь хоёр ба түүнээс дээш орлогын төрөлтэй байна.

Дундаж орлоготой өрхүүдийн 55% нь нэг орлогын төрөлтэй бөгөөд тэдгээрийн 44% нь бүх гишүүд нь цалингийн орлоготой өрхүүд ажээ. Харин 35% нь хоёр орлогын төрөлтэй бөгөөд цалин+тэтгэвэр тэтгэмжийн орлоготой, цалин+бизнесийн орлоготой өрхүүд зонхилж байна. Дундаж орлоготой өрхүүдийн 10% нь хоёр ба түүнээс дээш орлогын төрөлтэй байна.

Дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 40% нь нэг орлогын төрөлтэй бөгөөд тэдгээрийн 36% нь бүх гишүүд нь цалингийн орлоготой өрхүүд ажээ. Түүнчлэн хоёр орлогын төрөлтэй өрхүүд мөн л 40% бөгөөд цалин+тэтгэвэр тэтгэмжийн орлоготой, цалин+бизнесийн орлоготой өрхүүд зонхилж байна. Дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 20% нь хоёр ба түүнээс дээш орлогын төрөлтэй бөгөөд эдгээрийн олонх нь цалин+тэтгэвэр+бизнесийн орлоготой өрхүүд байна.

Зураг 44. Өрхийн орлогын төрөл, орлогын ангиллаар




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Цалин хөлсний орлоготой өрхийн гишүүдийн олонх нь нийгмийн даатгал төлдөг цалингийн эх үүсвэртэй, бизнесийн орлоготой өрхийн гишүүдийн олонх нь худалдаа наймаа болон бусад төрлийн бизнесийн орлогын эх үүсвэртэй ажээ. Тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрхийн гишүүд сард дунджаар 302,500 төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж авч байна.

Өрхийн орлогын үндсэн төрлүүдийг орлогын эх үүсвэрээр нь авч үзвэл цалин хөлсийн хувьд 69% нь НДШ төлдөг цалин, 30% нь НДШ төлдөггүй цалин, 1% нь бусад төрлийн цалин хөлс байна. Бизнесийн орлогын гол эх үүсвэр нь худалдаа наймаанаас олсон орлого (49%) болон бусад төрлийн бизнесээс олсон орлого (42%) байна.

Тэтгэвэр, тэтгэмжийн 88% нь тэтгэвэр, 7% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамж, үлдсэн 5% нь бусад төрлийн халамж байна. Тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой 186 хүн байгаагаас 83% нь тэтгэвэр, тэтгэмжийнхээ хэмжээг хэлсэн бол үлдсэн 17% нь хэлэхээс татгалзжээ. Дундаж тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ сард 302,500 төгрөг, хамгийн ихдээ 825,000 төгрөг, хамгийн багадаа 155,000 төгрөг байна.

Зураг 45. Өрхийн гишүүдийн орлогын эх үүсвэр, орлогын төрлөөр



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


4.1.2 Өрхийн зардал

Өрхийн зардлыг боловсрол, сургалтын зардал, эрүүл мэндийн зардал, түлш, цахилгааны зардлаар ангилан авч үзлээ.

Боловсрол, сургалтын төлбөр

Судалгаанд оролцсон өрхүүдийн 42% нь боловсрол, сургалтын зардал гаргадаг бөгөөд эдгээр өрх жилд дунджаар 1.2 сая төгрөгийг боловсролд зарцуулдаг ажээ. Хамгийн ихдээ жилд 9 сая төгрөг, хамгийн багадаа 100 мянган төгрөгийг зарцуулсан байна. Боловсролд зардал гаргадаг өрхүүдийн 49% нь жилд 500 мянган төгрөг хүртэл, 16% нь 500-1000 мянган төгрөг, 11% нь 1-2 сая төгрөг, 24% нь 2 саяас дээш төгрөгийг боловсролд зарцуулжээ.

Зураг 46. Боловсрол, сургалтын зардлын бүлэглэлт, жилээр (n=174)



Дундаж: 1,257,580

Медиан: 600,000

Хамгийн олон давтагдсан утга: 240,000


Хамгийн их утга: 9,000,000

Хамгийн бага утга: 100,000


Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Боловсрол, сургалтын зардлыг өрхийн орлогын ангиллаар авч үзвэл боловсролд зардал гаргаагүй өрхүүдийн талаас илүү хувь нь бага орлоготой бол боловсролд зардал гаргадаг өрхүүдийн талаас илүү хувь нь дундаж орлоготой өрхүүд байна. Боловсролд зардал гаргадаг өрхүүдийг орлогоор нь ангилан үзвэл бага орлоготой өрхүүдийн 60 орчим хувь нь, дундаж орлоготой өрхүүдийн 70% нь, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 55% нь 1 сая хүртэл төгрөгийн зардал гаргаж байна.

Зураг 47. Боловсрол, сургалтын зардал гаргадаг эсэх, орлогын ангиллаар (n=416)



Зураг 48. Боловсрол, сургалтын зардлын бүлэглэлт, орлогын ангиллаар (n=174)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Эрүүл мэндийн зардал

Судалгаанд оролцсон өрхүүдийн 94% нь эрүүл мэндийн зардал гаргадаг бөгөөд эдгээр өрх сард дунджаар 63,400 төгрөгийг эрүүл мэндэд зарцуулж байна. Хамгийн ихдээ сард 350 мянган төгрөг, хамгийн багадаа 6,000 төгрөгийг зарцуулсан байна. Эрүүл мэндэд зардал гаргадаг өрхүүдийн 20% нь сард 25 мянган төгрөг хүртэл, 44% нь сард 25-50 мянган төгрөг, 24% нь сард 50-100 мянган төгрөг, 7% нь сард 100-200 мянган төгрөг, 4% нь сард 200 мянгаас дээш төгрөгийг эрүүл мэндэд зарцуулжээ.


Зураг 49. Өрхийн эрүүл мэндийн сарын зардал, төгрөгөөр (n=392)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Эрүүл мэндийн зардлыг өрхийн орлогын ангиллаар авч үзвэл бага орлоготой өрхүүд эрүүл мэнддээ сард дунджаар 54,370 төгрөг, дундаж орлоготой өрхүүд 61,580 төгрөг, дунджаас дээгүүр орлоготой өрхүүд 76,200 төгрөгийг зарцуулж байна. Бага ба дунд орлоготой өрхүүдийн гуравны хоёр нь, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн тал нь сард 50,000 хүртэл төгрөгийн зардлыг эрүүл мэнддээ гаргаж байна. Харин бага ба дундаж орлоготой өрхүүдийн 34%, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 51% нь сард 50 мянгаас дээш төгрөгийг эрүүл мэнддээ зарцуулж байна. Эндээс бага ба дундаж орлоготой өрхүүдийн хувьд эрүүл мэндийн зардалд төдийлөн ялгаа ажиглагдахгүй байгаа бол дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн хувьд энэ 2 бүлгээс дунджаар 15,000-20,000 төгрөг илүү зарцуулж байна.

Зураг 50. Эрүүл мэндийн зардлын бүлэглэлт, орлогын ангиллаар (n=392)




Эрүүл мэндийн зардал (сард)	Бага орлоготой	Дундаж орлоготой	Дунджаас дээгүүр орлоготой
Дундаж (төгрөг)	54,370	61,580	76,220
Медиан (төгрөг)	40,000	40,000	50,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон өрхүүдийн 92% нь амьсгалын замын өвчинд, 24% нь зүрх судасны өвчинд тус тус зардал гаргаж байна. Амьсгалын замын өвчинд нэг өрх дунджаар сард 37,125 төгрөг зарцуулдаг бол зүрх судасны өвчинд 27,660 төгрөгийг дунджаар зарцуулдаг аж. Амьсгалын замын өвчинд зардал гаргаж буй өрхүүдийн 51% нь сард 20,000 хүртэл төгрөгийн зардал, 35% нь сард 20-50 мянган төгрөгийн зардал, 10% нь сард 50-100 мянган төгрөгийн зардал, 5% нь сард 100 мянгаас дээш төгрөгийн зардал уг өвчинд гаргаж байна. Харин зүрх судасны өвчинд зардал гаргаж буй өрхүүдийн 58% нь сард 20,000 хүртэл төгрөгийн зардал, 32% нь 20-50 мянган төгрөгийн зардал, 10% нь сард 50 мянгаас дээш төгрөгийн зардал уг өвчинд гаргаж байна.

Зураг 51. Амьсгалын замын өвчний зардлын бүлэглэлт (n=384) ба тодорхойлох статистик



Зураг 52. Зүрх судасны өвчний зардлын бүлэглэлт (n=101) ба тодорхойлох статистик



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Түлээ, нүүрсний зардал

Судалгаанд оролцсон өрхүүд жилд дунджаар 69 уут түлээ, 4 тонн нүүрс түлдэг байна. Харин хүйтний улиралд сард 16 уут түлээ, 1 тонн нүүрс хэрэглэдэг аж. Эдгээр үр дүн нь ӨНЭЗС-ны үр дүнтэй бараг ижил гарч байна.

Хүснэгт 7. Өрхийн түлээ, нүүрсний дундаж хэрэглээ

	Сарын хэрэглээ				Жилийн хэрэглээ				Дундаж үнэ
	Дундаж	Медиан	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж	Медиан	Хамгийн их	Хамгийн бага	
Түлээний мод, куб метр	1.5	1	3	1	3.1	4	6	1	36,000-45,000
Түлээний мод, уут	16	12	60	4	69	72	120	15	3,000-4,500


Нүүрс, тонн	1	1	1.5	0.3	4	4	8	2	150,000
Нүүрс, шуудай	20	24	36	8	72	60	120	24	3,000- 4,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхүүдийн 36% нь Багануурын нүүрс, 36% нь Налайхын нүүрс, 24% нь хаанахын нүүрс хэрэглэдэгээ мэдэхгүй, 1% нь Таван толгой, Алаг толгойн нүүрс түлдэг бол үлдсэн 3% нь нүүрс түлдэггүй байна.

Өрхийн сар болон жилийн түлээний зардлыг тооцвол түлээнд²¹ сард дунджаар 57,340 төгрөг, жилд дунджаар 214,996 төгрөг зарцуулж байна. Түлээний сарын хэрэглээний хувьд сараар мэдээллээ өгсөн 235 өрхийн 55% нь сард 50 мянга хүртэлх төгрөгийн зардал, 45% нь 50-210 мянган төгрөгийн зардлыг түлээнд зарцуулдаг аж.

Зураг 53. Өрхийн сарын түлээний зардал (n=235²²) ба тодорхойлох статистик



Зураг 54. Өрхийн жилийн түлээний зардал (n=159²³) ба тодорхойлох статистик



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхийн сар болон жилийн нүүрсний зардлыг тооцвол нүүрсэнд²⁴ сард дунджаар 88,950 төгрөг, жилд дунджаар 607,468 төгрөг зарцуулж байна. Нүүрсний сарын хэрэглээний хувьд сараар мэдээллээ өгсөн 163 өрхийн 26% нь сард 75 мянга хүртэлх төгрөгийн зардал, 24% нь 75-100 мянган төгрөгийн зардал, 50% нь 100-157 мянган төгрөгийн нүүрсэнд зарцуулдаг аж.

²¹ Түлээний зардлыг тооцохдоо нэг уут түлээний үнийг 3500 төгрөгөөр тооцов. Түүнчлэн куб.метрээр хэрэглээгээ хэлсэн өрхүүдийг уут руу шилжүүлээ. Ингэхдээ нэг куб.метр түлээг ойролцоогоор 12 ууттай тэнцэнэ гэж үзлээ.


²² Долоо хоног болон сараар мэдээллээ өгсөн өрхүүдийн мэдээллийг ашиглав.

²³ Жилээр мэдээллээ өгсөн өрхүүдийн мэдээллийг ашиглав.

²⁴ Нүүрсний зардлыг тооцохдоо нэг уут нүүрсний үнийг 3500 төгрөг, нэг тонн нүүрсний үнийг 150,000 төгрөгөөр тус тус тооцов.

Нүүрсний сарын зардлыг өрхийн орлогын ангилалтай харьцуулахад үл ялиг эерэг хамааралтай²⁵ хэдий ч статистикийн хувьд ач холбогдолгүй байна. Тодруулбал, орлогын ангилал бүрийн хувьд 50 орчим хувь нь нүүрсний дундаж зардлаас илүүг зарцуулж байна. Харин нүүрсний сарын хэрэглээг сууцандаа дулаалга хийсэн болон хийгээгүй өрхүүдтэй харьцуулан үзэхэд сууцандаа дулаалга хийсэн өрхүүдийн нүүрсний сарын хэрэглээ дулаалга хийгээгүй өрхүүдийнхээс дунджаар 3 уутаар бага байна.

Зураг 55. Өрхийн сарын нүүрсний зардал ($n=163$ ²⁶) ба тодорхойлох статистик



Зураг 56. Өрхийн жилийн нүүрсний зардал ($n=237$ ²⁷) ба тодорхойлох статистик



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Цахилгааны зардал

Судалгаанд оролцсон өрхүүд халаалтын улиралд цахилгаандаа сард дунджаар 52,900 төгрөг, халаалтын бус улиралд дунджаар 37,280 төгрөгийг төлж байна. Халаалтын ба халаалтын бус улирлаас үл хамааран хамгийн олон өрхийн цахилгаандаа төлж буй хэмжээ 30,000 төгрөг ажээ. Халаалтын улиралд өрхүүдийн цахилгааны зардал дунджаар 10,000-15,000 төгрөгөөр өсөж байгаа нь зорилтот хороодын өрхүүд цахилгааныг дулаандаа ямар нэгэн хэмжээгээр ашиглаж байна гэж дүгнэж болохоор байна. Цахилгааныг дулаандаа ашиглаж буй өрхүүдийн олонх нь дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд байна.

Халаалтын улиралд²⁸ судалгаанд оролцсон өрхүүдийн цахилгааны сарын төлбөр дунджаар 52,900 төгрөг, хамгийн ихдээ 350 мянган төгрөг, хамгийн багадаа 10 мянган төгрөг байна.

²⁵ Сарын нүүрсний зардал ба орлогын ангиллын корреляци 0.049

²⁶ Долоо хоног болон сараар мэдээллээ өгсөн өрхүүдийн мэдээллийг ашиглав.


²⁷ Жилээр мэдээллээ өгсөн өрхүүдийн мэдээллийг ашиглав.

²⁸ 9-р сарын дунд үеэс 5-р сарын эх хүртэлх хугацааг хамарна.

Харин халаалтын бус улиралд өрхүүд дунджаар 37,280 төгрөг, хамгийн ихдээ 120 мянган төгрөг, хамгийн багадаа 8 мянган төгрөг цахилгаандаа төлж байна.

Халаалтын бус улиралд цахилгаандаа 25 мянган төгрөг хүртэл зарцуулдаг өрхийн тоо халаалтын улиралд ижил хэмжээний мөнгөн дүн зарцуулдаг өрхийн тооноос 15%-иар их, харин халаалтын улиралд сард 25-50 мянган төгрөг болон 50-75 мянган төгрөгийн зардалтай өрхийн тоо халаалтын бус улирлынхаас харгалзан 3% ба 6%-иар их байна. Түүнчлэн 100,000-аас дээш төгрөгийн цахилгааны зардлыг өрхүүдийн 8% нь халаалтын бус улиралд гаргаж байгаа зэрэг нь зорилтот хороодын өрхүүд цахилгаанаа дулаандаа ашигладаг гэдгийг харуулж байна.

Зураг 57. Өрхийн сарын цахилгааны төлбөрийн бүлэглэлт, халаалтын ба халаалтын бус улирлаар (n=416)



Сарын цахилгааны зардал	Халаалтын улиралд (төгрөг)	Халаалтын бус улиралд (төгрөг)
Дундаж	52,900	37,280
Медиан	40,000	30,000
Хамгийн олон давтагдсан утга	30,000	30,000
Хамгийн их утга	450,000	120,000
Хамгийн бага утга	10,000	8,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Халаалтын улирлын цахилгааны зардлыг өрхийн орлогын ангиллаар авч үзвэл бага орлоготой өрхүүд цахилгаандаа сард дунджаар 44,020 төгрөг, дундаж орлоготой өрхүүд 57,730 төгрөг, дунджаас дээгүүр орлоготой өрхүүд 70,930 төгрөгийг зарцуулж байна. түүнчлэн бага орлоготой өрхүүдийн 80%, дундаж орлоготой өрхүүдийн 67%, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 60% нь 50 мянга хүртэл төгрөгийг цахилгаандаа зарцуулж байна. Харин бага орлоготой өрхүүдийн 20%, дундаж орлоготой өрхүүдийн 33%, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 40% нь 50 мянгаас дээш төгрөгийг цахилгаандаа зарцуулж байна. Эндээс цахилгааныг дулаандаа ашиглаж байгаа өрхүүдийн олонх нь дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд хэмээн дүгнэж болохоор байна.

Зураг 58. Халаалтын улирлын цахилгааны зардлын бүлэглэлт, орлогын ангиллаар (n=392)



Сарын цахилгааны зардал	Бага орлоготой	Дундаж орлоготой	Дунджаас дээгүүр орлоготой
Дундаж (төгрөг)	44,020	57,730	70,930
Медиан (төгрөг)	35,000	40,000	45,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Цахилгааны зардлыг өрхийн сарын нүүрсний хэрэглээтэй харьцуулахад сул сөрөг хамаарал ажиглагдаж байна²⁹. Тодруулбал, өрхийн нүүрсний хэрэглээ өсөх тусам цахилгааны зардал үл ялиг буурч байна. Сард 15 уут хүртэл нүүрс хэрэглэдэг өрхийн цахилгааны дундаж зардал 59,470 төгрөг, сард 16-30 уут нүүрс хэрэглэдэг өрхүүдийн цахилгааны дундаж зардал 44,210 төгрөг, сард 31-45 уут нүүрс хэрэглэдэг өрхүүдийн цахилгааны дундаж зардал 45,600 төгрөг байна.

Түүнчлэн цахилгааны зардлыг өрхийн сууцны хэмжээтэй харьцуулахад сул эерэг хамааралтай³⁰ буюу өрхийн сууцны хэмжээ өсөх тусам цахилгааны зардал үл ялиг өсөж байна.

Хүснэгт 8. Цахилгааны зардал ба өрхийн сууцны хэмжээ

Сууцны хэмжээ		16-30м ²	31-45м ²	46-60м ²	61-75м ²	76-90м ²	91м ² +
Цахилгааны зардал (төгрөг)	Дундаж	43,760	45,200	62,681	69,920	53,450	77,600
	Медиан	36,000	35,000	40,000	48,000	49,000	45,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхийн дээрх 4 төрлийн зардлыг гэр бүлийн төрлөөр ангилан үзвэл эмэгтэй өрхийн тэргүүнтэй болон ганц бие эрэгтэй өрхийн тэргүүтэй гэр бүлүүдийн хувьд бусад гэр бүлийн төрлийн зардлаас төдийлөн бага байгаа явдал ажиглагдахгүй байна. Харин ч эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн боловсролын дундаж зардал, ганц бие эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн цахилгааны дундаж зардал бусад төрлийн өрхүүдээс хамгийн өндөр байна. Гэхдээ эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн цахилгаан ба нүүрсний дундаж зардал, ганц бие эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн эрүүл мэндийн дундаж зардал бусад төрлийн өрхүүдээс хамгийн бага байна.

Хүснэгт 9. Зардлын төрлүүд ба гэр бүлийн төрлүүд

²⁹ Цахилгааны зардал ба нүүрсний сарын хэрэглээний зардлын хоорондын корреляцийн коэффициент -0.1.

³⁰ Цахилгааны зардал ба сууцны хэмжээний хоорондын корреляцийн коэффициент +0.12 байна.

Зардлын төрөл Гэр бүлийн төрөл		Боловсролын зардал (жилд)	Эрүүл мэндийн зардал (сард)	Нүүрсний зардал (жилд)	Халаалтын улирлын цахилгааны зардал (сард)
Эмэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл	Дундаж	1,819,545	69,665	382,800	36,562
	Медиан	1,400,000	50,000	330,000	30,000
Ганц бие эрэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл	Дундаж	1,555,300	40,454	440,000	63,083
	Медиан	1,450,000	30,000	440,000	38,000
Дан гэр бүл ³¹	Дундаж	1,075,658	59,200	448,540	55,540
	Медиан	500,000	40,000	440,000	40,000
Нийлмэл гэр бүл ³²	Дундаж	1,444,800	88,300	506,000	52,703
	Медиан	1,020,000	60,000	495,000	40,000
Хамгийн их утга		Хамгийн бага утга		Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн	

4.2. Өрхийн хадгаламж ба зээл

4.2.1 Өрхийн хадгаламж


Өрхүүдийн зөвхөн 20% хадгаламжтай бөгөөд хадгаламжийн дундаж хэмжээ 2 сая төгрөг байна. Хадгаламжтай өрхүүдийн 30% нь бага орлоготой, 54% нь дундаж орлоготой, 16% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд байна. Хэдийгээр хадгаламжтай өрхийн тоо болон хадгаламжийн хэмжээ бага ч хадгаламжтай өрхүүдийн олонх нь хадгаламжийн дадал, зуршилтай ажээ. Хадгаламжийн олонх нь ирээдүйн хөрөнгө оруулалт, эрсдэлд зориулагдсан бол зөвхөн 6% нь байшин барих, байшингийнхаа засвар өргөтгөлд зориулан хадгалжээ.

Судалгаанд оролцсон өрхүүдийн 80% нь хадгаламжгүй, үлдсэн 20% нь хадгаламжтай ажээ. Эдгээрийн 15% нь хадгаламжийнхаа хэмжээг хэлэхээс татгалзсан, эсвэл мэдэхгүй байна. Иймд зөвхөн нийт өрхийн 5% хувьд л хадгаламжийн хэмжээний мэдээлэл ирсэн бөгөөд эдгээр өрхийн хадгаламжийн дундаж хэмжээ 2 сая төгрөг байна. Хадгаламжтай өрхүүдийн 30% нь бага орлоготой, 54% нь дундаж орлоготой, 16% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд байна.

³¹ Эхнэр, нөхөр, хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл

³² Эхнэр, нөхөр, хүүхдүүд, эмээ, өвөө, хамаатнаас бүрдсэн гэр бүл

Зураг 59. Өрхийн хадгаламж (n=461)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


Хадгаламжтай өрхүүдийн 58% нь Хаан банкинд, 19% нь Хас банкинд, 11% нь Төрийн банкинд, 8% нь Голомт банкинд, үлдсэн 3% нь ХХБ болон Капитрон банкинд тус тус хадгаламжтай ажээ. Нийт хадагалмжийн 70% нь хугацаатай, 30% нь хугацаагүй байна. Хэдийгээр хадгаламжтай өрхийн тоо бага ч гэсэн хадгаламж эзэмшдэг өрхүүдийг хадгаламжийн дадал, зуршил суусан өрхүүд гэж дүгнэж болохоор байна. Учир нь эдгээр өрх хадгаламжтай болоод дунджаар 2 жил, хамгийн ихдээ 8 жил, хамгийн багадаа 3 сар болжээ.

Нийт хадгаламжийн 35% нь хүүхдийн ирээдүйн хөрөнгө оруулалтад, 27% нь ирээдүйн эрсдэлд зориулагдсан, 17% нь орон сууцанд, 13% нь сургалтын төлбөрт, бол зөвхөн 6 хувь нь байшин барих, засвар өргөтгөлд зориулагдсан байна.

Зураг 60. Өрхийн хадгаламжийн бусад мэдээлэл (n=84)



Өрхийн хадгаламжийн зориулалт (n=84)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

4.2.2 Өрхийн зээл

Өрхүүдийн гуравны нэг нь зээлтэй бөгөөд олонх нь цалин, тэтгэвэр, хэрэглээний зээлтэй байна. Нийт зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 5.8 сая төгрөг бол цалингийн зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 6.2 сая, тэтгэврийн зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 4.2 сая төгрөг байна. Зээлийн дундаж хугацаа 2 жил бөгөөд зээлийн эргэн төлөлтөд сард дунджаар 374.8 мянган төгрөг төлдөг ажээ. Зээлтэй өрхүүдийн 21% нь байшин барих, хашаа байшин худалдаж авах, байшингийн засвар өргөтгөлд зээлээ зарцуулжээ.

Судалгаанд оролцсон өрхүүдийн 68% нь зээлгүй, үлдсэн 32% нь зээлтэй ажээ. Эдгээрийн 16% нь цалингийн зээлтэй, 9% нь тэтгэврийн зээлтэй, 5% нь хэрэглээний зээлтэй, үлдсэн 3% нь автомашин, бизнес, орон сууцны зээлтэй аж.

Зураг 61. Өрхийн зээлийн төрөл (n=461)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Зээлтэй өрхүүдийн 12% нь хоёр зээлтэй байна. Эдгээрийн олонх нь тэтгэвэр ба цалингийн зээлтэй байна.

Зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 5.8 сая төгрөг, хамгийн их зээлийн хэмжээ 30 сая төгрөг, хамгийн бага хэмжээ 150 мянган төгрөг байна. Зээлтэй өрхүүдийн 15% нь 1 сая хүртэл төгрөгийн зээлтэй, 27% нь 1-3 сая төгрөгийн зээлтэй, 16% нь 3-5 сая төгрөгийн зээлтэй, 27% нь 5-10 сая төгрөгийн зээлтэй, 15% нь 10 саяас дээш төгрөгийн зээлтэй ажээ.

Зээлийн хэмжээг зээлийн гол төрлүүдтэй харьцуулбал цалингийн зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 6.2 сая, тэтгэврийн зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 4.2 сая төгрөг байна.

Зураг 62. Өрхийн зээлийн хэмжээ (n=135)




Зээлийн гол төрлүүд ба зээлийн дундаж хэмжээ

	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Автомашинны зээл
Дундаж	6,248,930	4,213,590	6,105,000	7,021,430
Медиан	5,000,000	3,000,000	4,000,000	5,000,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Зээлтэй өрхүүдийг орлогын ангиллаар авч үзвэл 50% нь бага орлоготой, 38% нь дундаж орлоготой, 13% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд байна. Бага орлоготой өрхүүдийн зээлийн дундаж хэмжээ 5 сая төгрөг, дундаж орлоготой өрхүүдийнх 6.2 сая төгрөг, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийнх 7.2 сая төгрөг байгаа нь орлогын ангилал өсөх тусам зээлийн хэмжээ өсч байгааг харуулж байна. Түүнчлэн бага орлоготой зээлтэй өрхүүдийн бараг тал нь, дундаж орлоготой өрхүүдийн 38% нь, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 36% нь 3 сая хүртэл төгрөгийн зээлтэй байна.


Зураг 63. Зээлийн хугацаа (n=135)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Зээлийн дундаж хугацаа 2 жил, хамгийн ихдээ 15 жил, хамгийн багадаа 4 сарын хугацаатай байна. Нийт зээлтэй өрхүүдийн 26% нь 1 жил хүртэл, 42% нь 1-2 жил, 17% нь 2-3 жил, 15% нь 3 жилээс дээш хугацааны зээлтэй аж.

Зураг 64. Зээлийн хугацаа (n=135)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Зээлтэй өрхүүд зээлийн эргэн төлөлтөд сард дунджаар 374.8 мянган төгрөг, хамгийн ихдээ 5 сая төгрөг, хамгийн бага хэмжээ 9630 төгрөг төлж байна. Зээлтэй өрхүүдийн 15% нь 100 мянга хүртэл төгрөг, 25% нь 100-250 мянган төгрөг, 36% нь 250-500 мянган төгрөг, 19% нь 500-750 мянган төгрөг, 3% нь 750 мянгаас дээш төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд төлдөг ажээ.

Зээлийн эргэн төлөлтийг зээлийн гол төрлүүдтэй харьцуулбал цалингийн зээлэнд дунджаар 376.8 мянган төгрөг, тэтгэврийн зээлэнд дунджаар 272.8 мянган төгрөгийг сард төлж байна.

Зураг 65. Өрхийн зээлийн эргэн төлөлт (n=135)



Зээлийн гол төрлүүд ба зээлийн эргэн төлөлтийн дундаж хэмжээ

	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Автомашинны зээл
Дундаж	376,860	272,280	332,780	416,700
Медиан	350,000	280,000	250,000	415,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Зээлийн эргэн төлөлтийг өрхийн орлогын хүрэлцээтэй байдалтай харьцуулахад өрхийн орлогын хүрэлцээтэй байдал нэмэгдэх тусам сарын зээлийн эргэн төлөлт өсөх хандлагатай байна. Тодруулбал, өрхийн орлогоо огт хүрэлцдэггүй гэж үнэлсэн зээлтэй өрхүүд сард дунджаар 245 мянган төгрөг, орлогын хүрэлцээгээ дундаас доогуур үнэлсэн зээлтэй өрхүүд сард дунджаар 275 мянган төгрөг, орлогын хүрэлцээгээ дунд зэрэг гэж үнэлсэн зээлтэй өрхүүд сард дунджаар 320 мянган төгрөг, орлогоо хүрэлцээтэй гэж үнэлсэн өрхүүд сард дунджаар 385 мянган төгрөгийг тус тус зээлийн эргэн төлөлтөд төлж байна.

Өрхүүдийн олонх банк, санхүүгийн байгууллагаас зээл авсан байна. Тодруулбал, зээлтэй өрхүүдийн 87% нь банкнаас, 9% нь ББСБ, 1% нь ХЗХ-оос зээл авсан бол үлдсэн 3% нь албан байгууллага болон хувь хүнээс зээл авчээ.

Зээлтэй өрхүүдийн 29% нь өрхийн хэрэглээнд, 18% нь машин худалдаж авахад, 14% нь сургалтын төлбөр төлөхөд, 14% нь сургалтын төлбөрт зээлээ зарцуулсан бол 21% нь байшин барих, хашаа байшин худалдаж авах, байшингийн засвар өргөтгөлд зарцуулжээ.

Зураг 66. Өрхийн зээлийн зориулалт (n=170³³)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

4.3.Өрхийн өмч хөрөнгө ба хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөө


4.3.1 Өрхийн өмч хөрөнгө

Хөдлөх хөрөнгө: Судалгаанд оролцсон өрхүүдийн 54% нь автомашинтай бөгөөд эдгээр өрхөд нийт 252 автомашин байна. Нэг өрх дунджаар 1.2 автомашинтай байгаа бол хамгийн ихдээ 6 автомашинтай өрх байна. Автомашинтай өрхүүдийн 85% нь нэг автомашинтай, 11% нь хоёр автомашинтай, 2% нь 3 автомашинтай, 2% нь 4 автомашинтай, 0.4% буюу нэг өрх 6 автомашинтай аж. Автомашины төрлөөр нь авч үзвэл өрхүүдэд байгаа автомашины 89% нь суудлын автомашин, 10% нь ачааны машин, 1% нь автобус байна. Нийт автомашины 7% нь барьцаанд байгаа ажээ.

Зураг 67.Автомашинтай өрхийн бүлэглэлт, автомашины тоогоор (n=226)

Зураг 68.Автомашины төрөл (n=252)

³³ Нийт 135 өрх 170 хариултыг өгчээ.




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн нийт автомашинтай өрхүүдийн 30% нь бага орлоготой, 54% нь дундаж орлоготой, 15% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд байна. Автомашинтай, бага орлоготой өрхүүдийн 90% нь, дундаж орлоготой өрхүүдийн 85% нь, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 79% нь тус бүр нэг автомашинтай бол 2-оос дээш машинтай өрхүүдийн олонх нь дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд байна.

Үл хөдлөх хөрөнгө: Судалгаанд оролцсон өрхүүдийн 77% нь хашааныхаа газрын өмчилдөг, 17% нь эзэмшдэг, 5% нь тухайн өрхийн өмч биш, 1% нь газрын бичиг баримтгүй байна. Нэг өрх дунджаар 606м² хашааны газартай бол хамгийн ихдээ 1000м² газартай, хамгийн багадаа 134м² газартай өрх байна. Нийт өрхийн 46% нь 650м² хүртэл, 49% нь 650м²-800м², үлдсэн 5% нь 800м²-аас дээш хэмжээний газартай ажээ.


Зураг 69. Газрын хэмжээ (n=416)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Нийт өрхийн 96% нь амьдарч буй сууцаа өмчилдөг бөгөөд тэдгээрийн 77% нь ҮХХ-ийн гэрчилгээтэй, 19% нь гэрчилгээгүй байна. Түүнчлэн сууцаа өмчилдөг өрхүүдийн 9% нь сууцаа зээлийн барьцаанд тавьжээ. Сууцаа өмчилдөггүй өрхүүдээс нэгээс бусад өрх нь бага ба дундаж орлоготой ажээ.

Зураг 70. Өрхийн сууцны өмчлөл ба ҮХХ-ийн гэрчилгээтэй эсэх (n=416)



Зураг 71. Өрхийн сууцны өмчлөл ба барьцаанд байгаа эсэх (n=416)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

4.3.2 Өрхийн хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөө


Судалгаанд оролцсон өрхүүдийн 67% нь ойрын ирээдүйд ямар нэгэн хөрөнгө оруулалтыг төлөвлөгөөгүй бол 24% нь барилга сууцанд, 3% нь боловсролд, 3% машин худалдаж авахад, үлдсэн 2% гадаад руу явах, эмчилгээнд явах, томоохон тэмдэглэлт үйл явдалд хөрөнгө зарцуулахаар төлөвлөж байгаа ажээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгүй өрхүүдийн 54% нь бага орлоготой өрхүүд, 42% нь дундаж орлоготой өрхүүд, 5% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд байна. Харин барилга сууцандаа хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа өрхүүдийн 40% нь бага орлоготой, 40% дундаж орлоготой, 20% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд байна. Эдгээр өрхийн 71% нь 2019-2020 онд, 29% нь 2021-2023 онд сууцандаа хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа аж.

Зураг 72. Өрхийн ойрын ирээдүйд хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (n=416)



Зураг 73. Барилга сууцанд хөрөнгө оруулахаар төлөвлөсөн хугацаа (n=101)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


5. ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

5.1. Сууцны насжилт, зохион байгуулалт, материал

5.1.1 Сууцны насжилт

Судалгаанд оролцсон өрхүүдийн 47% нь сууцаа хэзээ баригдсаныг мэдэхгүй байв. Иймд эдгээр өрхийн сууцны насжилтыг тооцохдоо тухайн өрхийн уг сууцанд амьдарсан жилээр орлуулан тооцлоо. Сууцны дундаж насжилт 11 жил, хамгийн ихдээ 56 жил, хамгийн багадаа жил хүрээгүй сууцнууд байна. Нийт өрхийн 38% нь 0-5 жилийн настай сууцанд, 24% нь 6-10 жилийн настай сууцанд, 13% нь 11-15 жилийн настай сууцанд, 10% нь 16-20 жилийн настай сууцанд, 14% нь 21-ээс дээш настай сууцанд тус тус амьдарч байна.

Зураг 74. Сууцны насжилт (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Сууцны дундаж насыг байшингийн төрөл болон өрхийн орлогын ангиллаар авч үзвэл банз болон модон байшингийн дундаж насжилт бусад төрлийн байшингаас бага зэргийн их байна. Орлогын ангиллын хувьд дундаж орлоготой өрхүүдийн байшин бага ба дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн байшингаас насаар ялимгүй бага байна.

Хүснэгт 10. Сууцны дундаж насжилт, сууцны ханын төрөл ба өрхийн орлогын ангиллаар, жилээр

	Сууцны хананы төрөл					Өрхийн орлогын ангилал		
	Мод	Тоосго	Банз	Хөнгөн блок	Нүхтэй блок	Бага	Дундаж	Дунджаас дээгүүр
Дундаж нас	12	10	19	11	8	12	9.5	11
Медиан нас	9	8	18	7	6	9	6	9.5

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

5.1.2 Сууцны хэмжээ ба зохион байгуулалт

Судалгаанд оролцсон өрхүүдийн сууцны дундаж хэмжээ 47м² бол хамгийн ихдээ 256м², хамгийн багадаа 16м² сууцтай өрхүүд байна. Нийт өрхийн 21% нь 30м² хүртэл, 64% нь 31-60м², 11% нь 61-90м² хэмжээ бүхий сууцтай бол үлдсэн 4% нь 91м²-аас дээш хэмжээтэй сууцтай ажээ. Сууцны хэмжээг орлогын ангиллаар авч үзвэл төдийлөн ялгаа ажиглагдахгүй байна. Түүнчлэн нийт өрхийн 4% нь 2 давхар сууцтай байна.

Зураг 75. Сууцны хэмжээ (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Нийт өрхийн 55% нь нэг өрөө сууц буюу зочин, унтлагын өрөө, гал тогоо нь хамтдаа байдаг байшинд амьдарч байна. Харин 45% нь нэгээс дээш өрөөтэй сууцанд амьдарч байна. Сууцны зохион байгуулалтыг нэг өрөөтэй ба нэгээс дээш өрөөтэй байшингаар нь ангилан авч үзье.

Нэг өрөөтэй сууцны шинжүүд: Энэ төрлийн сууцууд нь дунджаар 41м² хэмжээтэй, урд зүгт харсан хаалгатай, урагшаа харсан 2 цонхтой гэсэн нийтлэг шинжтэй байна.

Хүснэгт 11. Нэг өрөөтэй сууцны шинжүүд (n=226) болон нийтлэг сууцны план зураг

Дундаж хэмжээ	41м2							
Мансарттай эсэх	8%							
Гонхтой эсэх	31%							
Хаалганы харсан зүг	Урд	62%						
	Хойд	4%						
	Баруун	13%						
	Зүүн	21%						
Цонхны харсан зүг	Цонхны тоо							
		0	1	2	3	4	7	9
	Урд	4%	11%	54%	27%	4%	0.4%	-
	Хойд	86%	12%	2%	-	0.4%	-	-
	Баруун	74%	18%	7%	1%	-	-	-
	Зүүн	73%	17%	8%	1%	0.4%	-	0.4%

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Нэгээс дээш өрөөтэй сууцны шинжүүд: Энэ төрлийн сууцууд нь дунджаар 55м² хэмжээтэй, 2-3 өрөөтэй, урд зүгт харсан хаалгатай, урагшаа харсан 2 цонх, баруун ба зүүн тийш харсан нэг цонхтой гэсэн нийтлэг шинжтэй байна. Гурван өрөөний хувьд зочны өрөө, унтлагын өрөө, гал тогоо гэсэн өрөөнүүдтэй, харин хоёр өрөөтэй сууцны хувьд зочны өрөө, гал тогоо гэсэн өрөөнүүдтэй айлууд нийтлэг байна.

Нэгээс дээш өрөөтэй сууцнуудын 92% нь зочны өрөөтэй, 66% нь унтлагын өрөөтэй, 79% нь унтлагын өрөөтэй, 17% нь угаалгын өрөөтэй байна. Түүнчлэн 17 өрх хоёр унтлагын өрөөтэй, 1 өрх гурван унтлагын өрөөтэй байна.

Хүснэгт 12. Нэгээс дээш өрөөтэй сууцны шинжүүд (n=190) болон нийтлэг сууцны план зураг

Дундаж хэмжээ	55м2		Хойд зүг Баруун зүг Зүүн зүг Урд зүг Зочны өрөө Унтлагын өрөө Гал тогоо Ганг ХААЛГА create.ly				
Мансардтай эсэх	8%						
Гонхтой эсэх	48%						
Хаалганы харсан зүг	Урд	73%					
	Хойд	2%					
	Баруун	11%					
	Зүүн	14%					
Өрөөний зохион байгуулалт	Өрхийн тоо (190)	Зочны өрөө	Унтлагын өрөө	Гал тогоо	Угаалгын өрөө		
	10%	+	+	+	+		
	35%	+	+	+			
	4%	+	+		+		
	1%	+		+	+		
	1%		+	+	+		
	9%	+	+				
	35%	+		+			
	8%		+	+			
Цонхны харсан зүг	Цонхны тоо						
		0	1	2	3	4	5
	Урд	3%	15%	46%	30%	4%	2%
	Хойд	80%	14%	5%	1%	-	-
	Баруун	55%	33%	9.5%	1%	0.5%	1%
	Зүүн	52%	38.5%	8%	0.5%	1%	-

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

5.1.3 Сууцны бүтэц


Өрхүүд ерөнхийдөө дараах хоёр төрлийн сууцанд амьдарч байна.

- Тоосгон ханатай, шувуун нуруун дээвэртэй, бетонон шалтай байшин
- Модон ханатай, шувуун нуруун дээвэртэй, модон шалтай байшин

Судалгаанд оролцсон өрхүүдийн 50% нь тоосгон ханатай, 31% нь модон ханатай, үлдсэн 19% нь банз, нүхтэй блок, хөнгөн блокон ханатай башинтай байна. Түүнчлэн нийт өрхийн байшингийн 91% нь шувуун нуруун дээвэртэй, үлдсэн 9% мансардан дээвэртэй ажээ.

Тоосгон ханатай байшингийн 11%, нүхтэй блокон байшингийн 7%, хөнгөн блокон байшингийн 6%, модон байшингийн 5% нь мансардан дээвэртэй бол бусад нь бүгд шувуун нуруун дээвэртэй аж. Материалын хувьд олонх нь төмөр дээвэртэй байна.

Тоосго, нүхтэй болон хөнгөн блокон ханатай байшингуудын олонх нь бетонон шалтай бол мод болон банзан ханатай байшингуудын олонх нь модон шалтай ажээ.



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

5.1.4 Сууцыг барьсан этгээд


Судалгаанд хамрагдсан өрхүүдийн олонх нь өөрсдөө байшингаа барьсан бөгөөд мэргэжлийн байгууллагаар байшингаа бариулах хандлага төдийлөн байхгүй байна. Судалгаанд оролцсон өрхүүдийн 28% нь амьдарч байгаа сууцаа хэн барьсаныг мэдэхгүй байна. Харин нийт өрхийн 65% нь өөрсдөө болон хамаатан, найз нөхөдийн хамтаар, 2.5% нь мэргэжлийн бус бригад, хувь хүмүүсээр байшингаа бариулсан бол зөвхөн 4.5% нь барилгын мэргэжлийн компани болон бригадаар байшингаа бариулжээ.

Сууцыг хэн барьсаныг мэдэж байгаа өрхүүдийг орлого болон сууцны төрлөөр нь ангилахад дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүдийн 9-13% нь байшингаа мэргэжлийн


байгууллагаар бариулсан байна. Харин бага орлоготой өрхүүдэд мэргэжлийн байгууллагад хандсан явдал бараг байхгүй байна. Сууцны төрлийн хувьд бүх сууцны төрлөөс тус бүр 6% нь мэргэжлийн байгууллагаар баригджээ.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан өрхүүдийн 34% нь манайд байшин барих туршлагатай хүн бий гэсэн бол 66%-д нь байшин барих туршлагатай хүн байхгүй байна.

Зураг 78. Сууцыг барьсан этгээд ба орлогын ангилал (n=298*)



Зураг 79. Сууцыг барьсан этгээд ба сууцны ханын төрөл (n=299*)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Тэмдэглэгээ: *-Сууцаа хэн барьсаныг мэдэхгүй байгаа өрхүүдийг хасч тооцов.

Ийнхүү ихэнх тохиолдолд сууцаа өөрсдийн мэдлэг болон эргэн тойрны хүмүүсийн туршлагад тулгуурлан барьснаас үүдэн ихэнх байшингууд стандарт бус, ялангуяа байрны битүүмж байхгүй чийг цан цохьдог, агаар сэлгэлт явагддаггүй, дулаан хадгалалт муу, шал нь тэгш бус гэх мэт асуудлууд нийтлэг тулгардаг нь бүлгийн ярилцлагын үеэр дурдагджээ (2018 оны 10-11 дүгээр сарын ФБЯ).

5.2. Сууцны дулаалга ба дулаан алдагдал


5.2.1 Сууцны дулаалга

Нийт өрхийн зөвхөн гуравны нэг нь л сууцаа дулаалжээ. Иргэдийн дунд тав тухтай өвөлжихийн тулд сууцаа дулаалахын ач холбогдлын талаар ойлголт, мэдлэг сул байна. Зарим бүлгийн ярилцлагын үеэр, өвлийн бэлтгэл гэдгийг зөвхөн нүүрс, түлээгээ бэлтгэх гэж ойлгож буй өрхүүд цөөнгүй байгаа нь ажиглагдсан (2018 оны 10-11 дүгээрс сарын ФБЯ). Сууцаа дулаалсан өрхүүдийн хувьд, дулаалгын материалыг сонгон авахад хамгийн гол нөлөөлдөг хүчин зүйл бол хямд үнэ, зах зээл дэх материалын олдоц аж. Өрхүүд дулаалгаа бараг 100 хувь өөрсдөө хийсэн бөгөөд талаас илүү хувь нь хийсэн дулаалгын чанараа сайн болсон гэж үзэж байна. Сууцаа дулаалахад тулгарч буй гол гурван бэрхшээл

нь санхүү, хүн хүчний дутмаг байдал, цаг завгүй байдал ажээ. Санхүүгийн бэрхшээл тулгарч буй өрхүүдийн 92% бага ба дундаж орлоготой өрхүүд байна.

Судалгаанд оролцсон өрхүүдийн 32% нь сууцандаа дулаалга хийсэн бол 68% нь дулаалга хийгээгүй байна. Дулаалга хийсэн байшингуудын 46% нь тоосгон ханатай, 35% нь модон ханатай, үлдсэн 19% нь бусад төрлийн ханатай байшин байна.


Зураг 80. Дулаалга хийсэн эсэх, байшингийн ханын төрлөөр (n=416)




Дулаалга хийсэн өрхүүдийн 41% нь дулаалгад ашигласан материалыг үнэ хямд учраас, 37% нь гадуур элбэг байдаг учраас худалдан авсан бол үлдсэн 18% нь бусдын туршлага, зөвлөгөө, өөрсдийн хайлтын үр дүнд үндэслэн, үлдсэн 4% нь хэрэглээний хялбар байдал, материалын чанарыг харгалзан худалдан авчээ (Зураг 81).

Дулаалга хийсэн өрхүүдийн 98% нь өөрсдөө хийсэн бол үлдсэн 2% нь мэргэжлийн бригад болон мэргэжлийн бус хүнээр хийлгэжээ. Өрхүүдийн 12% нь хийсэн дулаалгаа маш сайн, 43% нь сайн, 38% нь дунд зэрэг, 8% нь муу болсон гэж үнэлжээ (Зураг 82).

Зураг 81. Дулаалгын материалыг худалдан авахад нөлөөлсөн хүчин зүйлс (n=172*)



Зураг 82. Өрхүүдийн хийсэн дулаалгын чанартаа өгсөн үнэлгээ (n=130)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Тэмдэглэгээ: *-130 өрхийн хариулсан нийт хариултын тоо.


Судалгаанд оролцсон өрхүүдээр сууцаа дулаалахад тулгараад байгаа хоёр гол бэрхшээлийг нэрлүүлэхэд нийт 674 хариулт иржээ. Эдгээрээс сууцаа дулаалахад тулгарч

буй топ гурван бэрхшээл нь санхүү, хүн хүчний дутмаг байдал, цаг завгүй байдал байна. Харин нийт өрхийн 5% нь сууцаа дулаалахад бэрхшээлгүй гэсэн бол 4% нь дулаалга хийхийг ач холбогдолгүй гэж үздэг аж. Санхүүгийн бэрхшээл тулгарч буй өрхүүдийг орлогын ангиллаар авч үзэхэд 57% нь бага орлоготой, 35% нь дундаж орлоготой, 8% нь дунджаас дээгүүр орлоготой байна.

Зураг 83. Дулаалга хийхэд тулгардаг бэрхшээлүүд (n=674)



Санхүүгийн бэрхшээл ба орлогын ангилал (n=280)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон өрхүүдийн 52% нь байшингийнхаа дулаалгыг мэргэжлийн бригадаар хийлгэх сонирхолтой байгаа бол 34% нь сонирхолгүй, 14% нь одоогоор хэлж мэдэхгүй байна. Мэргэжлийн байгууллагаар дулаалга хийлгэх сонирхолтой өрхүүдийг орлогоор ангилан үзвэл 53% нь бага орлоготой, 38% нь дундаж орлоготой, 9% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд ажээ.

Зураг 84. Дулаалгыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх сонирхол(n=416)



Мэргэжлийн байгууллагаар дулаалга хийлгэх сонирхол ба орлогын ангилал (216)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

5.2.2 Сууцны дулаан алдагдал


Өрхүүдийн гуравны хоёр нь сууцныхаа аль нэг газраас дулаан алдагдаж байгаа гэсэн бөгөөд цонх болон хананаас дулаан илүүтэй алдагдаж байна. Нийт өрхүүдийн талаас илүү хувь дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээ авсан бөгөөд хана, цонх, дээврээ илүүтэй дулаалжээ. Ингэхдээ хөөсөнцөр, шилэн хөвөнг түгээмэл ашигласан байна. Хана, дээврийг дунджаар 14 см-ийн зузаантай, шалыг дунджаар 12 см-ийн зузаантай дулаалсан бөгөөд дулаалгын материалаа голдуу жижиглэн худалдаанаас авч ашиглажээ.

Судалгаанд оролцсон өрхүүдийн 24% нь байшингаас нь дулаан алдаагүй, 11% нь дулаан алдаж байгаа эсэхийг мэдэхгүй байв. Харин 65% нь байшингийнхаа аль нэг газраас дулаан алдаж байгаа гэжээ. Эдгээр өрхөөс (272 өрх) байшингийнхаа дулаан алдагдаж байгаа газруудын талаар нийт 427 хариулт ирснээс гуравны нэг нь цонхноос, 24% нь хананаас, хаалга, шал, дээврээс тус бүр 13% нь дулаан алдаж байгаа аж.

Бүлгийн ярилцлагын үеэр дурдсанаар, цонхноос дулаан алдаж буйгийн илрэл нь цан цохих, сийгэх, хөлдөх байдлаар голцуу илэрдэг байна. Цонхноос дулаан алдалт нь модон болон вакум цонхны төрлөөс хамааран төдий л ялгаагүй байна. Сүүлийн үеийн вакум цонхны чанарт иргэд сэтгэл дундуур ба цонхны түгжээ эвдрэх, резин сулрах асуудал түгээмэл аж. Модон цонхны хувьд дулаалга хийх нь ажиллагаа ихтэй, ихэнх тохиолдолд насжсан, үүнээсээ үүдэн завсар гарч сийгдэг байна (2019 оны 2-р сарын ФБЯ).

Түүнчлэн сууцнаас нь дулаан алдаж байгаа өрхүүдийн 47% нь байшингийнх нэг газраас, 45% нь хоёр газраас, 6% нь гурван газраас, 3% нь дөрвөн газраас дулаан алдаж байна. Хоёр газраас дулаан алдаж байгаа өрхүүдийн хувьд “хана ба цонх”, “цонх ба хаалга”, “хана ба шал”, “хана ба дээвэр” зэргээс дулааныг голдуу алдаж байгаа бол нэг газраас дулаан алдаж байгаа өрхүүдийн цонх, хана, шалнаас дулааныг ихэвчлэн алдаж байна.

Зураг 85. Сууцны дулаан алдаж байгаа газрууд (n=427)



Байшингийнх нь дөрвөн газраас дулаан алдаж байгаа өрхүүд 3%

Байшингийнх нь гурван газраас дулаан алдаж байгаа өрхүүд 6%

Байшингийнх нь хоёр газраас дулаан алдаж байгаа өрхүүд 45%

Байшингийнх нь нэг газраас дулаан алдаж байгаа өрхүүд 47%


Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Сууцны дулаан алдаж байгаа газруудыг байшингийн ханын төрлүүдтэй харьцуулбал тоосго, мод, банзан ханан байшинтай өрхүүд цонх ба хананаас илүү дулаан алдаж байгаа гэсэн бол хөнгөн ба нүхтэй блокон ханан байшинтай өрхүүд цонх ба хаалганаас дулаан илүү алдаж байгаа гэжээ.

Бүлгийн ярилцлагад оролцсон өрхүүдийн туршлагаас харахад, байшингийн ар хэсгийн хананаас дулаан алдалт түгээмэл байдаг ба энэ нь дулаалгаа буруу хийсэн, дулаалга нь

нимгэн болсноос үүддэг аж. Гол асуудал нь хананы булангаас сийгэх, хаяагаар сийгэх, чийгтэж ханын цаас нь хуурах асуудал гардаг байна (2019 оны 2-р сарын ФБЯ).

Зураг 86. Сууцны дулаан алдаж байгаа газрууд ба байшингийн ханын төрөл (n=427)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


Судалгаанд оролцсон өрхүүдийн 45% нь дулаан алдагдлыг бууруулах ямар нэгэн арга хэмжээ аваагүй бөгөөд эдгээрийн талаас илүү хувь (52%) нь байшингаасаа дулаан алдаагүй болон дулаан алдаж байгаа эсэхийг мэдэхгүй гэж хариулсан өрхүүд байна.

Ялангуяа өрхүүдийн дунд нийтлэг байгаа туршлага нь дээврийн дулаан алдагдлын талаар ойлголтгүй, дээврийн дулаалга ихэнхдээ хийдэггүй, хийхийн ач холбогдлын талаар мэдлэггүй байна. Түүнчлэн шалны дулаалгыг төдий л хайхардаггүй орхидог тохиолдол элбэг аж (2019 оны 2-р сарын ФБЯ).


Харин өрхүүдийн 55% нь сууцныхаа дулаан алдагдлыг бууруулах талаар ямар нэгэн арга хэмжээ авсан байна. Тодруулбал, эдгээр өрхөөс (227 өрх) байшиндаа дулаалга хийсэн 298 тохиолдол бүртгэгдсэнээс 31% нь ханаа, 26% нь цонхоо, 15% нь дээвэрээ дулаалсан бол үлдсэн 27% нь хаалга, шал, булан тохой зэргийг дулаалсан байна. Дулаалга хийхэд хамгийн түгээмэл ашиглагдсан материал хөөсөнцөр болон шилэн хөвөн байна. Нийт дулаалга хийсэн 298 тохиолдлын 33% нь хөөсөнцөр, 28% нь шилэн хөвөн, 7% нь чулуун ба эрдэс хөвөн ашигласан бол үлдсэн 30% нь бусад төрлийн материал болох үртэс, даавуу, сликон зэргийг ашиглажээ.

Дулаалгад ашигласан материалыг дулаалга хийсэн газруудтай харьцуулахад хана, цонх, булан тохой уулзварын дулаалахад хөөсөнцөрийг, шал ба хаалгыг дулаалахад бусад төрлийн материалыг, дээвэрт шилэн хөвөнг түлхүү ашиглажээ. Дулаалгын материалтай холбоотойгоор, хөөсөнцөр хавтангийн дундуур хулгана гүйх, хөөсөнцөрийн цагаан үйрмэг гэрт орж ирэх, өнгөлгөөний шавар бороо, цасанд урсах асуудал түгээмэл аж. Түүнчлэн байшингийн дулаалгатай холбоотой иргэдийн санааг зовоож буй дараагийн бэрхшээл нь байшингийн агааржуулалтын шийдэл байна. Бүлгийн ярилцлагад орсон өрхүүдийн хувьд нийтлэг агааржуулалтыг орхигдуулсан байсан ба энэ нь агааржуулалтын шийдлийн талаар мэдлэг бага, зах зээл дээр байгаа шийдлүүдийн талаар мэдээлэлгүй, мөн санхүүгийн эх үүсвэргүй байдал нөлөөлдөг байна. (2019 оны 2-р сарын ФБЯ).

Зураг 87. Дулаалга хийсэн газрууд (n=298)




Зураг 88. Дулаалга хийсэн газрууд ба ашигласан материал (n=298)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхүүд дулаалгын материалаа голдуу жижиглэн худалдаанаас авч ашиглаж байна. Тодруулбал, дулаалга хийсэн өрхүүдийн 87% нь жижиглэн худалдааны цэгүүд болох барилгын материалын дэлгүүр, зах, худалдааны төвүүдээс, 9% нь үйлдвэрийн газраас ашигласан материалаа худалдан авдаг гэжээ. Харин 4% нь бусад буюу танил, хамаатнаасаа авсан байна.

Зураг 89. Дулаалгын материал авсан газар (n=298)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Шигтгээ. ... 36см-ийн зузаантай тоосгон ханатай амины орон сууц анх худалдаж авсан, дотор талаас нь 5см зузаан хөөсөнцөр хийсэн. Дотроос нь дулаалах нь муу, гэхдээ тэр үед өвөл хаяанд ирсэн байсан болохоор өөр арга байгаагүй. Дээрээ хучилтын хавтантай. Шалнаасаа их жиндүү. Энгийн ханан нийшинтэй. Өвөлдөө 4 портер нүүрс түлдэг. Дулаалгын материалаа Зуун айл, Хангай зах, Гурвалжин дээрээс авсан. Цонхоо вакум болгосон ч чанар муутай учраас сийгэлт ихтэй байдаг (СХД-ийн 28-р хорооны иргэн, 2018-10-31).

Ерөнхийд нь харвал, сууцаа дулаалж дулаан алдагдалыг багасгах нь нүүрсний хэрэглээ багасгах, цаашлаад агаарын бохирдол бууруулахад хувь нэмэр оруулна гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Хэрэглэхэд хялбар, хямд аргачлалуудын талаар мэдлэг, мэдээлэлтэй байх хүсэл сонирхол их байна.


5.3. Халаалт, цэвэр ба бохир ус

5.3.1 Халаалт

Өрхүүд өвлийн улиралд хоногт дунджаар 3-4 удаа галлаж байна. Галлагааны дундаж тоог сууцандаа дулаалга хийсэн болон хийгээгүй өрхүүдээр харьцуулахад бараг ялгаагүй бөгөөд энэ нь өрхүүдийн өөрсдөө хийсэн дулаалга галлагааны тоог цөөлөхөд төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 50% нь энгийн зуухтай, 40% нь төслийн зуухтай, үлдсэн 10% нь усан халаалтын зуух болон цахилгаан зуухтай ажээ. Нийтдээ арван өрх хоёр төрлийн зуухтай байна. Эдгээрээс түгээмэл нь энгийн ба усан халаалтын зуухны хослол байна.


Зураг 90. Өрхийн зуухны төрөл (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Өрхүүд өвлийн улиралд хоногт дунджаар 3.4 удаа галладаг бол хамгийн ихдээ 8 удаа галладаг өрхүүд байна. Нийт өрхийн 21% нь өдөрт 0-2³⁴ удаа, 60% нь 3-4 удаа, 15% нь 5-6 удаа, 4% нь 7-8 удаа галлаж байна. Байшингийн ханын төрлөөр галлагааны дундаж тоог тооцоход хөнгөн блок ханан байшинтай өрхүүд хамгийн олон буюу хоногт дунджаар 4 удаа, банз болон модон ханан байшинтай өрхүүд хоногт дунджаар 3.5-3.6 удаа, харин тоосго болон нүхтэй блок ханан байшинтай өрхүүдийн хамгийн бага буюу хоногт дунджаар 3.1-3.2 удаа галлаж байна.

Зураг 91. Өвлийн улиралд хоногт галладаг тоо (n=416)



³⁴ Дулаанаа цахилгаанаар шийдсэн зарим өрхүүд галладаггүй ажээ. Ийм өрх 2 байна


Хоногт галладаг дундаж тоо	3.6	3.5	3.2	3.1	4
----------------------------	-----	-----	-----	-----	---

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн галлагааны дундаж тоог сууцандаа дулаалга хийсэн болон хийгээгүй өрхүүдээр харьцуулахад төдийлөн ялгаа ажиглагдсангүй. Тодруулбал, дулаалга хийсэн болон хийгээгүйгээс үл хамааран өрхүүд өвлийн улиралд хоногт дунджаар 3.4 удаа галладаг байна. Галлагааны тоог дулаалга хийсэн болон хийгээгүй өрхөөр харьцуулахад дулаалга хийсэн өрхүүдэд 0-2 удаа галладаг өрхийн эзлэх хувь дулаалга хийгээгүй өрхүүдийнхээс 7%-иар их, 3-4 удаа галладаг өрхийн эзлэх хувь 11%-иар бага, харин 5-аас дээш галладаг өрхийн эзлэх хувь 3%-иар их байна. Өөрөөр хэлбэл, дулаалга хийгээгүй өрхүүдтэй харьцуулахад дулаалга хийсэн өрхүүдийн хувьд хоногт бага галладаг өрхүүдийн эзлэх хувь илүү байгаа ч олон галладаг өрхүүдийн эзлэх хувь мөн илүү байна. Эндээс өрхүүдийн өөрсдөө хийсэн дулаалга галлагааны тоог цөөлөхөд төдийлөн нөлөө үзүүлээгүй гэж дүгнэж болох юм.

Түүнчлэн хана, шал, дээврээ дулаалсан өрхийн хоногийн галлагааны дундаж тоог огт дулаалга хийгээгүй өрхийн дундаж галлагааны тоотой харьцуулахад ялимгүй бага байна.


Зураг 92. Галлагааны тоо ба дулаалга хийсэн эсэх (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Халаах хэрэгслийн хувьд нийт өрхийн 57% нь ханан пийшинтэй, 26% нь зуухны гадаргуутай, 10% нь радиатортой, 6% нь цахилгаан халаагууртай, 0.5% нь шалны халаалттай байна. Өрхийн зуухний төрлийг халаах хэрэгсэлтэй харьцуулахад энгийн зуухтай өрхүүдийн 70% нь ханан пийшинтэй, төслийн зуухтай өрхүүдийн 56% нь ханан пийшин, 33% нь зуухны гадаргуугаар халдаг байна.

Зураг 93. Зуухны төрөл ба халаах хэрэгсэл (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


5.3.2 Цэвэр ба бохир ус

Цэвэр усны эх үүсвэр ба хэрэглээ


Судалгаанд оролцсон өрхүүдийн 61% нь ус түгээх байрнаас, 35% нь зөөврийн усны үйлчилгээнээс, 3% нь хамгаалсан гүний худаг, булагаас унд болон ахуйн хэрэглээний усаа авч хэрэглэдэг бол 1% нь төвийн ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон байна.

Өрхүүд хоногт дунджаар 35 литр ус хэрэглэдэг бол хамгийн ихдээ 125 литр ус, хамгийн багадаа 2.5 литр ус хэрэглэдэг өрхүүд байна. Нийт өрхийн 39% нь хоногт 20 литр хүртэл, 19% нь 21-30 литр, 16% нь 31-40 литр ус хэрэглэж байгаа бол үлдсэн 25% нь хоногт 41 литрээс дээш хэмжээний ус хэрэглэж байна.

Зураг 94. Ундны эх үүсвэр (n=416)



Зураг 95. Өрхийн хоногийн унд болон ахуйн хэрэглээний усны хэмжээ (n=416)



Дундаж: 35.1л

Медиан: 26л

Хамгийн олон давтагдсан утга: 20л

Хамгийн их утга: 125л


Хамгийн бага утга: 2.5л

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Бохир усны зайлуулалт ба усанд ордог газар

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 56% нь нийтийн халуун усанд, 39% нь гэртээ, 5% нь айлд очиж усанд ордог байна.

Өрхүүдийн 83% нь бохир усны эсвэл жорлонгийн цооног руу, 12% нь соруулдаг бохир усны цооног руу, 5% нь ил задгай бохироо асгадаг бол 1 (0.3%) өрх төвлөрсөн шугамаар бохироо зайлуулдаг ажээ.



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


6. ӨРХИЙН СУУЦНЫ ЦААШДЫН СОНИРХОЛ

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан өрхүүдийн одоогийн амьдарч буй сууцандаа өөрчлөлт шинэчлэлт хийх ямар хүсэл сонирхол, төлөвлөгөөтэй байгаа талаар тодрууллаа.

6.1. Сууцны цаашдын төлөвлөгөө

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн нийтлэг сонирхол нь одоогийн энэ байршилдаа амьдрах байна. Тодруулбал судалгаанд оролцогсдын 28% нь орон сууц руу нүүх сонирхолтой байгаа бол үлдсэн 72% нь байр сууцаа засах өргөтгөх (31.5%), шинээр байшин барих (4.8%) эсвэл одоогоор ямар нэг төлөвлөсөн зүйлгүй байна (31.5%).

Зураг 98. Одоогийн амьдарч буй сууцаа цаашид хэрхэх вэ? (n=416)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Орон сууцанд нүүхээр сонирхож буй гэж хариулсан 28%-ийг орлогын түвшнээр нь нарийвчилж харвал, тэдний тэн хагас нь (14%) нь бага орлоготой, гуравны нэгээс ялимгүй их (10%) нь дунд орлоготой өрхүүд байгаа бол өндөр орлоготой өрх ердөө долооны нэг нь (4%) байна. Ам бүлийн тоогоор нь задалж харвал, 1-5 ам бүлтэй өрхүүд дийлэнх нь ба тэр дотроо дөрвөн ам бүлтэй өрх олонхийг бүрдүүлж байна. Тиймээс орон сууц рүү нүүнэ гэж буй өрхүүдийн төлөвлөгөөг орлоготой нь уялдуулаад харахад орон сууц рүү нүүх өрхийн тоо бодит байдал дээр тийм ч олон байж чадахааргүй байна.

Өрхүүдийн дийлэнх (72%) ойрын хугацаанд буюу 2019-2020 онд амьдарч буй сууцандаа өөрчлөлт хийхээр төлөвлөж байна.

Зураг 99. Төлөвлөж буй он, %



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


6.2. Дулаан алдагдлыг бууруулахад авах арга хэмжээ

Өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулахад ямар арга хэмжээ авах талаар тоон судалгааны үр дүнгээс харахад эхний ээлжинд иргэд цахилгаан халаагуур тавихыг хамгийн ихээр сонгосон байна. Хоёр дахь арга хэмжээгээр дулаалгыг, тэр дундаа цонх, хана, шалны дулаалгыг сонгосон байна.

Зураг 100 Дулаан алдагдлыг бууруулах авах арга хэмжээ #1



Зураг 101 Дулаан алдагдлыг бууруулах авах арга хэмжээ #2



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Цахилгаан халаагуурыг иргэдийн хувьд нэгдүгээр сонголтоор түлхүү (44%) сонгосон ба голлох шалтгаан нь цахилгаан халаагуурт төлж буй нэг сарын зардал нь нэг портер нүүрсний үнэтэй үндсэндээ адил байгаатай холбоотой. Цахилгааны төлбөрт нэг сарын 150-200 мянган төгрөг төлдөг жишиг байна (2018 оны 10-11-р сарын ФБЯ). Гэхдээ цахилгаан халаагуурын хэрэглээг хязгаарлаж байгаа цөөнгүй шалтгаанууд байна. Түүн

дотроо нэгдүгээрт, амьдарч буй байршлийн цахилгааны хүчдэлийн чадал муу, цахилгааны монтажны чанар муудсан зэргээс үүдэлтэй галын аюул гарах эрсдэл, хоёрдугаарт, цахилгааны үнэ тариф өндөр, цахилгаан халаагуур авах, суурилуулах зардал өндөр буюу санхүүгийн гачигдал голлох шалтгаан нь болдог аж. Фокус бүлгийн ярилцлагын үеэр иргэдийн зүгээс дараах шалтгаануудыг голлон нэрлэж байсан (2019 оны 2-р сарын ФБЯ).

Сүхбаатар дүүргийн ФБЯ:

- Амьдарч буй байршлийн цахилгааны чадал муу.
- Монтажны утас дийлдэггүй.
- Халаагуур авч чадах айл цөөхөн.
- 1 Квт-ын үнэ их байна.
- Улсаас шөнийн тарифыг тэгэлсэн хирнээ тэр нь их амархан дуусдаг.
- Шөнийн тариф мөн өндөр байна.
- Агаарыг шатаана. Галын аюултай.
- Ханын пийшинтэй учир халаагуурын шаардлага байхгүй.
- Цахилгаан тэглэх цагийн хуваарь буруу байна.

Сонгинохайрхан дүүргийн ФБЯ:

- Галын аюултай. Цахилгааны утас олон жил болсон.
- Цахилгааны үнэ өндөр.
- Тоолуураа хянаж чаддаггүй.
- Цахилгаан халаагууртай айл тоолуураа сайн хянах хэрэгтэй.
- Цахилгааны зардалд хэмнэлт хэрхэн гарч байгааг мэддэггүй.
- Шөнийн тарифийн талаар сайн мэдэхгүй.
- Жижиг байшинтай учраас түлээ түлээд сурсан.
- Дулаанаа сайн шийдэхгүй бол халаалт тавьсан ч нэмэргүй.

Дулаан алдагдлыг сайжруулах чиглэлд иргэдийн сонгож байгаа **дараагийн шийдэл нь зуух, пийшингээ солих**, сайжруулах сонголт байна. Айл өрхүүдийн дунд хамгийн түгээмэл хэрэглэгдэж байгаа нь нам даралтын зуух, ханын пийшин, утаагүй зуух (төслийн зуух) байна. Тухайн өрхийн хэрэглэж дадсан байдлаас хамааран иргэд харилцан адилгүй аль аль төрлийн зууханд давуу болон сул тал байгааг дурдаж байсан.

Судалгааны хүрээнд, бүлгийн ярилцлагын үеэр утаагүй гэж нэрлэж заншсан төслийн зуухны хэрэглээ яагаад сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын өрхүүдэд буурч байгааг тодруулсан. Иргэдийн зүгээс уг зуух сайн халдаг боловч түлшний хэрэглээ өндөр, дулаан барилт муу, галлагаа нь хялбар биш, манай орны ахуй нөхцөлд тохироогүй гэх мэт олон шалтгааныг дурдаж байсан. Түүн дотроо уг зуух нь байшин гэхээсээ илүү Монгол гэрийн хэлбэр, зохион байгуулалтад илүү тохиромжтой, тиймээс хөдөө орон нутаг руу худалдаалагддаг тохиолдол нийтлэг жишиг болсныг дурдаж байлаа. Фокус бүлгийн ярилцлагын үеэр дараах шалтгаануудыг голлон нэрлэж байсан.

Сүхбаатар дүүргийн ФБЯ:

- Их мод ордог.
- Үнс буулгадаг юм нь хугараад унасан учир ахиад хэрэглэх боломжгүй болсон.
- Крант нь хагарчихдаг. Цантсан хүйтэн нүүрс хийхээр хагардаг.
- Ахуйн нөхцөлд тохироогүй.

Сонгинохайрхан дүүргийн ФБЯ:

- Ашиглалт нь хэцүү. Өрхийн гишүүн болгон хэрэглэж чадахгүй. Ихэнх хүмүүс ашиглаж чадахгүй.
- Халаалт муу. Их халаад хурдан хөрдөг.
- Ханан пийшинд тавьхад түлш их


- Дээрээсээ түлдэг нь тогоо тавьж болдоггүй.
- Зориулалт нь Монголд тохироогүй. Турк улсдаа тохирдог байх.
- Утаа багассан юм байхгүй.
- Адилхан утаа гарна. Тиймээс хүмүүс хэрэглэхээ больсон.
- Ханын пийшингээ буудуулсан. Тохиромжгүй.
- Төслийн зууханд нүүрснүүдийн чанар их өөр. Түлэхэд өөр өөр байдаг.
- Бүгд хөдөө явсан.

- ордог.
- Буудуулж байсан. Аюултай.
- Энгийн пийшинг бодвол байн байн галладаг.
- Том талбайтай байшинг халаадаггүй.
- Үнс буулгадаг ширэм нь хагардаг.
- Түүхий нүүрс түлэхээр дулаанаа барих нь муу. Харин сайжруулсан түлш дулаанаа сайн барьдаг. Харин үнс юу ч үлддэггүй. Үнэ нь арай өндөр.
- Хөдөө рүү зардаг.

Иргэдийн дараагийн сонгож буй арга нь байшингаа дулаалах сонголт байна. Хамгийн түгээмэл туршлага нь ханаа дулаалдаг бол дээвэр болон шалны дулаалгын талаар, хэрхэн дулаалах арга ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл багатай байгаа нь бүлгийн ярилцлагын үеэр тод ажиглагдаж байсан.

Иргэд өөрийн байшингийн одоогийн нөхцлөөс үл хамааран, үнэ боломжийн нөхцөлд аль боломжит хэмжээнд өнгө үзэмж сайтай, иж бүрэн дулаалгын шийдэл сонирхох хандлагатай байна. Үүнийг бүлгийн ярилцлагын эхэн хэсэгт, иргэдээс амьдарч буй орон сууцных нь хувьд дараах гурван бүрэлдэхүүн (1. Өнгө үзэмж, 2. Дулаан, тохь тухтай байдал, 3. Эрчим хүч, түлшний хэмнэлттэй байдал) хэр чухал ач холбогдолтой болохыг 1-10 оноогоор оролцооны аргаар үнэлүүлсэн ба бүлгийн дундаж оноо хоёр дүүргийн хувьд тун төстэй байсан. Иргэдийн хувьд байшиндаа засвар шинэчлэлт хийхэд дулаан, тохь тухтай байх нь чухал боловч, гадна өнгө үзэмж сайтай байх нь түүнээс дутахгүй ач холбогдол өгч байна. Хэдийгээр эрчим хүч, түлээ бага хэрэглэдэг байхыг ялгаагүй чухалчилж байгаа ч нөгөө хоёр үзүүлэлтээс 1-1.5 пунктээр бага үнэлгээ өгсөн байна.

Зураг 102 Байшингийн засвар, шинэчлэлтэд харгалзах хүчин зүйлс





Үзүүлэлт	СХД	СБД	Дундаж
Өнгө үзэмж	9.4	8.3	8.8
Дулаан, тав тух	10	8.9	9.4
Эрчим хүч, түлшний хэмнэлт	7.4	8.4	7.9

Дулаалгын шийдлүүдийн талаарх сонирхол: Иргэдээс дулаалгын шийдэл авахаар бол байшингийнхаа аль хэсгийг дулаалах талаар БЭХХТ-өөс санал болгосон таван төрлийн шийдэл дээр саналыг нь тодруулсан. Бүлгийн ярилцлагад оролцогчдоос орох багцаар ялгаатай 5 төрлийн шийдэл дээр сонголт хийлгэсэн ба нийтлэг Шийдэл #3, 4 болон 5-ыг сонгох хандлагатай байна.

- Шийдэл #1 болон 2-оос ялгаатай нь дараагийн гурван шийдэл нь агааржуулалтыг багтаасанаараа иргэдийн сонирхлыг түлхүү татаж байна.
- Шийдэл #4-ийн сонирхож байгаа иргэдийн хувьд энэ нь өмнөхөөс цонхны дулаалгыг нэмж оруулж ирсэнээрээ давуу гэж үзэж байна. Гэхдээ хараахан Шийдэл #5-ийг авч чадахгүй байгаа шалтгаан нь шал, суурийн дулаалга авбал зардал өндөр тусна, ажиллагаа их гэсэн шалтгаан голлох нөлөөтэй байна.
- Шийдэл #5-ийг сонирхож буй айлуудын хувьд байшингийн сууриуд харилцан адилгүй байдаг, суурь хамгийн чухал, нэгэнт төсөлд хамрагдаж, хөрөнгө зарцуулж хийж байга учир цогцоор нь хийсэн нь дээр гэсэн шалтгаан гол түлхэц болж байна.

Хүснэгт 13. Тодорхойлсон техникийн шийдлүүд ба иргэдийн сонголт хийх эрэмбэ

Шийдэл	Шийдэл #1 • Дээврийн хучилт	Шийдэл #2 • Дээврийн хучилт • Цонхны дулаалга	Шийдэл #3 • Дээврийн хучилт • Хананы дуулга • Агааржуулалт	Шийдэл #4 • Дээврийн хучилт • Хананы дулаалга • Цонхны дулаалга • Агааржуулалт	Шийдэл #5 • Дээврийн хучилт • Хананы дулаалга • Цонхны дулаалга • Агааржуулалт • Шал, суурийн дулаалга
					
Сүхбаатар дүүрэг	1	1	1	5	5
Сонгинохайрхан дүүрэг	1	2	5	3	7
Нийт	2	3	6	8	12

Түүнчлэн, 2018 оны намар хийгдсэн цуврал бүлгийн ярилцлагууд болон энэ удаагийн уулзалтуудад нийтлэг ажиглагдсанаар, өрхүүд зах зээл дээр зарагдаж буй дулаалга болон халаалтын шийдэл, бараа материалын талаар сурталчилгаа багагүй хүлээн авдаг ч, яг алийг нь авч хэрэглэх, хэрхэн ашиглах талаар тодорхой мэдээлэл байдаггүй байна. Энэ нь


уулзалтын үеэр танилцуулсан дээрх шийдлүүдийн талаар сонирхож лавшруулан асууж байснаас харагдана. Тиймээс төслийн хүрээнд боловсруулж буй шийдлүүдийн талаар дэлгэргүй заавар, хаанаас ямар үнэтэй худалдан авах боломжтой гэх мэт мэдээллийг иргэдэд ойрхон хэлбэрээр түгээх хэрэгцээ их байна (2018 болон 2019 оны ФБЯ).

Ингэхдээ, сонгосон хорооны нутаг дэвсгэрт загварын байшин барих нь зорилтот бүлгийн иргэдэд мэдээллээ илүү оновчтой хүргэхэд чухал үүрэгтэйг дурдсан байна. Түүнчлэн, иргэд олноор үйлчлүүлдэг дэлгүүрт мэдээллээ байршуулах, залуучууд руу нийгмийн сүлжээг ашиглах, хэсгийн ахлагч нартай ойрхон ажиллах, (гэхдээ зарим оролцогч нар хэсгийн ахлагч нар зөвхөн идэвхтэй айлууддаа мэдээлэл өгч байна энэ нь хязгаарлагдмал хүрээг хамарч байгааг анхааруулсан) эсвэл хорооны нутаг дэвсгэрт (ойрхон дунд сургуулийн зааланд) амралтын өдөр хүмүүсийг цуглуулж мэдээлэл өгвөл илүү өргөн хүрээнд хүрэх боломжтойг онцолж байсан (2018 болон 10-11 дүгээр сарын ФБЯ).

6.3. Санхүүгийн боломж, сонирхол

Байр, сууцандаа ямар нэгэн өөрчлөлт, шинэчлэлт хийхээр болсон тохиолдолд санхүүгийн шийдвэр гаргах сонирхол ямар байгааг тодруулсан. Ингэхэд иргэдийн гуравны нэг нь хэрхэн шийдэх талаар тодорхой байр суурьгүй, ойролцоогоор тэн хагас нь ямар нэг хэлбэрээр урьдчилж өөрөө төлөх, дөрөвний нэг орчим нь ямар нэг хэлбэрийн зээлийн эх үүсвэр рүү хандана гэсэн хариулт өгчээ.

Зураг 103 Санхүүжилтийг хэрхэн шийдэх (n=416)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


Үүн дотроо дулаалгаанд тусгайлан, “хэрвээ танай өрхийн түлшний зардал багадаа 20 хувиар буурах боломжтой бол та дулаалганд мөнгө зарцуулах уу” гэсэн асуултанд зарцуулахгүй гэж 27%; зарцуулна, өөрөө бүхэлд нь төлнө гэж 19%; зарцуулна, тодорхой хэсгийг зээлээд, үлдсэнийг өөрөө төлнө гэж 37%; мэдэхгүй гэж 18% нь хариулжээ. Өрхүүдийг байшингаа дулаалахад хөрөнгө оруулалт хийхээс хязгаарлаж буй голлох шалтгаан нь санхүүгийн гачигдалтай байдал байна. Тэр дундаа тогтмол орлогогүй өрхүүдийн хувьд барьцаа хөрөнгө гол санааг нь зовоосон асуудал болж байна.

Түүнчлэн, 2018 оны намар хийгдсэн бүлгийн ярилцлагын үеэр Сүхбаатар дүүргийн зарим өрхүүд дахин төлөвлөлтөнд орох байх гэсэн хүлээлттэй (зарим өрхүүдийн хувьд 8 жил


хүлээж байгаа тохиолдол байна) байгаа нь санхүүгийн томоохон шийдвэр гаргахаас болгоомжлох, азнах нөхцөл болоод байгаа аж.

Өрхүүдийн 54% нь 2 хүртэл сая төгрөгийг дулаалганд зарцуулах боломжтой гэжээ.

Зураг 104 Дулаалганд мөнгө зарцуулах эсэх (n=416)



Зураг 105 Зарцуулах боломжтой мөнгөн дүн



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Шигтгээ. ... Дундаж байшинд хамгийн дээд тал нь 6 сая төг байхад хангалттай хөрөнгө оруулалт болно. Заримд нь 2 сая ч болно. Тухайн үед хэдэн төгрөг хуримтлуулбал хамгийн түрүүнд амьдрах байшингаа л тордож тав тухтай, үр хүүхэд эрүүл өсөх орчин бүрдүүлэхийг бодно. Материалаа авчихвал мэддэг чаддаг хүнээр заалгаад өөрсдөө л дулаална, сэтгэлээсээ хийж чадна. Дундаас нь материал, үйлчилгээний үнэ өртөг хэт нэмчихнэ гэж болгоомжлох юмгүй. Стандартын дагуу зах зээлийн үнээр материалын үнэ зэрэг дээр хэт их нэмэлтгүй байвал хийлгэх айл ч байгаа – бүгд өөрсдөө хийх чадваргүй (СХД-ийн 28-р хорооны иргэн, 2018-10-31).

Техникийн шийдэл ба түүнд төлөх санхүү: Тодорхойлсон техникийн шийдлүүдэд сонголт хийхэд санхүүгийн санал болгож буй үнэ, төлбөрийн нөхцлийг иргэд голлон сонирхож байсан. Фокус бүлгийн ярилцлагад оролцсон иргэдийн хувьд боломжийн нөхцөлтэй санхүүжилтийн эх үүсвэр байгаа тохиолдолд байшингаа дулаалахад хөрөнгө оруулалт сонирхол нийтлэг ажиглагдсан. Ярилцлагын үеэр, иргэдээс болзмол байдлаар 50 м² байшиндаа дулаалгын шийдэл авахаар болвол санхүүгийн ямар нөхцөл хамгийн дөхөмтэй талаар хэлэлцсэн. Хэлэлцүүлгийн үр дүнг доорх хүснэгтээр харуулав. (2019 оны 2-р сарын ФБЯ).

Хүснэгт 14. Тодорхойлсон техникийн шийдлүүд ба иргэдийн сонголт хийх эрэмбэ

Үзүүлэлт	Утга	Санал
Талбайн хэмжээ	50 м ²	Болзмол
Нийт үнэ	5-7 сая	Тодорхойлсон техникийн шийдлүүдийн иж бүрэн хувилбар “Шийдэл 5”-ийг өөрсдөө хийх нөхцөлтэйгээр 5 сая, бригадаар хийлгэх нөхцөлтэйгээр 7 сая төгрөг гэсэн үнийн дүнг иргэд боломжийн гэж үзэж байна. Дулааны алдагдал шийдэгдэж, тав тухтай амьдарч эхэлбэл энэ дүнгээр хөрөнгө оруулах сонирхол байна. Гэхдээ өмнөх 2018 оны намар хийгдсэн бүлгийн ярилцлагын үеэр оролцогчид 1-2 сая төгрөг зарцуулах боломжтой гэж байсан үр дүн байгаа ба энэ удаагийн бүлгийн ярилцлагад шийдүүдийг тодорхой танилцуулан, ач холбогдлыг нь тайлбарласан нь 5-7 сая төгрөгийг боломжийн гэж үзэхэд нөлөөлсөн байх талтай. Гэхдээ цөөн тооны иргэд энэ дүнг жаахан өсгөн 10 сая төгрөгөөр шинэ байшин барих боломжтой, тиймээс үнэтэй биш үү гэсэн санал гаргаж байсан ба, өнөөгийн зах зээл дэх барилгын материалын үнийн талаар ямар мэдээлэлтэй байгааг тодруулах шаардлагатай.
Зээлийн хүү	1%	Санал болгож буй 1%-ийн хүүн дээр иргэдийн зүгээс ямар нэгэн санал байхгүй, бүрэн зөвшөөрч байна.
Хугацаа	30-36 сар	Нийтлэг хоёр дүүргийн бүлгийн ярилцлагаас иргэд илүү урт хугацаатай зээлийн үйлчилгээг сонирхож байна. 36 сар буюу 3 жилийн хугацааг хамгийн тохиромжтой гэсэн саналыг түлхүү хэлж байсан. Тиймээс 30 хүртэлх сарын хугацаатай хэрэглээний зээлээс илүү, түүнээс дээш хугацаатай ипотекийн зээлтэй дөхүү зээлийн бүтээгдэхүүнийг илүү сонгох хандлагатай байна. Урт хугацааг сонирхож буй гол шалтгаан нь сард ноогдох төлбөрийн хэмжээг аль болох бага байлгах сонирхол ажээ.
Сарын төлбөр	220,000 – 305,000 төг	Сард төлөх төлбөрийн хэмжээг тогтоохдоо өрхийн орлоготой (ажил эрхлэлттэй) уялдаатай тогтоохоор байна. Тэтгэврийн насны хүмүүсийн хувьд сард дээд тал нь 170,000-200,000 төгрөгийг боломжийн гэж үзэж байгаа бол, дунд насны ажил эрхэлдэг өрхүүдийн хувьд 300,000 хүртэл төлөх боломжтой байна.

Иргэдийн зүгээс дээрх бүлгийн ярилцлагаар тодруулсан нөхцлийн дагуу, санхүүгийн зуучлалын үйлчилгээнд хамрагдаж, зах зээл дээрээс боломжийн үнэтэй, чанар сайтай барилгын дулаалгын материалаар байшингаа тодорхой зааварчилгааны дагуу өөрсдөө дулаалах, нарийн ажилбартай хэсэгт мэргэжлийн бригадын үйлчилгээ авах төсөлд хамрагдах сонирхол, бодит хэрэгцээ газар дээр байна. Энэ нь өмнөх 2018 оны 10 болон 11 дүгээр сард хийгдсэн ФБЯ-ын үеэр мөн ажиглагдсан үр дүнтэй нийцэж, үүгээр бататгагдаж байна.

Гэхдээ, хөнгөлөлттэй зээлэнд хамрагдан, дулаалгын шийдэл хэрэгжүүлэхээр хүлээж авч байгаа айл өрхөд хариуцлагын тогтолцоо бий болгох хэрэгтэйг дурдаж байсан. Төсөлд хамрагдах өрхүүд өөрсдийн боломжид таарсан хугацаа болон сарын эргэн төлөлт бүхий,

бага хүүтэй зээл авч дулаалгаа хийгээд/хийлгээд эргэн төлөлтөө найдвартай төлөөд явбал төсөл амжилттай хэрэгжиж, илүү олон өрхүүдэд боломж нээгдэх талаар мөн дурдсан (2018 оны 10-11-р сарын ФБЯ).

ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан өрхүүд

Сүхбаатар ба Сонгинохайрхан дүүргийн зорилтот 11 хорооны 416 өрх судалгаанд хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан нэг өрх дунджаар 4 ам бүлтэй, дунджаар 1.5 хүүхэдтэй бөгөөд нийт өрхүүдийн 39% нь өндөрт настантай, 7% нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй ажээ. Түүнчлэн нэг өрхөд дунджаар хөдөлмөр эрхлэх боломжтой 2 хүн байна.

Нийт өрхийн 14% нь гэр бүлийн төрлийн хувьд эмзэг төвшинд хамаарагдаж болохуйц өрхүүд байна. Тодруулбал, нийт өрхийн 11% нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй, 3% нь ганц бие эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүд ажээ.

Өрхүүдийн олонх нь залуу ба дундаж насны гэр бүлүүд байна. Гэхдээ өрхийн тэргүүний боловсролын түвшин доогуур буюу нийт өрхийн тэргүүний 66% нь бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой, 7% нь огт боловсролгүй байна. Өрхийн тэргүүний боловсролын түвшин доогуур байх тусам өрхийн орлого бага байна.

Өрхийн насанд хүрсэн гишүүдийн тал нь хувийн секторт, 15% нь төрийн байгууллагад ажиллаж байгаа бол үлдсэн 34% нь одоогоор ажил эрхлээгүй байна. Ажил эрхэлж буй гишүүд худалдаа, үйлчилгээ, барилга, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, эрчим хүч, боловсрол, эрүүл мэндийн салбарт голдуу ажиллаж байна.

Нийт насанд хүрсэн гишүүдийн 46% нь НДШ төлдөг бөгөөд төрийн байгууллагад ажилладаг гишүүд бүгд НДШ төлдөг, хувийн байгууллагад ажилладаг гишүүдийн 67% нь НДШ төлдөг, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 40% нь НДШ төлж байна.

Өрхөд аливаа томоохон худалдан авалт болон хөрөнгө оруулалтын шийдвэрийг голдуу өрхийн тэргүүн, эхнэр гаргадаг бөгөөд тэд ихэвчлэн хоорондоо ярилцаж, хамтын шийдвэр гаргадаг ажээ.

Агаарын бохирдлын талаарх мэдлэг, хандлага

Өрхүүдийн агаарын бохирдлын талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлохдоо агаарын чанарын гол хэмжүүрийг мэддэг эсэх, агаарын бохирдол юунаас үүсдэг болох, гол хор хөнөөл нь юу болох, хэрхэн бууруулах боломжтой зэргийг харгалзан үзлээ.

Агаарын чанарын гол хэмжүүр: Агаарын чанарын хэмжүүрийн талаарх анхан шатны мэдлэг тааруу байна. Өрхүүдийн 51% нь АЧИ-ийн талаар сонсож байсан гэж хариулсан ч тэдгээрийн олонх АЧИ-ийг тайлж ойлгох анхан шатны мэдлэггүй байв.

Агаарын бохирдлын эх үүсвэрүүд: Агаарын бохирдлын гол эх үүсвэрүүдийн талаарх мэдлэг сайтай байна. Өрхүүдийн олонх нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын хамгийн гол эх үүсвэрийг гэр хорооллын өрхүүдийн нам даралтын зуухны утаа, дараагийн эх үүсвэрээр авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт утааг нэрлэжээ.

Агаарын бохирдлын хор хөнөөл: Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөний талаарх анхан шатны мэдлэг сайтай байна. Түүнчлэн өрхүүдийн 72% нь агаарын бохирдлоос үүдэн эрүүл мэндээрээ хохирч байгаа гэсэн бол 25% нь эдийн засгийн хувьд хохиролтой байна гэж үзжээ. Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалахын тулд талаас

илүү хувь нь амны хаалт зүүж байгаа нь агаарын бохирдлоос өөрийгөө хамгаалах хандлага үүсэж буйг харуулж байна.

Агаарын бохирдлыг бууруулахад оруулах хувь нэмэр: Цахилгаан халаагуур хэрэглэх, байшингаа дулаалж нүүрсний хэрэглээгээ бууруулах явдал нь гэр хорооллын амины сууцтай өрхүүдийн хувьд агаарын бохирдлыг бууруулахад хамгийн тохиромжтой гэж үзсэн байна. Өрхийн орлогын бүлгээр авч үзвэл бага орлоготой өрхүүд байшингаа дулаалах, сайжруулсан түлш хэрэглэх, цахилгаан халаагуур хэрэглэхийг өөрт тохирно гэж үзэж байгаа бол дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд сайжруулсан түлш хэрэглэх, цахилгаан халаагуур хэрэглэх, хашаандаа мод тарих, орон сууцанд орох замаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.

Дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлага

Өрхүүдийн дулаан алдагдлын талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлохдоо гэрээ дулаан байлгахад юу хийх хэрэгтэй талаар, гэрээ дулаан байлгахад юу хийсэн, гэртээ дулаахан өвөлжиж байгаа эсэхийг харгалзан үзлээ.

Гэрээ дулаахан байлгах мэдлэг: Сууцаа дулаалах, дулаан алдагдлыг бууруулах талаарх мэдлэг тааруу байна. Өрхүүдээс гэрээ дулаахан байлгахад юу хийх талаар асуухад тал хувь “галаа түлнэ”, “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн нь орон гэрээ дулаалах, түлшний хэмнэлтийн талаар мэдлэггүйг харуулж байна. Түүнчлэн өрхийн орлогын түвшнөөс хамаараад сууцаа дулаалах, дулаан алдагдлыг бууруулах мэдлэг бага зэрэг ялгаатай байв.

Гэрээ дулаалсан эсэх: Гэрээ дулаан байлгах, сууцны дулаан алдагдлаа бууруулах хандлага хангалттай биш байна. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь мэдлэгийн дутмаг байдал болон орлогын хүрэлцээгүй байдал юм. Тодруулбал, судалгаанд оролцогчдын бараг тал хувь (46%) нь сууцандаа огт дулаалга хийгээгүй бөгөөд эдгээрийн 62% нь гэрээ дулаан байлгах талаар мэдлэггүй бол 87% нь дунд ба түүнээс доош орлоготой өрхүүд байна.

Гэртээ дулаахан өвөлжиж байгаа эсэх: Өрхүүдийн олонх гэртээ тав тухтай, дулаахан өвөлжиж байна. Гэхдээ өрхүүдийн гуравны нэг нь дунд зэрэг ба хүйтэн өвөлжиж байгаа бөгөөд тэдгээрийн талаас илүү хувь нь гэртээ дулаалга хийгээгүй байна.

Өрхийн орлого

Өрхийн сарын дундаж орлого: Өрхүүдийн бараг тал хувь нь 700 мянган төгрөгөөс бага сарын орлоготой байгаа төдийгүй төслийн зорилтот хороодын өрхүүдийн сарын дундаж орлого нийтээрээ Нийслэлийн өрхүүдийн дундаж орлогоос доогуур байна. Сүхбаатар дүүргээс судалгаанд оролцсон өрхүүдийн сарын дундаж орлого Сонгинохайрхан дүүргийнхнээс бага зэрэг өндөр байна.

Өрхийн сарын дундаж орлогыг ойролцоолон тооцвол 840 мянган төгрөг болох ба нийслэлийн өрхийн сарын дундаж мөнгөн орлогоос даруй 460 мянган төгрөгөөр бага байна. Түүнчлэн нийт өрхийн 26% нь 500 мянга хүртэлх төгрөгийн сарын дундаж орлоготой бөгөөд үүний 17% (71 өрх) нь 3 ба түүнээс дээш ам бүлтэй байна. Иймд нийт өрхийн 17% нь амжиргааны доод түвшнөөс доогуур орлоготой³⁵ байна. Ганц бие, эмэгтэй өрхийн тэргүүнтэй болон ганц бие эрэгтэй өрхийн тэргүүтэй гэр бүлүүдийн олонх нь бага орлоготой байна.

³⁵ 2019 оны хүн амын амьжиргааны доод түвшин нэг хүнд сард 217,900 төгрөг байна. YCX

Хэрвээ гэр бүлийн төрлийн хувьд эмэгтэй өрхийн тэргүүнтэй болон ганц бие эрэгтэй өрхийн тэргүүтэй гэр бүлүүдийг эмзэг бүлэг, орлогын хувьд 500 мянга хүртэлх төгрөгийн сарын дундаж орлоготой, 3 ба түүнээс ам бүлтэй өрхүүдийг эмзэг гэж үзвэл нийт 131 өрх буюу нийт өрхийн 31% нь энэ бүлэгт хамрахаар байна.

Өрхүүдийн талаас дээш хувьд өрхийн орлого хүрэлцэхгүй байна. Бага орлоготой өрхүүдийн 80%, дундаж орлоготой өрхүүдийн 30%, дунджаас дээгүүр орлоготой өрхүүдийн 24%-д өрхийн орлого хүрэлцэхгүй байгаа аж.

Өрхийн насанд хүрсэн гишүүдийн орлого: Өрхийн насанд хүрсэн гишүүдийн талаас илүү хувь цалингийн орлоготой бөгөөд судалгаанд оролцсон өрхүүдийн гуравны нэгийг нь хувьд өрхийн бүх гишүүн цалингийн орлоготой байна. Түүнчлэн цалин+тэтгэвэр тэтгэмжийн орлоготой өрхүүд, цалин+бизнесийн орлоготой өрхүүд дараагийн томоохон хэсэг нь байна. Цалин хөлсний орлоготой өрхийн гишүүдийн олонх нь нийгмийн даатгал төлдөг цалингийн эх үүсвэртэй, бизнесийн орлоготой өрхийн гишүүдийн олонх нь худалдаа наймаа болон бусад төрлийн бизнесийн орлогын эх үүсвэртэй ажээ. Тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрхийн гишүүд сард дунджаар 302,500 төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж авч байна

Өрхийн зардал

Өрхийн зардлыг боловсрол, сургалтын зардал, эрүүл мэндийн зардал, түлш, цахилгааны зардлаар ангилан авч үзлээ.

Боловсролын зардал: Нийт өрхүүдийн 42% нь боловсролд зардал гаргадаг бөгөөд эдгээр өрх жилд дунджаар 1.2 сая төгрөгийг боловсролд зарцуулж байна. Боловсролын зардал гаргадаг өрхүүдийн олонх (63%) нь дунд ба дундаас дээш орлоготой бол боловсролын зардал гаргаагүй өрхүүдийн талаас илүү хувь нь бага орлоготой өрхүүд байна.

Эрүүл мэндийн зардал: Өрхүүдийн 94% нь эрүүл мэндийн зардал гаргадаг бөгөөд эдгээр өрх сард дунджаар 63,400 төгрөгийг эрүүл мэндэд зарцуулж байна. Бага орлоготой өрхүүд эрүүл мэнддээ сард дунджаар 54,370 төгрөг, дундаж орлоготой өрхүүд 61,580 төгрөг, дунджаас дээгүүр орлоготой өрхүүд 76,200 төгрөгийг зарцуулж байна. Нийт өрхийн 92% нь амьсгалын замын өвчинд, 24% нь зүрх судасны өвчинд тус тус зардал гаргаж байна. Эдгээр өрх амьсгалын замын өвчинд сард дунджаар 37,125 төгрөг, зүрх судасны өвчинд сард дунджаар 27,660 төгрөгийг тус тус зарцуулдаг ажээ.

Түлээ, нүүрсний зардал: Өрхүүд жилд дунджаар 69 уут түлээ, 4 тонн нүүрс түлдэг байна. Харин хүйтний улиралд сард 16 уут түлээ, 1 тонн нүүрс хэрэглэдэг аж. Түлээнд сард дунджаар 57,340 төгрөг, жилд дунджаар 214,996 төгрөг зарцуулж байгаа бол нүүрсэнд сард дунджаар 88,950 төгрөг, жилд дунджаар 607,468 төгрөг зарцуулж байна.

Цахилгааны зардал: Өрхүүд халаалтын улиралд цахилгаандаа сард дунджаар 52,900 төгрөг, халаалтын бус улиралд дунджаар 37,280 төгрөгийг төлж байна. Халаалтын ба халаалтын бус улирлаас үл хамааран хамгийн олон өрхийн цахилгаандаа төлж буй хэмжээ 30,000 төгрөг ажээ. Халаалтын улиралд өрхүүдийн цахилгааны зардал дунджаар 10,000-15,000 төгрөгөөр өсөж байгаа нь зорилтот хороодын өрхүүд цахилгааныг дулаандаа ямар нэгэн хэмжээгээр ашигладаг болохыг харуулж байна. Цахилгааныг дулаандаа ашиглаж буй өрхүүдийн олонх нь дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд байв.

Өрхийн хадгаламж ба зээл

Өрхийн хадгаламж: Өрхүүдийн зөвхөн 20% хадгаламжтай бөгөөд хадгаламжийн дундаж хэмжээ 2 сая төгрөг байна. Хадгаламжтай өрхүүдийн 30% нь бага орлоготой, 54% нь дундаж орлоготой, 16% нь дунджаас дээгүүр орлоготой өрхүүд байна. Хэдийгээр хадгаламжтай өрхийн тоо болон хадгаламжийн хэмжээ бага ч хадгаламжтай өрхүүдийн олонх нь хадгаламжийн дадал, зуршилтай ажээ. Хадгаламжийн олонх нь ирээдүйн хөрөнгө оруулалт, эрсдэлд зориулагдсан бол зөвхөн 6% нь байшин барих, байшингийнхаа засвар өргөтгөлд зориулан хадгалжээ.

Өрхийн зээл: Өрхүүдийн 32% нь зээлтэй ажээ. Эдгээрийн 16% нь цалингийн зээлтэй, 9% нь тэтгэврийн зээлтэй, 5% нь хэрэглээний зээлтэй, үлдсэн 3% нь автомашин, бизнес, орон сууцны зээлтэй байна. Нийт зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 5.8 сая төгрөг бол цалингийн зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 6.2 сая, тэтгэврийн зээлтэй өрхүүдийн дундаж зээлийн хэмжээ 4.2 сая төгрөг байна. Зээлийн дундаж хугацаа 2 жил бөгөөд зээлийн эргэн төлөлтөд сард дунджаар 374.8 мянган төгрөг төлдөг ажээ. Цалингийн зээлийн эргэн төлөлт тэтгэврийн зээлийнхээс дунджаар 100 мянган төгрөгөөр их байна. Зээлтэй өрхүүдийн 21% нь байшин барих, хашаа байшин худалдаж авах, байшингийн засвар өргөтгөлд зээлээ зарцуулжээ.

Өрхийн өмч хөрөнгө ба хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөө

Өрхийн өмч, хөрөнгө: Өрхүүдийн талаас илүү хувь нь автомашинтай бөгөөд тэдгээрийн 85% нэг автомашинтай бол үлдсэн хэсэг нь 2-оос 6 хүртэл автомашинтай ажээ. Харин нийт автомашины 7% барьцаанд байна.

Өрхүүдийн 77% нь хашааныхаа газрын өмчилдөг, 17% нь эзэмшдэг бөгөөд нэг өрх дунджаар 606м² хашааны газартай байна. Түүнчлэн өрхүүдийн 96% нь амьдарч буй сууцаа өмчилдөг бөгөөд тэдгээрийн олонх нь ҮХХ-ийн гэрчилгээтэй ажээ. Сууцаа өмчилдөг өрхүүдийн 9% сууцаа зээлийн барьцаанд тавьжээ.

Хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөө: Өрхүүдийн зөвхөн гуравны нэг хөрөнгө оруулалтын цаашдын төлөвлөгөөтэй бөгөөд эдгээрийн олонх нь барилга сууцанд хөрөнгө оруулахаар төлөвлөж байна. Барилга сууцандаа хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа өрхүүдийн 40% нь бага орлоготой, 60% дунд ба дундаас дээгүүр орлоготой өрхүүд байна.

Өрхийн сууцны нөхцөл байдал

Сууцны насжилт, зохион байгуулалт, бүтэц: Өрхүүд дунджаар 11 жил болсон, дундаж хэмжээ нь 47м² сууцанд амьдарч байна. Өрхүүдийн талаас илүү хувь нэг өрөөтэй сууцанд амьдарч байна. Нэг өрөөтэй сууцнууд дунджаар 41м² хэмжээтэй, урд зүгт харсан хаалгатай, урагшаа харсан 2 цонхтой гэсэн нийтлэг шинжтэй ажээ. Харин нэгээс дээш өрөөтэй сууцнууд дунджаар 55м² хэмжээтэй, 2-3 өрөөтэй, урд зүгт харсан хаалгатай, урагшаа харсан 2 цонх, баруун ба зүүн тийш харсан нэг цонхтой гэсэн нийтлэг шинжтэй байна. Гурван өрөөний хувьд зочны өрөө, унтлагын өрөө, гал тогоо гэсэн өрөөнүүдтэй, харин хоёр өрөөтэй сууцны хувьд зочны өрөө, гал тогоо гэсэн өрөөнүүдтэй айлууд нийтлэг байна.

Сууцны материалаар харвал ерөнхийдөө дараах хоёр төрлийн сууцанд өрхүүд амьдарч байна. Үүнд: (i) Тоосгон ханатай, төмрөөр хийсэн шувуун нуруун дээвэртэй, бетонон шалтай байшин, (ii) Модон ханатай, төмрөөр хийсэн шувуун нуруун дээвэртэй, модон шалтай байшин.

Өрхүүдийн олонх өөрсдөө байшингаа барьсан бөгөөд мэргэжлийн байгууллагаар байшингаа бариулах хандлага төдийлөн байхгүй байна.

Сууцны дулаалга ба дулаан алдагдал: Нийт өрхийн зөвхөн гуравны нэг нь л сууцаа дулаалжээ. Дулаалгын материалыг сонгон авахад хамгийн гол нөлөөлдөг хүчин зүйл бол хямд үнэ, зах зээл дэх материалын олдоц аж. Өрхүүд дулаалгаа бараг 100 хувь өөрсдөө хийсэн бөгөөд талаас илүү хувь нь хийсэн дулаалгын чанараа сайн болсон гэж үзэж байна. Сууцаа дулаалахад тулгарч буй гол гурван бэрхшээл нь санхүү, хүн хүчний дутмаг байдал, цаг завгүй байдал ажээ. Санхүүгийн бэрхшээл тулгарч буй өрхүүдийн 92% бага ба дундаж орлоготой өрхүүд байна. Түүнчлэн өрхүүдийн талаас илүү хувь цаашид байшингийнхаа дулаалгыг мэргэжлийн бригадаар хийлгэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд тэдгээрийн 53% бага орлоготой, 47% дунд ба дундаас дээш орлоготой өрхүүд байна.

Өрхүүдийн гуравны хоёр нь сууцныхаа аль нэг газраас дулаан алдагдаж байгаа гэсэн бөгөөд цонх болон хананаас дулаан илүүтэй алдагдаж байна. Нийт өрхүүдийн талаас илүү хувь дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээ авсан бөгөөд хана, цонх, дээврээ илүүтэй дулаалжээ. Ингэхдээ хөөсөнцөр, шилэн хөвөнг түгээмэл ашигласан бөгөөд дулаалгын материалаа голдуу жижиглэн худалдаанаас авч ашиглажээ.

Халаалт: Өрхүүдийн 50% нь энгийн зуухтай, 40% нь төслийн зуухтай, үлдсэн 10% нь усан халаалтын болон цахилгаан зуухтай ажээ. Өвлийн улиралд хоногт дунджаар 3-4 удаа галлаж байна. Галлагааны дундаж тоог сууцандаа дулаалга хийсэн болон хийгээгүй өрхүүдээр харьцуулахад бараг ялгаагүй бөгөөд энэ нь өрхүүдийн өөрсдөө хийсэн дулаалга галлагааны тоог цөөлөхөд төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгааг харуулж байна. Өрхүүдийн олонх нь ханан пийшин, зуухны гадаргуу гэсэн халаах хэрэгсэлтэй ажээ.

Одоогийн амьдарч буй сууцны цаашдын төлөвлөгөө

Ойрын хугацааны сонирхол: Иргэдийн олонх нь одоогийн амьдарч буй байршилдаа үргэлжлүүлэн амьдрахаар байна. Хэдийгээр судалгаанд оролцогсдын гуравны нэг нь орон сууц руу нүүхээр төлөвлөж байна гэж хариулт өгсөн боловч тэдний бодит санхүүгийн нөхцөл байдал (тогтмол орлогын хэмжээ, хадгаламжийн хэмжээ, одоогийн зээлийн хэмжээ) нь ипотекийн зээлийн шаардлагыг давах эсэх нь тодорхой бус байна. Үлдсэн өрхүүд нь байр сууцаа засварлах, дулаалах сонирхол байгаа ба дийлэх нь (72%) нь ойрын хугацаанд буюу 2019-20 онд төлөвлөж байна.

Сууцны дулаан алдагдлыг бууруулах алхмууд: Одоогийн амьдарч буй сууцныхаа дулаан, тав тухтай байдлыг нэмэгдүүлэхэд цахилгаан халаагуур, зуухаа шинэчлэх, байшингаа дулаалах аргууд хамгийн үр дүнтэй гэж үзэж байна. Цахилгаан халаагуур хэрэглэхэд эрчим хүчний хөнгөлөлттэй тариф хөшүүрэг болж байгаа боловч галын аюултай гэсэн тогтсон ойлголт болон халаагуур тавиулах зардал өндөр шалтгаан гол хязгаарлалт болж байна. Зуух, пийшингээ сайжруулах, түлшний хэрэглээгээ багасгах нь чухал гэж үзэж байгаа ч утаагүй зуух (төслийн зуух)-ыг тийм ч оновчтой гэж үзэхгүй байна. Ойрын

хугацаанд хамгийн боломжит хувилбар нь байшингаа дулаалах гэдэг дээр иргэдэд харьцангуй ойлголт, мэдлэг бүрэлдэх шатандаа байна.

Сонирхож буй техникийн шийдэл. Иргэд дулаалгын шийдлийн илүү цогц хувилбарыг сонгох эрмэлзэлтэй байна. Зөвхөн байшингаа дулаалах төдийгүй, өнгө үзэмжийг нь дээшлүүлэх, түлээ, түлш бага хэрэглэдэг байх шийдэл илүү эрэлттэй гэж иргэд үзэж байна. Энэ нь өрхийн орлогын түвшнээс үндсэндээ хамааралгүй, нийтлэг чухалчлах хандлага байна. Гэхдээ дулаалгын материал сонголт, хэрхэн хийх арга ажиллагааны талаар тодорхой ойлголт мэдлэгтэй хүн ам маш цөөн буюу энэ талын мэдээллийн хэрэгцээ өндөр байна. Мэдээлэл хүргэхдээ илүү газар дээрх шууд аргууд буюу хорооны нутаг дэвсгэрт санал болгож буй шийдлийг бодитоор харуулсан загварын байшин барих, нүүр тулсан уулзалтууд иргэдтэй хийх, хэвлэмэл мэдээлэл хорооны олон нийтийн газарт байршуулах, нийгмийн сүлжээг ашиглах арга хэрэгсэл эрэлттэй байна.

Санхүүгийн боломж: Өрхүүдийн санхүүгийн чадавхид суурилсан ялгаатай нөхцлүүд бүхий зээлийн зуучлал илүү олон өрхийг техникийн шийдэл авах бололцоогоор хангана гэж хүлээж байна. Иргэдий дийлэнх нь 1-2 сая төгрөгийг байшингийн дулаалганд зарцуулах боломжтой гэж харж байгаа ба урт хугацааны ач холбогдлыг нь ойлговол иж бүрэн шийдэлд 5-7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх сонирхол байна. Ингэхийн тулд, сард төлөх эргэн төлөлтийн хэмжээ бага (~200,000 төг), илүү урт хугацаатай (~36 сар), бага хүүтэй (<1%) байх зээлийн үйлчилгээг иргэд сонирхох хандлагатай байна. Хэрвээ орлого багатай, нийгмийн эмзэг бүлгийн өрхийг төсөлд хамруулна гэвэл, банкнаас тавих шаардлага өрхийн нөхцөл байдлаас хамааран уян хатан байх шаардлага байна. Тухайлбал барьцаа хөрөнгө байхгүй, одоогийн сууц нь барьцаа хөрөнгийн шаардлага хангахааргүй, тогтмол орлогогүй, нийгмийн даатгал төлдөггүй, албан бус секторт болон улирлын ажил эрхлэгч зэрэг тус бүрт нь харгалзаж үзэх тохиолдлууд байна.

ХАВСРАЛТ

1. Түүвэр судалгааны асуумж

УЛААНБААТАР ХОТЫН ТӨЛӨВЛӨГДӨӨГҮЙ БҮСЭД ТОГТВОРТОЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ОРОН СУУЦ БАРИХАД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ (SWITCH II-SOAP)ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА

МИРИМ Консалтант ХХК нь СОП төслийн суурь судалгааны хүрээнд гэр хорооллын амины сууцанд амьдардаг өрхүүдээс судалгааг авч байна. Энэхүү судалгааы зорилго нь зорилтот хороодын өрхүүдийн сууцаа дулаалах мэдлэг хандлага, хэрэгцээ, санхүүгийн чадавх, сууцны одоогийн нөхцөл зэргийг тодорхойлох явдал юм. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн төслийн цаашдын ажил төлөвлөгдөх учраас судалгаанд идэвхтэй оролцож, үнэн зөв мэдээллээр хангахыг танаас хичээнгүйлэн хүсье. Бид таны өгсөн мэдээллийн нууцыг чандлан хадгалах бөгөөд зөвхөн судалгааны зорилгоор ашиглана.

(Энэ судалгааг зөвхөн өрхийн тэргүүн, өрхийн тэргүүний эхнэр, эсвэл байнгын хамт амьдардаг өрхийн шийдвэр гаргалтад оролцдог өрхийн насанд хүрсэн гишүүнээс авна)

Шалгуур асуулт: Танайх энэ байшинг түрээслэн суудаг уу?

1. Тийм (Судалгааг зогсооно)
2. Үгүй (Судалгааг үргэлжлүүлнэ)

№	Мэдээлэл цуглуулалтын багийн мэдээлэл				
1	Судлаачийн нэр				
2	Судалгаа авсан огноо				0 1 1 9
3	Эхэлсэн хугацаа (цаг, минут)			:	
4	Дууссан хугацаа (цаг, минут)			:	

№	Респондентийн мэдээлэл		
5	Респондентийн нэр		
6	Респондентийн нас		
7	Респондентийн хүйс	1. Эр	2. Эм
8	Байршил GPS уншуулах	Дүүрэг:	Хороо:
		Гудамж:	Хаалганы №:
9	Респондент өрхийн тэргүүнтэй ямар хамааралтай вэ?		
10	Респондентийн утасны дугаар		

I. ӨРХТЭЙ ХОЛБООТОЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Асуулт	Хариулт
1.1	Танай өрхөд байнга амьдардаг гишүүдийн тоо	1.хүн 1.1. Үүнээс насанд хүрээгүй хүүхдийн тоо..... 1.2. Үүнээс өндөр настаны тоо.....
1.2	Гэр бүлийн төрөл	1. Ганц бие 2. Эмэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл (эх, хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл) 3. Ганц бие эрэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл (эцэг, хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл) 4. Дан гэр бүл (эхнэр, нөхөр, хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл) 5. Нийлмэл гэр бүл (эхнэр, нөхөр, хүүхдүүд, эмээ, өвөө, хамаатнаас бүрдсэн гэр бүл) 6. Бусад (тодруулна уу).....
1.3	Танай өрхөд хөгжлийн бэрхшээлтэй хүн бий юу?	1. Байхгүй 2. Байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:.....
1.4	Танай өрхөд томоохон (ж: 300,000 төгрөг ба түүнээс дээш) худалдан авалт, хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэрийг хэн голдуу гаргадаг вэ? (Хамгийн гол 2 хүртэлх хүнийг сонгоно, нэрийг нь асууж сонголтын ард бичнэ)	1. Өрхийн тэргүүн..... 2. Эхнэр..... 3. Насанд хүрсэн хүүхэд..... 4. Өрхийн тэргүүний эцэг/эх..... 5. Өрхийн тэргүүний ах/эгч..... 6. Өрхийн тэргүүний хүргэн/бэр..... 7. Өрхийн тэргүүний өвөө/эмээ..... 8. Өрхийн тэргүүний хадам эцэг/эх..... 9. Өрхийн тэргүүний хадам ах/эгч..... 10. Бусад (тодорхойлно уу).....

Энд тухайн айлд байнга амьдардаг насанд хүрсэн гишүүдийн мэдээллийг асууна							
№	1.5 Өрхийн тэргүүнтэй хамааралтай байдал Доорх кодыг ашиглана уу 1=Өрхийн тэргүүн 2=Эхнэр/Нөхөр 3=Хүүхэд 4=Ач/зээ 5=Эцэг/эх 6=Ах/эгч 7=Хүргэн/ бэр 8=Өвөө/эмээ 9=Хадам аав/ээж 10=Бусад хамаатан 11=Хамаатан биш 12=Бусад.....	1.6 Хүйс Доорх кодыг ашиглана уу 1=Эр 2=Эм	1.7 Нас	1.8 Боловсролын түвшин Доорх кодыг ашиглана уу 1=Боловсролгүй 2=Бага(4,5-р анги) 3=Суурь (8,9-р анги) 4=Бүрэн дунд 5=Техник болон мэргэжлийн 6=Тусгай мэргэжлийн дунд 7=Бакалаврын дээд боловсролтой 8= Магистр 9=Доктор	1.9 Сүүлийн 12 сарын ажил эрхлэлтийн байдал Доорх кодыг ашиглана уу 1=Төрийн байгууллага 2=Хувийн байгууллага 3=Хувиараа хөдөлмөр эрхлэгч 4=ТББ 5=ОУБ 6=Тэтгэвэрт 7=Жирэмсэний амралтаа авсан 8=Малчин 9=Ажилгүй 10=Групп 11=Оюутан 12=Бусад	1.10 Хэрвээ ажил эрхэлдэг бол аль салбарт ажилладаг вэ? 1=ХАА 2=Уул уурхай 3=Боловсруулах үйлдвэрлэл 4=Эрчим хүч 5=Барилга 6=Худалдаа 7=Мэдээлэл, холбоо 8=Үйлчилгээ 9=Банк, санхүү 10=Боловсрол 11=Эрүүл мэнд 12=Соёл урлаг, спорт 13=Батлан хамгаалах 14=Бусад	1.11 Нийгмийн даатгал төлдөг эсэх Доорх кодыг ашиглана уу 1=Төлдөг 2=Төлдөггүй
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							

9							
---	--	--	--	--	--	--	--

Энд тухайн айлд байнга амьдардаг насанд хүрсэн гишүүдийн мэдээллийг асууна (үргэлжлэл)			
№	1.12 Орлогын төрөл 1=Цалин хөлс 2=Тэтгэвэр, тэтгэмж 3=Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ (бизнесийн) орлого	1.13 Орлогын эх үүсвэр 1=НДШ төлдөг цалингийн орлого 2= НДШ төлдөггүй цалингийн орлого 3=Өндөр насны тэтгэвэр 4=Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамж 5=Худалдаа наймаа, бизнесийн орлого 6=Бусад (тодруулна уу).....	1.14 Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ (төгрөг) 88=Хариулахаас татгалзсан
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			

**II. АГААРЫН БОХИРДОЛ БА СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДАЛЫН ТАЛААРХ
МЭДЛЭГ, ХАНДЛАГА**

№	Асуулт	Хариулт
АГААРЫН БОХИРДОЛ		
2.1	Агаарын чанарын индекс гэж та сонссон уу?	1. Сонсоогүй (2.2-р асуултыг алгасна уу) 2. Сонссон
2.2	Хэрвээ агаарын чанарыг ягаан өнгөөр тэмдэглэсэн бол та үүнийг хэрхэн ойлгож байна вэ?	1. Агаар цэвэр байна 2. Агаар хэвийн түвшинд байна 3. Агаар бага зэргийн бохирдолтой байна 4. Агаар дунд зэргийн бохирдолтой байна 5. Агаар их бохирдолтой байна 6. Агаар маш их бохирдолтой байна 88. Мэдэхгүй
2.3	Дараах хүчин зүйлсээс УБ хотын агаарын бохирдлын хамгийн гол хоёр эх үүсвэрийг дугуйлна уу.	1. Гэр хорооллын өрхүүдийн нам даралтны зуухны утаа 2. Хог хаягдал, үнс, сул хөрс шорооноос дэгдэх тоос 3. Авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа 4. Цахилгаан станцуудын ялгаруулж буй утаа 5. Хог хаягдлын шатаалтаас үүсэх утаа 6. Барилгын ажил, элсэн карьер зэргээс үүдэх тоос, тоосонцор
2.4	Агаарын бохирдол хүний аль эрхтэн тогтолцоонд хамгийн их хор нөлөө үзүүлдэг вэ?	1. Хоол боловсруулах тогтолцоо 2. Амьсгалын тогтолцоо 3. Мэдрэлийн тогтолцоо 4. Нөхөн үржихүйн тогтолцоо 5. Зүрх судасны тогтолцоо 88 Мэдэхгүй
2.5	Агаарын бохирдлоос гэр бүлийн эрүүл мэндээ хамгаалахын тулд та юу хийсэн бэ? Олон сонголтот	1. Гадуур явахдаа чанартай амны хаалт зүүж хэвшүүлэх 2. Гэртээ агаар цэвэршүүлэгч тавих 3. Утаа ихтэй үед аль болох гадагш гарахгүй байх 4. Гэрийн зуухны таталт сайн байгааг хянах 5. Илчлэг сайтай хоол хүнс хэрэглэж, биеийн дархлааг дэ 6. Гаднаас утаа оруулахгүйн тулд хаалга цонхоо битүүмж 7. Гэртээ, машиндаа тамхи татахгүй байх 8. Бусад (тодруулна уу)..... 9. Юу ч хийгээгүй
2.6	Агаарын бохирдлоос үүдэн танай өрхөд ямар хохирол учирч байна вэ?	1. Эрүүл мэндээрээ хохирч байна 2. Эрүүл мэндтэй холбоотой зардлууд өсч байна 3. Өрхийн хэрэглээний зардал (маск, урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга хэмжээний зардал) өсч байна. 4. Агаар цэвэршүүлэгч зэрэг үнэтэй бараа авах шаардлага гарч байна. 5. Бусад 6. Хохирол байхгүй 88. Мэдэхгүй
2.7	Танайд агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулах хамгийн тохиромжтой арга юу вэ?	1. Байшингаа дулаалж, нүүрсний хэрэглээгээ бууруулах 2. Сайжруулсан түлш хэрэглэх 3. Цахилгаан халаагуур хэрэглэх 4. Хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах 5. Хог шатаахгүй байх 6. Орон сууцанд нүүж орох 7. Бусад (тодруулна уу).....
2.8	Гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нэн тэргүүнд юу хийх шаардлагатай гэж та	1. 2. 3. 88. Мэдэхгүй

	бодож байна вэ?	
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ		
2.9	Гэрээ дулаахан байлгахад юу хийх хэрэгтэй вэ?	1. 2. 88. Мэдэхгүй
2.10	Та гэртээ дулаахан, тав тухтай өвөлжиж байна уу?	1. Маш дулаахан (байнга халууцдаг) 2. Дулаахан 3. Дунд зэрэг 4. Сэрүүн 5. Маш хүйтэн (байнга даардаг)

III. ӨРХИЙН САНХҮҮГИЙН ЧАДАМЖ

ӨРХИЙН ОРЛОГО				
3.1	Өрхийн сарын дундаж орлого (Гадаадаас хүлээн авч буй мөнгөн шилжүүлэгээс бусад бүх орлогыг нийлүүлж тооцно)	1. 500,000 төгрөг хүртэл 2. 500,001-700,000 төгрөг 3. 700,001-900,000 төгрөг 4. 900,001-1,100,000 төгрөг 5. 1,100,001-1,300,000 төгрөг 6. 1,300,001-1,500,000 төгрөг 7. 1,500,001-2,000,000 төгрөг 8. 2,000,001-2,500,000 төгрөг 9. 2,500,001 төгрөгөөс дээш 99. Хариулахаас татгалзсан 88. Мэдэхгүй		
3.2	Хэрвээ гадаадаас мөнгөн шилжүүлэг хүлээн авдаг бол жилд дунджаар хэдэн төгрөг хүлээн авдаг вэ?	1..... 2. Авдаггүй 99. Хариулахаас татгалзсан		
3.3	Танай өрхийн орлогын хүрэлцээ хэр вэ?	1. Өдөр тутмын ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй (түлээ түлш, хоол унд, автобус унаа гэх мэт) 2. Өдөр тутмын хэрэгцээндээ л дөнгөж хүрдэг 3. Өдөр тутмын хэрэгцээ болон ойр зуурын хувцас хунар зэрэгт л хүрэлцдэг 4. Эдгээрээс гадна үнэ цэнтэй зүйл (цахилгаан бараа, тавилга, үнэт эдлэл гм) авч хүрэлцдэг 5. Хэрэгцээнээсээ илүүчилж хуримтлал бий болгож чаддаг		
ӨРХИЙН ЗАРДАЛ [тухайн зардалд тохирох хугацаагаар нь бөглөнө үү] (Хэрэв зардал гаргаагүй бол 0 гэж бичнэ)				
№	Зардлын төрөл	7 хоног	Сар	Жил
3.4	Танай өрх боловсрол, сургалтын төлбөрт хэдэн төгрөг зарцуулдаг вэ?			
3.5	Танай өрх эрүүл мэндийн (эм тариа, эмчилгээ, эмнэлэгт хэвтэх) зардалд дунджаар хэдэн төгрөг зарцуулдаг вэ?			
3.5.1	Үүнээс амьсгалын замын (ханиад томуу, хатгаа гм) өвчинд дунджаар хичнээн төгрөг зарцуулдаг вэ?			
3.5.2	Үүнээс зүрх судасны өвчинд дунджаар хичнээн төгрөг зарцуулдаг вэ?			

3.6	Танай өрхийн түлшний хэрэглээ хэдий хэмжээтэй байдаг вэ?					
3.6.1	Түлээний мод (куб.метр/ уут)					
3.6.2	Нүүрс (тонн/ шуудай)					
3.6.3	Хэрвээ шуудайгаар гэж хариулсан бол шуудай нүүрсний дундаж үнэ хэд вэ?		төгрөг			
3.7	Хаанахын нүүрс голдуу хэрэглэдэг вэ?		1 2..... 88. Мэдэхгүй			
3.8	Цахилгааны сарын төлбөр					
3.8.1	Халаалтын улиралд (9-5 сар)		төгрөг			
3.8.2	Халаалтын бус улиралд (6-8 сар)		төгрөг			
3.9	Танай өрхийн цахилгаан хэрэглэгчийн кодоо хэлж өгнө үү.		1..... 88.Мэдэхгүй 99. Хариулахаас татгалзсан			
ӨРХИЙН ХАДГАЛАМЖ БА ЗЭЭЛ						
3.10	Та болон танай өрхийн гишүүд хадгаламжтай юу?		1. Байхгүй (3.14-р асуулт хүртэл алгасна уу) 2. Байгаа			
3.11	Танай өрхийн нийт хадгаламжийн хэмжээ ойролцоогоор хичнээн төгрөг вэ?		1.....төгрөг 99. Хариулахаас татгалзсан 88. Мэдэхгүй		Хадгалуулсан банк, ББСБ, ХЗХ зэргийн нэр: 1..... 2..... 3..... 4.....	
3.12	Хадгаламжийн төрөл болон хугацаагаа хэлж өгнө үү. (Нэг төрлийн хадгаламж олон байвал нэгтгэж бичнэ, хугацааг дунджаар нь тооцно)	#	Хадгаламжийн төрлүүд 1= Хугацаагүй хадгаламж 2= Хугацаатай хадгаламж			Хугацаа (сар)
		1				
		2				
		3				
		4				
3.13	Та одоогийн байдлаар юунд зориулан хадгаламж хийж байна вэ? Олон сонголтот	1. Орон сууц худалдаж авах 2. Хашаа байшин худалдаж авах 3. Байшин барих 4. Байшиндаа засвар, өргөтгөл хийх 5. Газар худалдаж авах 6. Машин худалдаж авах 7. Бизнес эхлэх, эсвэл өргөжүүлэх 8. Сургалтын төлбөр төлөх 9. Ахуйн хэрэглээндээ (электрон бараа, тавилга гм) 10. Хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулалт хийх 11. Ирээдүйн эрсдэлээс сэргийлэх 12. Бусад				
3.14	Танай өрх зээлтэй юу?		1. Зээлтэй 2. Зээлгүй (3.17 хүртэл алгасна уу)			
3.15	Зээлийн хэмжээ, хугацаа, хаанаас авсан зэргийг зээлийн төрөл бүрээр хэлж өгнө үү (Нэг төрлийн зээл олон байвал хэмжээг нь нэгтгэж тооцно, хугацааг дунджаар нь тооцно, зээл авсан газраа цувуулан бичнэ)					
	#	Зээлийн төрөл 1=Цалингийн зээл	Хэмжээ (төгрөг)	Хугацаа (сар)	Сарын эргэн	Зээл авсан газар 1=Банк

	2=Тэтгэвэрийн зээл 3=Орон сууцны зээл 4=Хэрэглээний зээл 5=Бизнесийн зээл 6=Автомашины зээл 7= Бусад (тодруулна)			төлөлтийн хэмжээ (төгрөг)	2=ББСБ 3=ХЗХ 4=Албан байгууллага 5=Хувь хүн 6=Ломбард 7= Бусад (тодруулна)
1					
2					
3					
4					
5					

3.16	Зээлээ ямар зориулалтаар зарцуулж байна вэ? Олон сонголтот	1. Орон сууц худалдаж авах 2. Хашаа байшин худалдаж авах 3. Байшин барих 4. Байшиндаа засвар, өргөтгөл хийх 5. Газар худалдаж авах 6. Машин худалдаж авах 7. Бизнес эхлүүлэх, эсвэл өргөжүүлэх 8. Сургалтын төлбөр төлөх 9. Өрхийн хэрэглээнд 10. Удаан эдэлгээт бараа авах (цах бараа, тавилга гм) 11. Өрхийн гишүүнээ гадаадад явуулах 12. Эрүүл мэндийн зардал төлөхөд 13. Бусад (тодруулна уу).....
------	---	---

ӨМЧ ХӨРӨНГӨ					
3.17	Танай өрх өөрийн эзэмшлийн автомашинтай юу? Олон сонголтот	#	Автомшины төрөл	Тоо	Барьцаанд байгаа эсэх 1=Тийм, 2=Үгүй
		1	Суудлын автомашинтай		
		2	Ачааны машинтай		
		3	Автобустай (микро, том оврын)		

3.18	Та хашааны газрынхаа өмчлөл болон хэмжээний талаар хэлж өгнө үү.	Өмчилдөг, эсвэл эзэмшдэг эсэх 1. Өмчилдөг 2. Эзэмшдэг 3. Бичиг баримтгүй 4. Манай өрхийн өмч биш	Газрын хэмжээ (м2)
------	--	--	---------------------------------

3.19	Та амьдарч буй энэ байшингийнхаа өмчлөлийн талаар хэлж өгнө үү?	Өрхийн өмч мөн эсэх 1. Мөн 2. Биш	ҮХХ-ийн гэрчилгээтэй эсэх 1. Тийм 2. Үгүй	Барьцаанд байгаа эсэх 1. Тийм 2. Үгүй
------	---	---	---	---

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ				
3.20	Ирэх хоёр жилд танай өрхөд дараах зүйлсэд хөрөнгө оруулах төлөвлөгөө бий юу?	#	Хөрөнгө оруулах зүйлс	Төлөвлөж буй он
		1	Барилга сууцанд	
		2	Машин худалдаж авах	
		3	Боловсролд (сургалтын төлбөр гм)	
		4	Эмчилгээнд	
		5	Гадаад явах (аялах, ажиллахаар явах)	
		6	Томоохон тэмдэглэлт үйл	

			явдалд (хурим гм)		
		7	Төлөвлөгөө байхгүй		

IV. ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

№	Асуулт	Хариулт	
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ			
4.1	Танай байшин хэдэн онд баригдсан вэ?	1.он 2. 88. Мэдэхгүй	
4.2	Танайх энэ байшинд хэдэн жил амьдарч байна вэ?	жил	
4.3	Танай байшингийн хэмжээ	1. Байшингийн хэмжээ:.....х.....(харьцаа) 2. Давхарын тоо:..... (хэрэв мансардыг давхарын тоонд оруулах бол зөвхөн өвөл, зунгүй амьдардаг байна)	
4.4	Танай байшинд дараах өрөөнүүд байдаг уу? Харгалзах өрөөнүүдийг дугуйлж, өрөөний тоог ард нь бичнэ үү.	1. Бүгд хамтдаа нэг өрөө (зочин, унтлагын өрөө, гал тогоо) 2. Зочны өрөө:..... 3. Унтлагын өрөө:..... 4. Гал тогоо:..... 5. Угаалгын өрөө:..... 6. Мансард:..... 7. Гонх 8. Бусад.....	
4.5	Хаалга болон цонхнуудын харсан зүг чиг	Төрөл	1=Урд, 2=Хойд, 3=Баруун, 4=Зүүн
		Хаалга	
		Цонхнууд	Урд..... Хойд..... Баруун..... Зүүн.....
4.6	Байшингийн ханын материал бүтэц	#	Гадна хана
		1	Тоосго
		2	Нүхтэй блок (хашааны блок)
		3	Мод (палк, дүнг, шургааг)
		4	Банз
		5	Хөнгөн блок
4.7	Байшингийн дээврийн хэлбэр	1. Шувуун нуруу 2. Мансард 3. Бусад (тодруулна уу).....	
4.8	Байшингийн дээврийн материал	1. Төмөр 2. Хар цаас 3. Долгионт хавтан (шипр) 4. Бусад (тодруулна уу).....	
4.9	Байшингийн шалны үндсэн материал	1. Мод 2. Бетон 3. Бусад (тодруулна уу).....	
4.10	Танай байшинг хэн барьсан бэ?	1. Өөрсдөө буюу хамаатан, найзуудаараа барьсан 2. Барилгын мэргэжлийн компани барьсан 3. Барилгын мэргэжлийн бригад/хувь хүмүүс барьсан 4. Мэргэжлийн бус бригад/хувь хүмүүс барьсан 88. Мэдэхгүй	
4.11	Танай өрхөд байшин	1. Байгаа	

	барих туршлагатай хүн бий юу?	2. Байхгүй				
ДУЛААЛГА						
4.12	Та байшиндаа ямар нэгэн дулаалга хийсэн үү?	1. Хийсэн 2. Хийгээгүй (4.18 хүртэл алгасана уу)				
4.13	Дулаалгын материалыг яагаад худалдан авсан бэ? Олон сонголтот	1. Үнэ хямд учраас 2. Зах зээл дээр элбэг байдаг учраас 3. Найз нөхөд, танилууд, хөршүүд хэрэглэдэг учраас 4. Хэрэглэхэд хялбар учраас 5. Мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч, түүнийхээ дагуу өөрөө худалдан авалт хийсэн 6. Интернэт болон бусад хэвлэмэл материалаас судалж байгаад худалдан авалтаа хийсэн 7. Бусад (тодруулна уу).....				
4.14	Та дулаалгаа хэрхэн хийсэн бэ?	1. Өөрсдөө буюу хамаатан, найз нөхдийн хамт 2. Мэргэжлийн компани/ бригад баг хөлсөлсөн 3. Мэргэжлийн бус хүнээр хийлгэсэн 4. Бусад (тодруулна уу).....				
4.15	Таны хийсэн дулаалга хэр чанартай болсон бэ?	1. Маш сайн 2. Сайн 3. Дунд 4. Муу 5. Маш муу				
4.16	Таны хувьд байшингаа дулаалахад тулгараад байгаа хамгийн гол 2 хүртэлх бэрхшээлийг хэлж өгнө үү	1. Санхүүгийн бэрхшээл 2. Хүн хүчний дутмаг байдал 3. Мэдлэг, мэдээлэл байхгүй (хэрхэн хийхээ мэдэхгүй) 4. Ур чадваргүй 5. Цаг завгүй 6. Дулаалга хийх нь ач холбогдолгүй 7. Байшингийн үндсэн хийц муу 8. Бусад.....				
4.17	Байшингийнхаа дулаалгыг хийлгэхэд мэргэжлийн бригад хөлслөх сонирхол байгаа юу?	1. Маш их сонирхол байна 2. Сонирхол байна 3. Сонирхол байхгүй 4. Одоогоор хэлж мэдэхгүй байна				
ДУЛААНЫ АЛДАГДАЛ						
4.18	Танай байшингийн хаанаас дулаан алдаж байна вэ? Олон сонголтот	1. Дулаан алдсан газар байхгүй 2. Хананаас 3. Дээврээс 4. Шалнаас 5. Цонхноос 6. Хаалганаас 7. Булан тохой, уулзваруудаас 8. Бусад (тодруулна уу)..... 88. Мэдэхгүй				
4.19	Дулаан алдагдлыг бууруулах ямар арга хэмжээ авсан бэ?	#	Дулаалга хийсэн газрууд	Ашигласан материал 1=Шилэн хөвөн 2=Чулуун хөвөн 3=Эрдэс хөвөн 4=Хөөсөнцөр 5=Бусад	Зузааны хэмжээ (см)	Ашигласан дулаалгын материалыг хаанаас авсан 1=Үйлдвэрлэгчээс (дотоод, гадаад) 2=Жижиглэн худалдаанаас 3=Гадаадаас авч оруулж ирсэн

					4=Бусад (тодруулна уу)
		1	Хана		
		2	Дээвэр		
		3	Шал		
		4	Цонх		
		5	Хаалга		
		6	Булан тохой, уулзварууд		
		7	Бусад (тодруулна)		
		8	Огт дулаалага хийгээгүй		
ХАЛААЛТ					
4.20	Танайх ямар төрлийн зуухтай вэ? Олон сонголтот	1. Энгийн зуух 2. Төслийн зуух 3. Усан халаалтын зуух 4. Цахилгаан 5. Бусад (тодруулна уу).....			
4.21	Өвлийн улиралд хоногт хэдэн удаа галладаг вэ?	1.удаа			
4.22	Ямар төрлийн халаах хэрэгсэлтэй вэ?	1. Зуухны гадаргуу 2. Цахилгаан халаагуур (тень, бойлуур) 3. Радиатор (паар) 4. Ханан пийшин 5. Бусад.....			
ЦЭВЭР БА БОХИР УС					
4.23	Танай өрхийн ундны усны эх үүсвэр юу вэ?	1. Төвийн ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон 2. Ус түгээх байр 3. Зөөврийн усны үйлчилгээ 4. Хамгаалсан гүний худаг, булаг 5. Савласан ус 6. Бусад (тодруулна уу).....			
4.24	Танайх унд болон ахуйн хэрэглээндээ хоногт хэр их ус хэрэглэдэг вэ?	 литрийн саваар..... хоноод ус авдаг			
4.25	Танайх хаана усанд ордог вэ?	1. Гэртээ 2. Айлд 3. Нийтийн халуун усны газарт			
4.26	Танайх ахуйн бохир усаа яаж зайлуулдаг вэ?	1. Төвлөрсөн шугамаар 2. Соруулдаг бохир усны цооног руу 3. Бохир усны эсвэл жорлонгийн цооног руу (шингэдэг) 4. Ил задгай асгадаг 5. Бусад.....			
ЦААШДЫН ХҮСЭЛ СОНИРХОЛ					
4.27	Байр орон сууцны хувьд цаашид ямар төлөвлөгөөтэй байна вэ?	№	Төлөвлөөний төрлүүд	Төлөвлөж буй он	
	Харгалзах төлөвлөгөөг дугуйлж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх оныг нь бичнэ үү.	1	Орон сууц худалдаж авна		
		2	Энэ хашаа байшингаа зараад, өөр газар хашаа байшин худалдаж авна		
		3	Энэ хашаандаа шинээр байшин барина		
		4	Энэ байшингаа засаж,		

		өргөтгөнө	
		5 Бусад.....	
		99 Одоогоор төлөвлөсөн зүйл байхгүй	
4.28	Та дээрх төлөвлөгөөнийхөө санхүүжилтийг хэрхэн шийдэх вэ?	1. Бүх зардлыг өрхийн төсвөөр төлнө 2. Зардлын тодорхой хэсгийг өөрөө төлөөд, үлдсэнийг хүүхдүүд, хамаатаны тусламжтайгаар төлнө. 3. Зардлын тодорхой хэсгийг өөрөө төлөөд, үлдсэнийг зээлнэ. 4. Бүх зардлыг зээлнэ 5. Бусад (тодруулна)..... 88. Мэдэхгүй	
4.29	Хэрвээ танай өрхийн түлшний зардал багадаа 20 хувиар буурах боломжтой бол та дулаалганд мөнгө зарцуулах уу?	1. Зарцуулна. Өөрөө бүхэлд нь төлнө. 2. Зарцуулна. Тодорхой хэсгийг зээлээд, үлдсэнийг өөрөө төлнө. 3. Зарцуулахгүй (4.30-г алгасана уу) 88. Мэдэхгүй	
4.30	Хэрвээ хөрөнгө зарцуулах бол төлөх боломжит мөнгөн дүнгээ хэлж өгнө үү	1. 1,000,000 хүртэл 2. 1,000,001-2,000,000 3. 2,000,000-3,000,000 4. 3,000,000-1 төгрөгөөс дээш 88. Мэдэхгүй	
4.31	Танай өрхийн хувьд дулаан алдагдалаа бууруулахад нэн тэргүүнд ямар арга хэмжээ авах хэрэгцээтэй байна вэ? (2 хүртэлх сонголт)	1. Цахилгаан халаагуур тавих 2. Зуух, пийшингээ солих 3. Зуух, пийшингээ сайжруулах 4. Ханаа дулаалах 5. Дээврээ дулаалах 6. Шалаа дулаалах 7. Цонх сайжруулах, дулаалах 8. Цонх солих 9. Гонх барих 10. Бусад (тодруулна уу)..... 11. Байхгүй	
4.32	Та энэхүү нарны дулаан хуримтлуулдаг өргөтгөлийг байшиндаа нэмэлтээр барихыг сонирхож байна уу? (Верандагийн зураг үзүүлж, тайлбарлах)	1. Сонирхож байна. 2. Сонирхохгүй байна 88. Одоогоор хэлж мэдэхгүй байна	

Судалгаанд оролцсон таньд баярлалаа

Талбарын судлаачийн тэмдэглэгээ

#	Хийх ажил	Хийсэн эсэх
1	Байшингийн гадна талын зургийг нүүрэн талаас нь, аль болох байшинг бүтэн оруулж авна	1. Авсан 2. Аваагүй 88. Татгалзсан
2	Цонх ба ханын уулзварын зургийг ойроос	1. Авсан 2. Аваагүй 88. Татгалзсан

	авна	
3	Зуух, халаах хэрэгслийн зургийг авна	1. Авсан 2. Аваагүй 88. Татгалзсан
111	Энэ айл дулаалга хийлгэх сонирхолтой байв уу?	1. Маш их сонирхолтой 2. Сонирхолтой 3. Сонирхолгүй

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

БХБЯ. (2017). *Агаарын бохирдлыг бууруулах үндэсний чуулганы илтгэл.*

Зориг сан, Konrad Adenauer Stiftung. (2018). *Агаарын бохирдлын тухай товчхон.*

НЭМҮТ. (2017). *Баримтын цомог: Агаарын бохирдол-Хүний эрүүл мэндэд.*

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар. (2013). *Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа .*

